



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.03.18 № 3Г-1/18

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй дагалдуулан боловсруулсан бусад төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



[Signature]

Г.ЗАНДАНШАТАР

000264001197



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.18 № ХХ/890

танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт/150 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ


000265003989

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“14.ХЭЛЭЛЦСЭН нь: Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.03.18 № 01/1961
танай 2026.03.18-ны № 01/916 -т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн
төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20
дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу
Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч
байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000350



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.03.18 № 1/1342

танай 2026.03.18 ны № 01/217 -т

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Т.АУБАКИР ТАНАА**

Танаас ирүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

ХЗДХЯ-ны А5
152640511



ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2025 оны 01 сарын 07-ны өдөр

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ийн 2-т “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.” гэж, 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.1-д “нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 1.1-д “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн

д “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино.” гэж, 1.2-т “... тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна.” гэж тус тус заажээ. Энэхүү тогтоолын 2.1 дэх заалтад “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Түүнчлэн, “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 3.2.17-д “... иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд хувиараа болон ажил олгогчийн дэмжлэгтэйгээр даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах” гэж, 3.2.18-д “хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн гүйцэтгэх бөгөөд эрх бүхий байгууллага эдгээр санд тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд хяналт тавих” гэж, 3.2.19-д “даатгуулагчийн хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хуулиар зохицуулах” гэж, 3.2.21-д “хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын багцыг хянах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг зохицуулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг даатгуулагчийн дансанд шилжүүлэх асуудлыг хуулиар зохицуулах” гэж, 3.5.4-т “хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч болон даатгуулагчийн харилцан тохиролцсон гэрээгээр зохицуулах” гэж, 4.3.1-д “даатгуулагч төлсөн шимтгэлтэйгээ уялдаатай тэтгэвэр авах олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бий болгох” гэж, 4.3.6-д “... хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоо бүрдэж, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөл хангагдах” гэж тус тус заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд анх баталж, 1995 оноос мөрдөж эхэлснээр хөдөлмөрийн насны хүн ам нийгмийн даатгалын харилцаанд шимтгэл төлж оролцох, үүнд ажил олгогч, даатгуулагч болон төр тодорхой хэмжээгээр хамтран шимтгэл төлөх харилцааг зохицуулсан. Монгол Улсын Их Хурлаас 2023 онд Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус тус баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар тэтгэврийн даатгалын санд ажил олгогч цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 8.5 хувь, даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 8.5 хувиар, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч өөрөө мэдүүлсэн орлогоос 11.5 хувиар тус тус шимтгэл төлж байна.

Одоогийн мөрдөж буй нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд

даатгуулагч шимтгэл төлсөн жил, авч байсан цалин хөлстэйгөө уялдсан тэтгэвэр авах буюу нэг эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байна.

Манай улсын хүн амын дундаж наслалт 2024 онд 71.7 жил болж, 2000 оны дундаж наслалтаас 8.6 жилээр өссөн үзүүлэлттэй, харин эрэгтэйчүүдийн дундаж наслалт 7.5 жилээр нэмэгдэж 67.9 жил, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 11.0 жилээр нэмэгдэж 77.1 жил болж нэмэгдсэн байна. Энэ нь 0 наснаас тооцоолсон дундаж бөгөөд харин тэтгэврийн тогтолцоонд тэтгэврийн насанд хүрсэн хүний цаашид амьдрах хугацааг авч үздэг. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын хүн амын хэтийн тооцооллыг 2024 оны байдлаар эмэгтэй хүн 55 наснаас хойш 25 жил, эрэгтэй хүн 60 наснаас хойш 16 жил амьдарч байна гэж тооцсон. Ирээдүйд буюу 2050 онд уг хугацаа эмэгтэй хүний хувьд 28.4 жил, эрэгтэй хүний хувьд 19.6 жил болж өсөхөөр байна.

Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч 2024 онд 531.8 мянга байсан бол Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэхээр байна. Өөрөөр хэлбэл, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 хүн, 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байна.

Нийгмийн даатгалын сангаас 2024 онд 509.1 мянган хүн тэтгэвэр авч байгаагаас 414.3 мянга нь өндөр насны тэтгэвэр авч байгаа ба тэдний тэтгэвэрт 3.8 их наяд төгрөг олгосон байна. 2025 онд нийгмийн даатгалын бүрэн тэтгэврийн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянга, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 572.4 мянга, дундаж тэтгэврийн хэмжээ 850.0 мянган төгрөг байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүр нэмэгдүүлж байна.

Түүнчлэн шимтгэлд суурилсан нийгмийн даатгалын тогтолцоо бүрдэхээс өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн алба хаагчдын тэтгэвэр болон зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулиар олгох тэтгэврийн нэмэгдлийн зардлыг улсын төсвөөс хариуцаж байна. Эдгээр зардалд болон тэтгэврийн санд улсын төсвөөс нийтдээ 2022 онд 840 тэрбум төгрөг, 2023 онд 760 тэрбум, 2024 онд 1.2 их наяд төгрөг олгосон бол энэ зардал 2025 онд 1.45 их наяд төгрөг, 2030 онд 3.7, 2035 онд 5.7 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Монгол Улсад ажиллагсдын дундаж цалингийн хэмжээ 2025 оны II улиралд 2,727.8 мянган төгрөг байгаа бол өндөр насны бүрэн тэтгэврийн дундаж хэмжээ 893.9 мянган төгрөг байгаа нь дээрх дундаж цалингийн хэмжээтэй харьцуулахад 32.3 хувь болж байна.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцод зааснаар өндөр насны тэтгэвэр бодох хувь доод хувь хэмжээг дундаж цалингийн 40 хувиас багагүй байх ёстой гэж заасан¹.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар цалинд суурилсан аргаар тэтгэврийг даатгуулагч 20 ба түүнээс дээш жил шимтгэл төлсөн

¹ ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ, 2012 он, 346 дахь тал

бол 240 сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 45 хувиар бодож, 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож тэтгэврийг нэмэгдүүлж байна. Нийгмийн даатгалын сангаас 2025 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 60 орчим хувиар тогтоолгож байгаа тооцоолол байна.

Түүнчлэн, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд баримтлах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр, ажил олгогчийн тухайд ямар нэгэн хязгаарлалтгүй цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа бөгөөд 2024 оны байдлаар 96.5 мянган даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс их хэмжээний цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой байна.

Иймд ажил олгогчийг дэмжих, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг даатгуулагчтай ижил байх хязгаарыг тогтоох шаардлагатай байна.

Өндөр орлоготой иргэдийн зүгээс шимтгэл төлөх дээд хязгаараас давсан орлогоосоо нэмэлт шимтгэл төлөх замаар ирээдүйд авах тэтгэврийн хэмжээгээ өсгөх сонирхолтой байдаг. Түүнчлэн, дундаж орлоготой иргэдийн хувьд өрхийн орлого, цалингаа зөв зохистой зарцуулснаар хувийн нэмэлт тэтгэврийн санд хуримтлал үүсгэх боломжтой юм.

Тэтгэврийн даатгалын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг харуулсан дээрх тоо баримт, үндэслэлүүдээс харахад дан ганц улсын тэтгэврийн даатгалын сангаас олгож буй тэтгэврээр даатгуулагч ирээдүйн амьжиргааны зардлаа бүрэн хангах боломжгүй байна.

Цаашид ахмад настныг тэтгэврийн олон эх үүсвэр бүхий орлоготой байх нөхцөлийг хуулиар олгох, ирээдүйд авах тэтгэврийн хэмжээг өсгөх шаардлага зайлшгүй тулгарч байгаа тул хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

Олон улсын түвшинд ихэнх улс орнууд хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог улсын тэтгэврийн тогтолцооны нэмэлт байдлаар нэвтрүүлсэн байдаг ба хөрөнгийн зах зээлийн хамгийн том хөрөнгө оруулагч нь хувийн тэтгэврийн сангууд, даатгалын компаниуд байдаг байна. 2023 оны байдлаар дэлхийн хөрөнгө оруулагчдын нийт хөрөнгийн 46 хувь нь зөвхөн тэтгэврийн сангуудын хөрөнгө байна.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаагаар хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн 7 улсын туршлагыг нарийвчлан судалж үзэхэд хувийн тэтгэврийн нэмэлт хуримтлал бүрдүүлэх асуудлыг төрийн зүгээс дэмжих нь зүйтэй гэж үздэг байна. Тухайлбал, хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд татварын зохицуулалтыг тодорхой тусгаж, олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай юм.

Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүй ч, зарим байгууллагууд өөрсдийн ажиллагсдыг хамруулсан

хувийн тэтгэврийн сангуудыг үүсгэн байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, Голомт банкны үүсгэн байгуулсан Тэтгэврийн ууган сан ТББ, Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф даатгал ХХК урт хугацаат даатгалын компанийн тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүн зэргийг дурдаж болно. Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаа практикт бий болсон боловч тухайлсан хуулийн зохицуулалтгүй байгаа нь хувийн тэтгэврийн санд хамрагдаж мөнгөө төлсөн иргэд, ажилтны эрх ашиг зөрчигдөх, улмаар тухайн сан дампуурах тохиолдолд хэрхэх, эсхүл эрсдэлд орохоос хэрхэн сэргийлэх арга замууд тодорхойгүй байна. Мөн эдгээр сангуудад холбогдох төрийн байгууллагаас хуулийн дагуу зөвшөөрөл олгоогүй, тогтмол хяналт шалгалт хийдэггүй, засаглалын зохистой байдлыг хангасан эсэх нь тодорхой бус, үйл ажиллагаа, санхүүгийн тайлан мэдээлэл нь гишүүд, олон нийтэд ил тод бус зэрэг шийдвэрлэвэл зохих асуудлууд байна. Эдгээр харилцааг одоогийн нийгмийн даатгалын багц хуулиар зохицуулах боломжгүй тул бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Нэг талаас хүн амын насжилтаас үүдэлтэй дундаж наслалтын өсөлт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан зайлшгүй нэмэгдэж байгаа тэтгэврийн зардлыг хуваалцах, тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлэх, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн өмнө тавигдаж байгаа асуудал бол нөгөө талаас иргэд хөдөлмөрлөж, цалин орлоготой байх үедээ шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлал бүхий хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд сайн дураар хамрагдаж, ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасны дагуу анхдагч хуулийн хэлбэрээр дараах асуудлыг тусган боловсруулна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгагчийн болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, чиг үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох, маргаан шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгана.

Хуулийн төсөл нь 11 бүлэгтэй бөгөөд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт, хуулийн зорилт, хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр томьёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, нэмэлт тэтгэврийн гэрээ, шимтгэл төлөх, нэмэлт тэтгэврийн нэрийн данс, зардлын ангилал, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн эрх зэргийг тодорхойлно.

Гуравдугаар бүлэгт, хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулах, нэр, дүрэм, хувийн тэтгэврийн сангийн удирдлага, зохион байгуулалт, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхлэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох, бүртгэлээс хасах, дуусгавар болгох үед авах арга хэмжээ, татан буулгах комисс, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зар сурталчилгаа зэргийг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт хийхэд баримтлах зарчим, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын ангилал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, кастодиан, кастодианд хориглох зүйл, кастодианы үйл ажиллагаанд тавих хяналт, хөрөнгө оруулалтын менежментийн компани, хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах гэрээ, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах зэргийг тусгана.

Тавдугаар бүлэгт, гишүүн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох зэргийг тусгана.

Зургадугаар бүлэгт, нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл, эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх, нэмэлт тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг, нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, өргөдөл шийдвэрлэх хугацаа зэргийг тусгана.

Долдугаар бүлэгт, нягтлан бодох бүртгэл, аудит, актуарын тайлан, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаагаа тайлагнах зэргийг тусгана.

Наймдугаар бүлэгт, мэдээллийн нэгдсэн санг тодорхойлно.

Есдүгээр бүлэгт, итгэмжлэгдсэн өмчлөгч үүрэг зөрчих, хариуцлага хүлээлгэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалтыг тодорхойлно.

Аравдугаар бүлэгт, хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд оролцогч төрийн даатгалын байгууллагын чиг үүргийг тодорхойлно.

Арваннэгдүгээр бүлэгт, шилжилтийн үеийн зохицуулалт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах эерэг үр

дагаврууд бий болно:

- Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдэж, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болно;

- Санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны сан бий болох, санхүүгийн болон даатгалын салбарт шинээр ажлын байр бий болж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг хөшүүрэг болно;

- Хувийн тэтгэврийн сангууд бий болсноор эдийн засагт хөрөнгө оруулалтын урт хугацааны эх үүсвэр бий болж, хөрөнгийн зах зээлийг дэмжинэ;

- Хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төлбөрийн чадварыг хангах, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломж бүрдэнэ;

- Ажил олгогчийн хувийн нэмэлт тэтгэвэрт төлөх хураамж, шимтгэлд олон улсын жишгийн дагуу татварын бодлогыг хэрэгжүүлснээр ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зэрэг хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдах сонирхлыг нэмэгдүүлнэ;

- Хувийн тэтгэврийн сангууд бий болсноор ажил олгогчид ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх бол ажилтны хувьд нэг байгууллагад удаан хугацаанд тогтвортой, бүтээмжтэй ажиллах сонирхол бий болохын зэрэгцээ ирээдүйд авах тэтгэврийн хэмжээ нэмэгдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуультай нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг шаардлагатай хуулийн төслийг тус тус боловсруулна.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Хувийн нэмэлт тэтгэврийн
тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлж, хувийн нэмэлт тэтгэврийн хууль, эрх зүйн орчныг бий болгон ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Тухайлбал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ийн 2-т “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.” гэж, 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настанууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.” гэж, “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 1.2-т “... тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна.” гэж тус тус заасан.

Одоогийн мөрдөж буй нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагч шимтгэл төлсөн жил, авч байсан цалин хөлстэйгөө уялдсан тэтгэвэр авах буюу нэг эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байна.

Манай улсын хүн амын дундаж наслалт 2024 онд 71.7 жил болж, 2000 оны дундаж наслалтаас 8.6 жилээр өссөн үзүүлэлттэй, харин эрэгтэйчүүдийн дундаж наслалт 7.5 жилээр нэмэгдэж 67.9 жил, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 11.0 жилээр нэмэгдэж 77.1 жил болж нэмэгдсэн байна. Энэ нь 0 наснаас тооцоолсон дундаж бөгөөд харин тэтгэврийн тогтолцоонд тэтгэврийн насанд хүрсэн хүний цаашид амьдрах хугацааг авч үздэг. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын хүн амын хэтийн тооцооллыг 2024 оны байдлаар эмэгтэй хүн 55 наснаас хойш 25 жил, эрэгтэй хүн 60 наснаас хойш 16 жил амьдарч байна гэж тооцсон. Ирээдүйд буюу 2050 онд уг хугацаа эмэгтэй хүний хувьд 28.4 жил, эрэгтэй хүний хувьд 19.6 жил болж өсөхөөр байна.

Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч 2024 онд 531.8 мянга байсан бол Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэхээр байна. Өөрөөр хэлбэл, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 хүн, 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байна.

Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 524.7

мянган хүн тэтгэвэр авч байгаагаас 418.8 мянга нь өндөр насны тэтгэвэр авч байгаа ба тэдний тэтгэвэрт 2026 онд 4.9 их наяд төгрөг олгоно. 2026 онд нийгмийн даатгалын бүрэн тэтгэврийн тэтгэврийн доод хэмжээ 769.0 мянга, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 652.4 мянга, дундаж тэтгэврийн хэмжээ 930.2 мянган төгрөг байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүр нэмэгдүүлж байна.

Түүнчлэн, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд баримтлах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр, ажил олгогчийн тухайд ямар нэгэн хязгаарлалтгүй цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа бөгөөд 2024 оны байдлаар 96.5 мянган даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс их хэмжээний цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой байна.

Өндөр орлоготой иргэдийн зүгээс шимтгэл төлөх дээд хязгаараас давсан орлогоосоо нэмэлт шимтгэл төлөх замаар ирээдүйд авах тэтгэврийн хэмжээгээ өсгөх сонирхолтой байдаг. Түүнчлэн, дундаж орлоготой иргэдийн хувьд өрхийн орлого, цалингаа зөв зохистой зарцуулснаар хувийн нэмэлт тэтгэврийн санд хуримтлал үүсгэх боломжтой юм.

Тэтгэврийн даатгалын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудаас харахад дан ганц улсын тэтгэврийн даатгалын сангаас олгож буй тэтгэврээр даатгуулагч ирээдүйн амьжиргааны зардлаа бүрэн хангах боломжгүй байна.

Олон улсын түвшинд ихэнх улс орнууд хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог улсын тэтгэврийн тогтолцооны нэмэлт байдлаар нэвтрүүлсэн байдаг ба хөрөнгийн зах зээлийн хамгийн том хөрөнгө оруулагч нь хувийн тэтгэврийн сангууд, даатгалын компаниуд байдаг байна. 2023 оны байдлаар дэлхийн хөрөнгө оруулагчдын нийт хөрөнгийн 46 хувь нь зөвхөн тэтгэврийн сангуудын хөрөнгө байна. Мөн Олон улсын валютын сангаас 2025 онд хийсэн “Тэтгэврийн шинэчлэл ба хөрөнгийн зах зээлийн хөгжил” судалгаанаас харахад ДНБ-д эзлэх тэтгэврийн сангийн хөрөнгийн 1 хувийн өсөлт нь хөрөнгийн зах зээлийн өсөлтийг 1.9-2.1 хувиар нэмэгдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн сангийн хөрөнгө ДНБ-д эзлэх хувь нэмэгдэх тусам хөрөнгийн зах зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

Мөн манай улсад хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүй ч, зарим байгууллагууд өөрсдийн ажиллагсдыг хамруулсан хувийн тэтгэврийн сангуудыг үүсгэн байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, Голомт банкны үүсгэн байгуулсан Тэтгэврийн ууган сан ТББ, Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф даатгал ХХК урт хугацаат даатгалын компанийн тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүн зэргийг дурдаж болно. Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаа практикт бий болсон боловч тухайлсан хуулийн зохицуулалтгүй байгаа нь хувийн тэтгэврийн санд хамрагдаж мөнгөө төлсөн даатгуулагч, ажилтны эрх ашиг зөрчигдөх, улмаар тухайн сан дампуурах тохиолдолд хэрхэх, эсхүл эрсдэлд орохоос хэрхэн сэргийлэх арга замууд тодорхойгүй байна. Мөн эдгээр сангуудад холбогдох төрийн байгууллагаас хуулийн дагуу зөвшөөрөл олгоогүй, тогтмол хяналт шалгалт хийдэггүй, засаглалын зохистой байдлыг хангасан эсэх нь тодорхой бус, үйл ажиллагаа, санхүүгийн тайлан мэдээлэл нь гишүүд, олон нийтэд ил тод бус зэрэг шийдвэрлэвэл зохих асуудлууд

байна. Эдгээр харилцааг одоогийн нийгмийн даатгалын багц хуулиар зохицуулах боломжгүй тул бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Нэг талаас хүн амын насжилтаас үүдэлтэй дундаж наслалтын өсөлт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан зайлшгүй нэмэгдэж байгаа тэтгэврийн зардлыг хуваалцах, тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлэх, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн өмнө тавигдаж байгаа асуудал бол нөгөө талаас иргэд хөдөлмөрлөж, цалин орлоготой байх үедээ шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлал бүхий хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд сайн дураар хамрагдаж, ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсэж байна.

Түүнчлэн, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаагаар хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг нарийвчлан судалж үзэхэд хувийн тэтгэврийн нэмэлт хуримтлал бүрдүүлэх асуудлыг төрийн зүгээс дэмжих нь зүйтэй гэж үздэг байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Батлан хамгаалах яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын хөрөнгийн бирж, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын актуарчдын нийгэмлэг, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Голомт банкны дэргэдэх Тэтгэврийн ууган сан ТББ, Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф даатгал ХХК, Мандал лайф ХХК-ий төлөөлөл, бие даасан судлаач, актуар нарын төлөөллийг хамруулан байгуулж, хуулийн төслийг боловсруулж байна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо нь сайн дурын, шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх бөгөөд үйл ажиллагаа, засаглал нь ил тод байх, санхүүгийн бие даасан, найдвартай байх, өвлөгдөх зарчимд суурилна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгагчийн болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, чиг үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох, маргаан шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгана.

Хуулийн төсөл нь 11 бүлэгтэй бөгөөд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр томьёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, нэмэлт тэтгэврийн

гэрээ, шимтгэл төлөх, нэмэлт тэтгэврийн нэрийн данс, зардлын ангилал, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн эрх зэргийг тодорхойлно.

Гуравдугаар бүлэгт хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулах, нэр, дүрэм, хувийн тэтгэврийн сангийн удирдлага, зохион байгуулалт, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхлэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох, бүртгэлээс хасах, дуусгавар болгох үед авах арга хэмжээ, татан буулгах комисс, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зар сурталчилгаа зэргийг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт хийхэд баримтлах зарчим, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын ангилал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, кастодиан, кастодианд хориглох зүйл, кастодианы үйл ажиллагаанд тавих хяналт, хөрөнгө оруулалтын менежментийн компани, хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах гэрээ, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах зэргийг тусгана.

Тавдугаар бүлэгт гишүүн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох зэргийг тусгана.

Зургадугаар бүлэгт нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл, эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх, нэмэлт тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг, нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, өргөдөл шийдвэрлэх хугацаа зэргийг тусгана.

Долдугаар бүлэгт нягтлан бодох бүртгэл, аудит, актуарын тайлан, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаагаа тайлагнах зэргийг тусгана.

Наймдугаар бүлэгт мэдээллийн нэгдсэн санг тодорхойлно.

Есдүгээр бүлэгт, итгэмжлэгдсэн өмчлөгч үүрэг зөрчих, хариуцлага хүлээлгэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалтыг тодорхойлно.

Аравдугаар бүлэгт хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд оролцогч төрийн даатгалын байгууллагын чиг үүргийг тодорхойлно.

Арваннэгдүгээр бүлэгт шилжилтийн үеийн зохицуулалт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл батлагдсанаар урт хугацааны хөрөнгө оруулалтын сан бий болох, хөрөнгийн зах зээлд бодит хуримтлал үүсэж, зах зээлийг дэмжих бол иргэд хуримтлалд суурилсан олон эх үүсвэр бүхий

тэтгэврийн орлоготой болох, тэтгэвэр өвлөгдөх, ажил олгогчийн тухайд ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Үүнд:

- Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдэж, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болно;

- Санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны сан бий болох, санхүүгийн болон даатгалын салбарт шинээр ажлын байр бий болж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг хөшүүрэг болно;

- Хувийн тэтгэврийн сангууд бий болсноор эдийн засагт хөрөнгө оруулалтын урт хугацааны эх үүсвэр бий болж, хөрөнгийн зах зээлийг дэмжинэ;

- Хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төлбөрийн чадварыг хангах, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломж бүрдэнэ;

- Ажил олгогчийн хувийн нэмэлт тэтгэвэрт төлөх хураамж, шимтгэлд олон улсын жишгийн дагуу татварын бодлогыг хэрэгжүүлснээр ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зэрэг хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдах сонирхлыг нэмэгдүүлнэ;

- Хувийн тэтгэврийн сангууд бий болсноор ажил олгогчид ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх бол ажилтны хувьд нэг байгууллагад удаан хугацаанд тогтвортой, бүтээмжтэй ажиллах сонирхол бий болохын зэрэгцээ ирээдүйд авах тэтгэврийн хэмжээ нэмэгдэнэ.

--oOo--

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Хувийн нэмэлт тэтгэврийн
тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлж, хувийн нэмэлт тэтгэврийн хууль, эрх зүйн орчныг бий болгон ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Одоогийн мөрдөж буй нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагч шимтгэл төлсөн жил, авч байсан цалин хөлстэйгөө уялдсан тэтгэвэр авах буюу нэг эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байна.

Манай улсын хүн амын дундаж наслалт 2024 онд 71.7 жил болж, 2000 оны дундаж наслалтаас 8.6 жилээр өссөн үзүүлэлттэй, харин эрэгтэйчүүдийн дундаж наслалт 7.5 жилээр нэмэгдэж 67.9 жил, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 11.0 жилээр нэмэгдэж 77.1 жил болж нэмэгдсэн байна. Энэ нь 0 наснаас тооцоолсон дундаж бөгөөд харин тэтгэврийн тогтолцоонд тэтгэврийн насанд хүрсэн хүний цаашид амьдрах хугацааг авч үздэг. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын хүн амын хэтийн тооцооллыг 2024 оны байдлаар эмэгтэй хүн 55 наснаас хойш 25 жил, эрэгтэй хүн 60 наснаас хойш 16 жил амьдарч байна гэж тооцсон. Ирээдүйд буюу 2050 онд уг хугацаа эмэгтэй хүний хувьд 28.4 жил, эрэгтэй хүний хувьд 19.6 жил болж өсөхөөр байна.

Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч 2024 онд 531.8 мянга байсан бол Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэхээр байна. Өөрөөр хэлбэл, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 хүн, 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байна.

Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 524.7 мянган хүн тэтгэвэр авч байгаагаас 418.8 мянга нь өндөр насны тэтгэвэр авч байгаа ба тэдний тэтгэвэрт 2026 онд 4.9 их наяд төгрөг олгоно. 2026 онд нийгмийн даатгалын бүрэн тэтгэврийн тэтгэврийн доод хэмжээ 769.0 мянга, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 652.4 мянга, дундаж тэтгэврийн хэмжээ 930.2 мянган төгрөг байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүр нэмэгдүүлж байна.

Түүнчлэн, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд баримтлах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр, ажил олгогчийн тухайд ямар нэгэн хязгаарлалтгүй цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа бөгөөд 2024 оны байдлаар 96.5 мянган даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс их хэмжээний цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой байна.

Өндөр орлоготой иргэдийн зүгээс шимтгэл төлөх дээд хязгаараас давсан орлогоосоо нэмэлт шимтгэл төлөх замаар ирээдүйд авах тэтгэврийн хэмжээгээ өсгөх сонирхолтой байдаг. Түүнчлэн, дундаж орлоготой иргэдийн хувьд өрхийн орлого, цалингаа зөв зохистой зарцуулснаар хувийн нэмэлт тэтгэврийн санд хуримтлал үүсгэх боломжтой юм.

Тэтгэврийн даатгалын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудаас харахад дан ганц улсын тэтгэврийн даатгалын сангаас олгож буй тэтгэврээр даатгуулагч ирээдүйн амьжиргааны зардлаа бүрэн хангах боломжгүй байна.

Олон улсын түвшинд ихэнх улс орнууд хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог улсын тэтгэврийн тогтолцооны нэмэлт байдлаар нэвтрүүлсэн байдаг ба хөрөнгийн зах зээлийн хамгийн том хөрөнгө оруулагч нь хувийн тэтгэврийн сангууд, даатгалын компаниуд байдаг байна. 2023 оны байдлаар дэлхийн хөрөнгө оруулагчдын нийт хөрөнгийн 46 хувь нь зөвхөн тэтгэврийн сангуудын хөрөнгө байна. Мөн Олон улсын валютын сангаас 2025 онд хийсэн “Тэтгэврийн шинэчлэл ба хөрөнгийн зах зээлийн хөгжил” судалгаанаас харахад ДНБ-д эзлэх тэтгэврийн сангийн хөрөнгийн 1 хувийн өсөлт нь хөрөнгийн зах зээлийн өсөлтийг 1.9-2.1 хувиар нэмэгдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн сангийн хөрөнгө ДНБ-д эзлэх хувь нэмэгдэх тусам хөрөнгийн зах зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

Мөн манай улсад хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүй ч, зарим байгууллагууд өөрсдийн ажиллагсдыг хамруулсан хувийн тэтгэврийн сангуудыг үүсгэн байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаа практикт бий болсон боловч тухайлсан хуулийн зохицуулалтгүй байгаа нь хувийн тэтгэврийн санд хамрагдаж мөнгөө төлсөн даатгуулагч, ажилтны эрх ашиг зөрчигдөх, улмаар тухайн сан дампуурах тохиолдолд хэрхэх, эсхүл эрсдэлд орохоос хэрхэн сэргийлэх арга замууд тодорхойгүй байна. Мөн эдгээр сангуудад холбогдох төрийн байгууллагаас хуулийн дагуу зөвшөөрөл олгоогүй, тогтмол хяналт шалгалт хийдэггүй, засаглалын зохистой байдлыг хангасан эсэх нь тодорхой бус, үйл ажиллагаа, санхүүгийн тайлан мэдээлэл нь гишүүд, олон нийтэд ил тод бус зэрэг шийдвэрлэвэл зохих асуудлууд байна. Эдгээр харилцааг одоогийн нийгмийн даатгалын багц хуулиар зохицуулах боломжгүй тул бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Нэг талаас хүн амын насжилтаас үүдэлтэй дундаж наслалтын өсөлт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан зайлшгүй нэмэгдэж байгаа тэтгэврийн зардлыг хуваалцах, тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлэх, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн өмнө тавигдаж байгаа асуудал бол нөгөө талаас иргэд хөдөлмөрлөж, цалин орлоготой байх үедээ шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлал бүхий хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд сайн дураар хамрагдаж, ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсэж байна.

Түүнчлэн, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаагаар хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг нарийвчлан судалж үзэхэд хувийн тэтгэврийн нэмэлт хуримтлал бүрдүүлэх асуудлыг төрийн зүгээс дэмжих нь зүйтэй гэж үздэг байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Батлан хамгаалах яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын хөрөнгийн бирж, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын актуарчдын нийгэмлэг, Монголын

үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Голомт банкны дэргэдэх Тэтгэврийн ууган сан ТББ, Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф даатгал ХХК, Мандал лайф ХХК-ий төлөөлөл, бие даасан судлаач, актуар нарын төлөөллийг хамруулан байгуулж, хуулийн төслийг боловсруулж байна. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд ажлын хэсгийн гишүүн байгууллагуудаас санал авахаар 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1211 тоот албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн саналыг хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төслийг яамны цахим хуудсанд 25 оны 02 дугаар сарын 12-ы өдөр байршуулах болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан хэлэлцүүлсэн. Түүнчлэн, Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01/1446 дугаар албан бичгээр санал авч, саналыг тусгасан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо нь сайн дурын, шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх бөгөөд үйл ажиллагаа, засаглал нь ил тод байх, санхүүгийн бие даасан, найдвартай байх, өвлөгдөх зарчимд суурилна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгагчийн болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, чиг үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох, маргаан шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгана.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл батлагдсанаар урт хугацааны хөрөнгө оруулалтын сан бий болох, хөрөнгийн зах зээлд бодит хуримтлал үүсэж, зах зээлийг дэмжих бол иргэд хуримтлалд суурилсан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болох, тэтгэвэр өвлөгдөх, ажил олгогчийн тухайд ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хувийн нэмэлт тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, тэтгэвэр олгох, өвлүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, төрийн эрх бүхий байгууллагаас зохицуулах, хяналт тавих, гишүүний эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомж

2.1.Хувийн нэмэлт тэтгэврийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль³, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль⁴, Даатгалын тухай хууль⁵, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль⁶, Татварын ерөнхий хууль⁷, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль⁸, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль⁹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль¹⁰, Компанийн тухай хууль¹¹, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль¹², Хөдөлмөрийн тухай хууль¹³, Нийгмийн даатгалын ерөнхий хууль¹⁴, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль¹⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

³ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Даатгалын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Татварын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Компанийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

¹² Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

¹⁴ Нийгмийн даатгалын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

¹⁵ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч болон гишүүн, өвлөгч нарын хооронд үүсэх харилцааг энэ хууль болон Даатгалын тухай хууль, Иргэний хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.2.Ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хувийн нэмэлт тэтгэврийн шимтгэл төлөхтэй холбогдсон харилцааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

3.3.Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт, зохицуулалттай холбогдсон харилцааг энэ хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.4.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаатай холбогдсон кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг энэ хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар тус тус зохицуулна.

3.5.Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдох татварын харилцааг татварын хууль тогтоомжоор зохицуулна.

3.6.Энэ хууль Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасан даатгалын харилцаанд үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Хувийн нэмэлт тэтгэвэр (цаашид “нэмэлт тэтгэвэр” гэх)-ийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.сайн дурын байх;
- 4.1.2.шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх;
- 4.1.3.үйл ажиллагаа, засаглал ил тод байх;
- 4.1.4.санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх;
- 4.1.5.өвлөгддөг байх;
- 4.1.6.төрөөс тусдаа хувийн менежменттэй байх;
- 4.1.7.төр хуримтлал, өгөөжид баталгаа гаргах үүрэг хүлээхгүй байх.

4.2. Нийгмийн даатгалд албан журмаар, эсхүл сайн дураар даатгуулагч нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэж ажил олгогч, ажилтан хамтран шимтгэл төлж хамрагдах энэ хуулийн 5.1.3-т заасан үйлчилгээг;

5.1.2.“хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэж хувь хүн шимтгэл төлж хамрагдах энэ хуулийн 5.1.3-т заасан үйлчилгээг;

5.1.3.“хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүнд хувийн нэмэлт тэтгэвэр олгох зорилгоор хувь хүн, ажил олгогчтой тохиролцсоны дагуу тэдгээрт үзүүлэх үйлчилгээг;

5.1.4.“шимтгэл” гэж нэмэлт тэтгэвэр авах зорилгоор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гишүүний нэр дээр төлж, хуримтлуулсан мөнгөн хөрөнгийг;

5.1.5.“хувийн тэтгэврийн сан” гэж энэ хуулийн 5.1.3-т заасан үйлчилгээг эрхлэх этгээдийг;

5.1.6.“урт хугацааны даатгагч” гэж энэ хуулийн 5.1.3-т заасан үйлчилгээ эрхлэх урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанийг;

5.1.7.“гишүүн” гэж энэ хуулийн 6.2-т заасан хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан хүнийг;

5.1.8.“өвлөгч” гэж Иргэний хуулийн 520, 522 дугаар зүйлд заасан этгээдийг;

5.1.9.“хадгалагдсан эрх” гэж шилжүүлэх, барьцаалах, хурааж авах, хүчингүй болгох эрхгүй, гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгө эзэмших хөрөнгийг өмчлөх эрхийг;

5.1.10.“хувийн нэмэлт тэтгэвэр” гэж хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн дагуу гишүүнд олгох мөнгөн хөрөнгийг;

5.1.11.“нэмэлт тэтгэврийн хөрөнгө” гэж гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан нийт мөнгөн хөрөнгийг;

5.1.12.“нэмэлт тэтгэврийн журам” гэж шимтгэл төлөх, өгөөж тооцох, олгох, захиргааны болон хөрөнгө оруулалтын зардал, ангилал, хэмжээний мэдээлэл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, гишүүний эрх, үүрэг болон тэтгэвэр авах нөхцөл, болзлыг тодорхойлсон баримт бичгийг;

5.1.13.“нэмэлт тэтгэврийн нэрийн данс” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүний нэр дээр бүртгэсэн нийт шимтгэл, баталгаат өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөж, зарлагыг тусгасан мөнгөн хуримтлалын бүртгэлийг;

5.1.14.“баталгаат өгөөж” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансны нийт үлдэгдлийг гэрээнд заасан хугацаанд нэмэгдүүлэх хамгийн бага хувь, хэмжээг;

5.1.15.“итгэмжлэгдсэн өмчлөгч” гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, татан буулгах комиссыг;

5.1.16.“кастодиан” гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.12-т заасан хуулийн этгээдийг;

5.1.17.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.11-д заасан хуулийн этгээдийг;

5.1.18.“нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан иргэн, хуулийн этгээдийг;

5.1.19.“холбогдох этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д заасан этгээдийг;

5.1.20.“тохиромжтой этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 68.1-д заасан шалгуурыг хангасан этгээдийг;

5.1.21.“эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84.1-д заасан этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ХӨТӨЛБӨР, НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ГЭРЭЭ, ШИМТГЭЛ ТӨЛӨХ, НЭРИЙН ДАНС

6 дугаар зүйл.Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр

6.1.Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр (цаашид “нэмэлт тэтгэврийн хөтөлбөр” гэх) нь хугацаагүй байх бөгөөд гишүүн нэмэлт тэтгэвэр авахад зориулагдана.

6.2.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөр нь дараах төрөлтэй байна:

6.2.1.хувь хүний;

6.2.2.ажил олгогчийн.

6.3.Ажилтан, хувь хүн нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулснаар нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гишүүн болно.

6.4.Ажил олгогч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг ажилтанд санал болгож болно.

6.5.Ажил олгогч ажилтанд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг санал болгохдоо мэдээллийн ил тод байдлыг хангана.

6.6.Ажилтан, хувь хүн нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гишүүн болсноос хойш хуримтлал үүсгэж эхлэх хүртэл хугацаанд нэмэлт тэтгэврийн гэрээнээс татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

6.7.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдахаас татгалзсан ажилтан нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулах хүсэлт дахин гаргах эрхтэй.

7 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн гэрээ

7.1.Энэ хуулийн 6.3-т заасан нэмэлт тэтгэврийн гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

- 7.1.1.гишүүнээр элсэх нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн нөхцөл;
- 7.1.2 шимтгэлийн хувь, мөнгөн дүн, төлөх хугацаа;
- 7.1.3.өвлөгчийн тухай;
- 7.1.4.баталгаат өгөөж;
- 7.1.5.гишүүнд баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг олгох нөхцөл;
- 7.1.6.нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хадгалалт, удирдлагын талаар;
- 7.1.7.холбогдох мэдээллийг гишүүнд хүргэх хугацаа, арга хэлбэр;

7.1.8.нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, хөтөлбөрийг дуусгавар болгох нөхцөл;

7.1.9.гишүүн нэмэлт тэтгэврийн хөрөнгөөс зарцуулах үндэслэл, торгуулийн хувь хэмжээ;

7.1.10.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч болон бусад этгээдэд төлөх үйлчилгээний хураамжийн хэмжээ, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

7.2.Ажил олгогч нь ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг ажилтантай тохиролцон сонгож, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай холбогдох гэрээ байгуулна.

7.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь ажилтан, хувь хүнтэй нэмэлт тэтгэврийн гэрээг цаасаар эсхүл цахимаар, хугацаагүй байгуулах бөгөөд талуудын зөвшөөрөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн гэрээгээр хүлээсэн үүрэг нь гишүүн, өвлөгч нэмэлт тэтгэвэр авч дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

7.5.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан нь гишүүнд давуу байдал бий болгохоор бол гишүүн санал гаргасан эсэхээс үл хамааран гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсонд тооцно.

7.6. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж байсан гишүүн Монгол Улсын харьяатаас гарсан, эсхүл гадаадын иргэн Монгол Улсаас бүр мөсөн явах тохиолдолд нэмэлт тэтгэврийн гэрээг цуцалж, энэ хуулийн 11.1-д заасан нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг түүнд олгоно.

8 дугаар зүйл.Шимтгэл төлөх

8.1.Хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүн шимтгэлийг нэмэлт тэтгэврийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлнө.

8.2.Нэмэлт тэтгэврийн гэрээний дагуу хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүний төлөх шимтгэлийг хувь хүн, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүний төлөх шимтгэлийг ажил олгогч, ажилтан гэрээгээр харилцан тохиролцож хамтран төлнө.

8.3.Ажил олгогч, ажилтны төлөх шимтгэлийг цалин хөлсний тодорхой хувиар эсхүл, мөнгөн дүнгээр тооцно.

8.4.Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх нийт шимтгэлийн 50-аас доошгүй хувийг ажил олгогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө.

8.5.Ажил олгогч нь ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны төлөх шимтгэлийг тухайн ажилтны цалин хөлснөөс суутгаж, ажил олгогчоос төлөх шимтгэлийн хамт хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид тухайн сард нь багтааж бэлэн бусаар төлнө.

8.6.Ажил олгогч нь шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, ажилтанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.7.Ажил олгогч нь өөрийн болон ажилтны төлөх шимтгэлийг энэ хуулийн 8.5-д заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

8.8.Гишүүн, өвлөгч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь ажил олгогчоос төлөгдөөгүй шимтгэлийг төлүүлэхээр шүүхэд гомдол гаргах эрхтэй.

9 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн нэрийн данс

9.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах гэрээ байгуулснаас хойш ажлын гурван өдөрт багтаан гишүүн бүрд нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээж, дансны мэдээллийг цахим хэлбэрээр хянах боломжтой нэвтрэх эрх олгоно.

9.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн, ажил олгогчийн төлсөн шимтгэл, баталгаат өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд хөтөлбөрийн нөхцөлийн дагуу бүртгэнэ.

9.3.Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан гишүүний нэр дээр ажил олгогч, ажилтны төлсөн шимтгэлийг тус тусад нь бүртгэнэ.

9.4.Баталгаат өгөөжийн хэмжээг Төв банк (Монгол банк)-ны бодлогын хүү, инфляцын түвшин, Засгийн газрын дотоод үнэт цаасны хүү зэргийг харгалзан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч жил бүр өөрөө тогтооно.

9.5.Гишүүнд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч гишүүний нэрийн дансанд байгаа мөнгөн хөрөнгийг удирдаж, энэ хуулийн 9.4-т заасан баталгаат өгөөжийг гэрээнд заасны дагуу төлнө.

9.6.Ажил олгогч төлөөгүй шимтгэлийг төлсөн буюу хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлсэн өдрөөс хойш аливаа өгөөж бодогдоно.

9.7.Нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд төлсөн шимтгэлийг бүртгэх, гишүүнд мэдээлэх аргачлалыг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батална.

10 дугаар зүйл.Зардлын ангилал

10.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг захиргааны болон хөрөнгө оруулалтын гэж ангилна.

10.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь захиргааны болон хөрөнгө оруулалтын зардал, ангилал, хэмжээ зэрэг мэдээллийг нэмэлт тэтгэврийн журамд тусгана.

11 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн эрх

11.1.Нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө нь тухайн хуримтлал үүсгэсэн гишүүний өмч байна.

11.2.Гишүүнд нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээгээр хадгалагдсан эрх үүснэ.

11.3.Дараах тохиолдолд гишүүн, өвлөгч энэ хуулийн 11.1-д заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх үүснэ:

11.3.1.гишүүн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн;

11.3.2.гишүүн хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан /цаашид "хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан" гэх/;

11.3.3.гишүүн нас барсан тохиолдолд өвлөгчид;

11.3.4.энэ хуулийн 7.6, 11.5 дахь хэсэгт заасан тохиолдолд.

11.4.Гишүүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл тогтооно.

11.5.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид 10 ба түүнээс дээш жил хамрагдсан гишүүн энэ хуулийн 11.3-т заасан эрх үүсэхээс өмнө нэмэлт тэтгэврийн хөрөнгийн 30 хүртэл хувийг энэ хуулийн 11.6-т заасан нөхцөлөөр зарцуулах хүсэлтийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид нэг удаа гаргаж болно.

11.6.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 11.5-д заасан хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэж, зардал, төлбөрийг тухайн эрүүл мэнд, боловсролын байгууллага, орон сууц худалдагчийн дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

11.7.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөрөнгөөс дараах зардлыг төлүүлэхээр хүсэлт гаргаж болно:

11.7.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцахгүй, даатгуулагч өөрөө хариуцан төлөх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт;

11.7.2.Монгол Улсад дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн тухайн жилийн сургалтын төлбөрийг бүрэн төлөхөөр бол дээд боловсролын сургалтын төлбөрт;

11.7.3.орон сууц худалдан авах зориулалтаар.

11.8.Энэ хуулийн 11.7-д заасан гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулах хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, шилжүүлэх, бүртгэх, тайлагнах журмыг Хороо батална.

11.9.Гишүүн, ажил олгогч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн болон бусад этгээдийн эсрэг үүссэн шаардах эрхийг хангах зорилгоор гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгийг барьцаалах, битүүмжлэх, суутган авах, шилжүүлэх болон бусад байдлаар захиран зарцуулахгүй.

11.10.Нэмэлт тэтгэврийн нэрийн данс дахь нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь гишүүн, ажил олгогч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон бусад этгээдтэй холбоотой аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл, дампуурлын хэрэг, эвлэрэл, түүнтэй адилтгах бусад ажиллагаанд хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН, УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧ

12 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулах, нэр, дүрэм

12.1.Хувийн тэтгэврийн сан нь Компанийн тухай хуулийн дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

12.2.Хувийн тэтгэврийн санг Компанийн тухай хуульд заасан хэд хэдэн хуулийн этгээд хувь нийлүүлэн үүсгэн байгуулах бөгөөд нэг үүсгэн байгуулагчийн эзэмших хувь 20 хувиас ихгүй байна.

12.3.Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулагч Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

12.3.1.санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнадаг байх;

12.3.2.санхүүгийн тайланг Монгол Улсад аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулдаг байх;

12.3.3.хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн санхүүгийн тайлангаар тодорхойлогдсон, хууль ёсны хөрөнгө байх;

12.3.4.хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлээгүй байх;

12.3.5.хувь нийлүүлсэн хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд байршуулсан байх;

12.3.6.зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчээр бүртгэгдэж байгаагүй;

12.3.7. татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй байх.

12.4. Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 15 тэрбум төгрөг байна. Энэхүү хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, хувийн тэтгэврийн санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг харгалзан Хороо тухай бүрд нэмэгдүүлэн тогтооно.

12.5. Энэ хуулийн 12.1-д заасан этгээд нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаанаас өөр чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

12.6. Хувийн тэтгэврийн сангийн нэр нь түүний оноосон нэр болон “Хувийн тэтгэврийн сан” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, “ХТС” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

12.7. Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад этгээд хувийн тэтгэврийн сангийн дэлгэрэнгүй болон товчилсон тэмдэглэгээг хэрэглэхийг хориглоно.

12.8. Хувийн тэтгэврийн сангийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

- 12.8.1. хувийн тэтгэврийн сан хугацаагүй үүсгэн байгуулагдсан тухай;
- 12.8.2. удирдлага, зохион байгуулалтын бүтэц;
- 12.8.3. хөрөнгө оруулалтын өгөөж баталгаат өгөөжөөс бага бол үүсгэн байгуулагч өөрийн хөрөнгөөс нөхөж олгохтой холбогдсон зохицуулалт.

12.9. Хувийн тэтгэврийн сан дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

- 12.9.1. нэмэлт тэтгэврийн хөтөлбөр боловсруулж, Хороонд бүртгүүлэх;
- 12.9.2. нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг олон нийтэд эрх тэгш санал болгож нэмэлт тэтгэврийн журмыг нээлттэй, ил тод байршуулах;
- 12.9.3. нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулах, шимтгэл хүлээн авах;
- 12.9.4. нэмэлт тэтгэврийн нэрийн данс хөтлөх;
- 12.9.5. нэмэлт тэтгэврийн хөрөнгийг удирдах хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээ байгуулах;
- 12.9.6. нэмэлт тэтгэврийн нэрийн данс, хөрөнгийг бүртгэх, хадгалах кастодиантай гэрээ байгуулах;
- 12.9.7. нэмэлт тэтгэвэр олгох;
- 12.9.8. үйл ажиллагааг эрх бүхий байгууллага, гишүүдэд ил тод тайлагнах;
- 12.9.9. нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагааг Хороо болон гишүүдэд ил тод тайлагнах;
- 12.9.10. гишүүний эрх ашгийг хамгаалах, сангийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах хороонд Хорооноос тогтоосон бусад шаардлага.

13 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сангийн удирдлага, зохион байгуулалт

13.1.Хувийн тэтгэврийн сан төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.

13.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн олонх нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хараат бус гишүүн байна.

13.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг сонгох, томилох, бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг энэ хууль болон Компанийн тухай хууль, хувийн тэтгэврийн сангийн дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

13.4.Хувийн тэтгэврийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод аудитын хороотой байх бөгөөд уг хорооны дарга нь удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

13.5.Энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүний төлөөлөл төлөөлөн удирдах зөвлөлийн гуравны нэгээс доошгүй хувь байх бөгөөд олонхын саналыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгоно.

13.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан эрх, үүргийг эдэлнэ.

13.7.Хувийн тэтгэврийн сангийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

13.7.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

13.7.2.эдийн засгийн гэмт хэрэгт холбогдоогүй, ял шийтгэлгүй байх;

13.7.3.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд харшлахгүй байх;

13.7.4.санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийг удирдаж байсан бөгөөд өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн хуулийн этгээдийг дампууруулаагүй байх;

13.7.5.энэ хуулийн 13.4-т зааснаас бусад төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, мэдээллийн технологийн чиглэлээр дээд боловсролтой, уг мэргэжлээр 3-аас доошгүй жил ажилласан байх;

13.7.6.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.

13.8.Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхтэй байна:

13.8.1.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианыг сонгох;

13.8.2.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, нягтлан бодох, аудит, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч болон хувийн тэтгэврийн санд үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдтэй гэрээ байгуулах зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгох;

13.8.3.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, бусад үйлчилгээ үзүүлэгчээс хувийн тэтгэврийн сангийн нэрийн өмнөөс хийсэн бүх хэлцэл болон хувийн тэтгэврийн сангийн эзэмшиж байгаа хувьцааны санал өгөх эрхийг хэрэгжүүлсэнтэй холбогдох мэдээлэлтэй танилцах, хяналт тавих;

13.8.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах;

13.8.5.хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, хувийн тэтгэврийн санд үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдийн үйлчилгээг дуусгавар болгох, өөрчлөх;

13.8.6.гүйцэтгэх удирдлагын бүтцийг батлах, томилох, цалин хөлс олгох журмыг батлах;

13.8.7.нэмэлт тэтгэврийн журам батлах;

13.8.8.хувийн тэтгэврийн сан, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох.

14 дүгээр зүйл.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

14.1.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Хороо хэрэгжүүлнэ.

14.2.Зөвшөөрөл хүсэгч хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг дараах баримт бичгийн хамт Хороонд цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

14.2.1.хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, хувийн тэтгэврийн сангийн дүрэм;

14.2.2.хувийн тэтгэврийн сангийн холбогдох этгээд, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;

14.2.3.хувийн тэтгэврийн сангийн Удирдах зөвлөлийн гишүүд, тэдгээрийн холбогдох этгээдийн мэдээлэл;

14.2.4.Удирдах зөвлөлийн гишүүдээс итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүрэг гүйцэтгэхээ хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл;

14.2.5.хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө;

14.2.6.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлого;

14.2.7.хуульд заасан бусад.

14.3.Энэ хуулийн 14.2.2, 14.2.3-т заасан мэдээлэлд өөрчлөлт орох бүрд Хороонд ажлын 5 өдрийн дотор мэдэгдэж, энэ хуульд заасан шаардлагыг биелүүлнэ.

14.4.Хороо нь энэ хуулийн 14.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг ирүүлэхийг шаардах, тодруулга, тайлбар авах эрхтэй.

14.5.Хороо зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн хүсэлт болон бусад баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор хянаж, Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан гэж үзвэл тусгай зөвшөөрөл олгох, эсхүл татгалзсан үндэслэл бүхий шийдвэрийн аль нэгийг гаргах бөгөөд хугацааг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс эхлэн тооцно.

14.6. Хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх хэсэгт заасан хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

14.7.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо батална.

14.8.Хороо дараах тохиолдолд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

14.8.1.бүрдүүлсэн баримт бичиг нь энэ хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангаагүй;

14.8.2.бүрдүүлсэн баримт бичигт гишүүн, өвлөгчийн ашиг сонирхлыг зөрчих зохицуулалтыг тусгасан, эсхүл ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг тусгаагүй.

14.9.Хороо энэ хуулийн 14.8-д заасны дагуу хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг тусгасан хариуг зөвшөөрөл хүсэгчид Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр хүргүүлнэ.

15 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

15.1.Хороо дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

15.1.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн;

15.1.2.баталгаат өгөөж, эсхүл гэрээгээр тохирсон баталгаат өгөөжөөс давсан дүнг төлөөгүй;

15.1.3.хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл худал мэдүүлж тайлагнасан;

15.1.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй нь тогтоогдсон;

15.1.5.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

15.1.6.зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.

15.1.7.татварын хууль тогтоомжид заасан тайлан тушаах, татвар төлөх үүргээ хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй тухай холбогдох байгууллагын дүгнэлт.

15.2.Хороо энэ хуулийн 15.1-д заасан үндэслэл байгаа тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш тусгай зөвшөөрөл эзэмшигч ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

15.4.Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 2 өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

15.5.Энэ хуулийн 15.1-д заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сангийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээж, тухайн шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэж, мэдэгдсэн огноог тэмдэглэнэ.

16 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

16.1.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

16.1.1.хувийн тэтгэврийн сангийн Удирдах зөвлөл уг сангийн үйл ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлтийг энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүн болон Хороонд ажлын 90 өдрийн өмнө бичгээр, эсхүл цахимаар хүргүүлсэн;

16.1.2.нэмэлт тэтгэврийн бүх хөтөлбөр Хорооны бүртгэлээс хасагдсан;

16.1.3.энэ хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн;

16.1.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй.

16.1.5.Компанийн тухай хуулийн 31.3-д заасан нөхцөл байдал тогтоогдсоноос хойш 90 хоногийн дотор дахин хөрөнгөжүүлээгүй;

16.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

16.1.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч дампуурсан, эсхүл татан буугдсан;

16.2.Хороо зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгаа тухай хувийн тэтгэврийн санд ажлын 5 өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

16.3.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 16.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлээгүй, гомдол гаргаагүй, ирүүлсэн тайлбар баримт бичиг шаардлага хангаагүй бол уг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор Хороо зөвшөөрлийг хүчингүй болгоно.

16.4.Хороо энэ хуулийн 16.3-т хэсэгт заасан шийдвэрийг хувийн тэтгэврийн сан, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, харьяалах татварын албанд ажлын 1 өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

16.5.Тусгай зөвшөөрөлгүй этгээд нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа эрхлэх, сурталчлахыг хориглоно.

16.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч Хороонд бүртгүүлээгүй нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт гишүүн элсүүлэх, шимтгэл цуглуулах, нэмэлт тэтгэвэр амлах, олгох, сурталчлахыг хориглоно.

17 дугаар зүйл.Урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр

17.1.Урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлж болно.

17.2.Урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 17.1-д заасан үйл ажиллагааг энэ хууль, Даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу эрхэлнэ.

17.3.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрд нэмэлт тэтгэврийн журам батална.

17.4.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрийн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг бусад хөрөнгөөс тусгаарлаж, тусдаа дансанд байршуулж, бүртгэнэ.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасан хөрөнгийг урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас бусад байдлаар болон хөтөлбөрт холбогдохгүй өр төлбөрийг барагдуулахад зарцуулах, батлан даалт гаргах, барьцаалахыг хориглоно.

17.6.Урт хугацааны даатгагч энэ хуулийн 17.4-т заасан хөрөнгийг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж гишүүн, өвлөгчийн эрх ашгийг хамгаална.

17.7.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг олон нийтэд эрх тэгш санал болгож, нэмэлт тэтгэврийн журмыг нээлттэй, ил тод байршуулна.

17.8.Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлого батална.

18 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх

18.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх тухай хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Хороонд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ:

18.1.1.энэ хуулийн 5.1.13-т заасан нэмэлт тэтгэврийн журам;

18.1.2.кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулсан гэрээ;

18.1.3.гишүүнтэй байгуулах нэмэлт тэтгэврийн гэрээний загвар.

18.2.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх тухай хүсэлт, баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор хянан шийдвэрлэж, шийдвэрийг ажлын 5 өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид бичгээр хүргүүлнэ.

18.3.Хороо дор дурдсан тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэхээс татгалзана:

18.3.1.хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичигт худал, төөрөгдүүлсэн, алдаатай, дутуу, зөрүүтэй мэдээлэл тусгасан эсхүл хууль болон Хорооноос тогтоосон шаардлагатай мэдээллийг тусгаагүй;

18.3.2.шаардлагатай нэмэлт мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй;

18.3.3.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж Хороо үзсэн.

19 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түр зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах

19.1.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ:

19.1.1.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

19.1.2.энэ хуульд заасан зар сурталчилгааны шаардлагыг зөрчсөн, худал төөрөгдүүлсэн зар сурталчилгаа түгээсэн;

19.1.3.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил гаргасан нь тогтоогдсон;

19.1.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 5 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

19.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

19.4.Хороо тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын 5 өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлнэ.

19.5.Хороо үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг нэг сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, хөтөлбөрийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 2 өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

19.6.Энэ хуулийн 19.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хүсэлтийг үндэслэн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг сэргээнэ.

19.7.Энэ хуулийн 19.1-д заасан шаардлагыг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хасна.

19.8.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах журмыг Хороо батална.

20 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох, бүртгэлээс хасах дуусгавар болгох үед авах арга хэмжээ

20.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан, дуусгавар болгосон мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн элсүүлэхийг хориглоно.

20.2.Хороо энэ хуулийн 20.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг даруй зогсооно.

20.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох шийдвэр гаргасан бол дараах арга хэмжээг авна:

20.3.1.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөтөлбөрийг дуусгавар болгох тухай мэдэгдэл өгснөөс хойш ажлын 30 өдрийн дотор нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн санхүүгийн тайланг Хороонд хүргүүлж, бүх гишүүдэд мэдэгдэх;

20.3.2.гишүүний хадгалагдсан эрхийн төлбөрийг барагдуулах хөрөнгө хангалттай тохиолдолд нэмэлт тэтгэврийн бусад хөтөлбөрт шилжих боломжийг гишүүнд олгох;

20.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөрөнгөнд аудит, актуарын тайлан, дүгнэлт гаргуулах, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр үнэлгээ хийлгүүлэх;

20.3.4. гишүүдийн хадгалагдсан эрхийн төлбөрийг барагдуулах хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч өөрийн хөрөнгөөр барагдуулах тухай хүсэлтийг санхүүгийн тайлангийн хамт Хороонд хүргүүлж, энэ тухай гишүүнд мэдэгдэх;

20.3.5. татан буулгах шийдвэрт ажил олгогчоос төлөгдөөгүй шимтгэлийг энэ хуульд заасны дагуу татан төвлөрүүлэхэд авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээний дэлгэрэнгүй тайланг тусгасан байх;

20.3.6. Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зарим үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

20.3.7. нийгмийн даатгалын болон татварын өр төлбөрийг бүрэн барагдуулсан байх;

20.4. Энэ хуулийн 20.3.6-д заасан үйл ажиллагаа татан буулгах явц бүрэн дуусах хүртэл эсхүл актив, пассив нь бусад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжих хүртэл үргэлжилнэ.

20.5. Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 20.3-д заасан арга хэмжээг авна.

20.6. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хассан тохиолдолд энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20.7. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг Хороо батална.

21 дүгээр зүйл. Татан буулгах комисс

21.1. Хороо хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хассан тохиолдолд татан буулгах комисс томилно.

21.2. Энэ хуулийн 21.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд дараах этгээдийг томилохгүй:

21.2.1. хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн удирдах зөвлөлийн гишүүн, бусад эрх бүхий албан тушаалтан;

21.2.2. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан.

21.3. Татан буулгах комисс нь гишүүн, өвлөгчийн өмнө хариуцлага хүлээсэн итгэмжлэгдсэн өмчлөгч байна.

21.4. Татан буулгах комисс, хувийн тэтгэврийн сан Хорооноос урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн актив, пассивыг бусад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлж болно.

21.5.Энэ хуулийн 21.4-т заасан тохиолдолд гишүүдэд 30 хоногийн өмнө мэдэгдлийг бичгээр болон цахимаар хүргүүлж биечлэн уулзалт зохион байгуулж саналыг авна.

21.6.Татан буулгах комисс өр төлбөрийг барагдуулахдаа дараах дарааллыг баримтална:

21.6.1. татан буулгах комиссын үйл ажиллагааны зардал;

21.6.2. гишүүдэд олгох бүх өр төлбөр;

21.6.3.хувийн тэтгэврийн сангийн эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтны хуульд заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс, төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэл;

21.6.4. албан татвар;

21.6.5.кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээний төлбөр;.

21.7.Энэ хуулийн 21.6-д заасан өр төлбөрийг бүрэн барагдуулсны дараа хувийн тэтгэврийн сан, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хөрөнгө үлдсэн бол татан буулгах комисс хөрөнгө хуваарилах төлөвлөгөө боловсруулж, Хороонд батлуулахаар хүргүүлнэ.

21.8.Гишүүн, өвлөгч нь буруутай үйл ажиллагаа явуулсан гэж үзсэн бол татан буулгах комисс, хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, тэдгээрийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эсрэг нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй.

21.9.Татан буулгах комиссын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах, өр төлбөр барагдуулах, урамшуулах, бусад харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

21.10.Урт хугацааны даатгагчийг татан буулгахтай холбогдсон харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хассан тохиолдолд энэ хуулийн дагуу зохицуулна.

21.11.Хувийн тэтгэврийн санг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

22 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зар сурталчилгаа

22.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг олон нийтэд үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр сурталчилна.

22.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүнд зориулан санхүүгийн боловсрол олгох сургалт, мэдээллийг жилд нэг удаа цахим болон биечилсэн хэлбэрээр зохион байгуулна.

22.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь Хорооноос тусгай зөвшөөрөл аваагүй, хороонд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөө бүртгүүлээгүй тохиолдолд “хувийн тэтгэврийн сан”, “нэмэлт тэтгэвэр”, “хувийн тэтгэвэр” гэсэн

агуулга бүхий үг хэллэг, эсхүл ижил төстэй бүтээгдэхүүнийг зах зээлд олон нийтэд санал болгох, сурталчлахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, КАСТОДИАН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ

23 дугаар зүйл.Хөрөнгө оруулалт хийх

23.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу хөрөнгө оруулалт хийнэ.

23.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөрөнгө оруулалт болон бусад асуудлаас үүдэлтэй алдагдлыг өөрийн хөрөнгөөр хариуцаж, гишүүн, өвлөгчийн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хамгаална.

23.3.Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр энэ хуулийн 24.1-д заасан зарчмыг баримтлан Хорооноос баталсан журмын дагуу хөрөнгө оруулна.

23.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалтад тавих нийтлэг шаардлага, зохистой харьцаа, эрсдэлийн удирдлага, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмыг Хороо батална.

23.5.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, дотоод хяналтын бие даасан нэгжтэй байна.

24 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалт хийхэд баримтлах зарчим

24.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хөрөнгө оруулалт хийхэд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 13.1-т зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

- 24.1.1.хөрөнгийн аюулгүй байдлыг хангах;
- 24.1.2.хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх,
- 24.1.3.боломжит өгөөж, ашгийн дээд хэмжээг эрэлхийлэх;
- 24.1.4.хөрөнгө оруулалтын багцын зохистой харьцааг хангах.

25 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг

25.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 24.1-д заасан зарчим, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дараах агуулгыг тусгасан хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг боловсруулна:

25.1.1.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангах хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл;

25.1.2.энэ хуулийн 26.1-д заасан хөрөнгийн ангилал бүрд болон нэг этгээд, эсхүл хэд хэдэн этгээдэд хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар;

- 25.1.3.хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах журам;
- 25.1.4.хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах журам;
- 25.1.5.хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах аргачлал.

25.2.Хорооноос тогтоосон журмын дагуу хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөрөнгө оруулалтын бодлого болон эрсдэлийн удирдлагын бодлогыг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж байгаа гишүүнд танилцуулна. Бодлогод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Хороо болон гишүүнд тухай бүрд мэдэгдэнэ.

25.3.Хороо хөрөнгө оруулалттай холбоотой зөрчил илэрсэн өдөр, хөрөнгө оруулалтын ангилал бүрд хөрөнгийн үнэлгээ хийж тухайн зөрчил илэрснийг тогтоосон өдрөөс хойш гурван сар хүртэл хугацааны дотор энэ хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулна.

26 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын ангилал

26.1. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг энэ хуулийн 24.1-т заасныг баримтлан эрсдэлгүй, эсхүл бага эрдэлтэй дараах санхүүгийн хэрэглэлүүдэд хөрөнгө оруулна:

26.1.1.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.5, 26.1.7, 26.1.8, 26.1.13-т заасан санхүүгийн хэрэгсэл;

26.1.2.Эрсдэлийг удирдах зорилгоор Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.9, 26.1.10-т заасан санхүүгийн хэрэгсэл.

26.2.Хороо нэг үнэт цаас гаргагч, түүний холбогдох хуулийн этгээд болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн нийт гаргасан үнэт цаас, банкны хадгаламж, хадгаламжийн сертификатад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн эзэмшиж болох дээд хязгаарыг тогтооно.

26.3.Энэ хуулийн 26.1-д зааснаас бусад санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

26.4.Нэмэлт тэтгэврийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөөр зээл, барьцаа, баталгаа, батлан даалт гаргахыг хориглоно.

27 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

27.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь дараах этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлана:

27.1.1.тухайн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч болон тэдгээрийн толгой, охин, хараат, зэргэлдээ компани;

27.1.2.тухайн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн холбогдох этгээдийн дангаар, эсхүл хамтдаа эзэмших хувьцааны хяналтын багц эзэмшдэг компани, хөрөнгө оруулалтын сан болон хуулийн этгээд;

27.1.3.тухайн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн холбогдох этгээдийн дангаар,

эсхүл хамтдаа эзэмших хувьцааны хяналтын багц эзэмшдэг компани, хөрөнгө оруулалтын сан болон хуулийн этгээд.

27.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шууд үйлчилгээ үзүүлэх кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн холбогдох этгээд байхыг хориглоно.

27.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани нь сонирхлын зөрчил бүхий гэрээ, хэлцлийг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу байгуулна.

28 дугаар зүйл.Кастодиан

28.1.Кастодиан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

28.1.1.нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулсан үнэт цаас, хадгаламжийн сертификатыг хадгалах, гүйлгээг бүртгэх;

28.1.2.нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид цахим, эсхүл цаасан хэлбэрээр өгөх;

28.1.3.нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой хийсэн гэрээ, хэлцэл нь энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын бодлогод нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

28.1.4.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас өгсөн үүрэг даалгаврыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын бодлого болон гэрээнд нийцүүлэн биелүүлэх;

28.1.5.нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын бодлогод нийцүүлэн хөрөнгө оруулалт хийсэн эсэхэд хяналт тавих, зөрчил гарсан тохиолдолд Хороо, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэх;

28.1.6.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

28.1.7.кастодианы гэрээнд заасан үүрэг болон Хорооноос баталсан бусад дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.

28.2.Кастодиан нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50.1-д заасны дагуу гэрээ байгуулна

28.3.Гэрээ байгуулсан кастодиан энэ хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг эдлэх бөгөөд энэ хуульд заасан итгэмжлэгдсэн өмчлөгч байна.

28.4.Кастодиан нь нэгээс дээш тооны хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид үйлчилгээ үзүүлж болно. Энэ тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө, үйл ажиллагаа, бүртгэл мэдээллийг тус тусад нь бүртгэнэ.

28.5.Кастодиан нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээд байна.

28.6.Кастодиантай байгуулсан гэрээгээр энэ хуульд заасан кастодианы үүрэг хариуцлагыг хязгаарлахыг хориглоно.

28.7.Кастодиан нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, гишүүн, өвлөгчийн өмнө хүлээсэн өөрийн итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргийг зөрчвөл энэ хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

28.8.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг кастодианы хөрөнгөөс тусгаарласан байна.

29 дүгээр зүйл.Кастодианд хориглох зүйл

29.1.Кастодиан нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхлэхэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

29.1.1.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээ үзүүлэх;

29.1.2.хөрөнгө оруулалтын менежментийн компани, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, тэдгээрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох этгээд байх;

29.1.3.хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний холбогдох этгээд, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд тухайн ажил олгогчид зээл олгох, зээл авах.

29.2.Кастодианы холбогдох этгээдэд энэ хуулийн 29.1.1 дэх заалт мөн адил хамаарна.

30 дугаар зүйл.Кастодианы үйл ажиллагаанд тавих хяналт

30.1.Эрх бүхий байгууллагаас кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, кастодиан гэрээний үүргийг зөрчсөн дампуурсан эсхүл татан буугдсан бол хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч дараах арга хэмжээг авна:

30.1.1.кастодианд гэрээ цуцлах тухай мэдэгдлийг ажлын 2 өдрийн дотор хүргүүлж Хороонд энэ тухай мэдэгдэх;

30.1.2.шинэ кастодианыг ажлын 2 өдрийн дотор томилох.

30.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 30.1.1, 30.1.2-т заасан хугацаанд арга хэмжээ аваагүй бол Хорооноос кастодианыг өөрчлөхийг үүрэг болгоно.

30.3.Хороо кастодианы бүтэц болон санхүүжилтийн доголдол үүссэн талаар хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, Төв банк (Монголбанк)-анд ажлын 1 өдрийн дотор мэдэгдэнэ.

30.4.Төв банк (Монголбанк) кастодианы төлбөрийн чадварт эрсдэл үүссэн талаар Хороо, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид ажлын 2 өдрийн дотор мэдэгдэнэ.

30.5.Кастодианыг өөрчлөхдөө нэмэлт тэтгэврийн хөрөнгөтэй холбоотой кастодианы үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэхээр тооцож хэрэгжүүлнэ.

30.6.Кастодиантай байгуулсан гэрээ дуусгавар болсон бол кастодиан өөрийн хадгалалт хамгаалалтад байсан үйлчилгээтэй холбоотой нэмэлт тэтгэврийн хөрөнгө болон бүх баримт бичгийг шинээр томилогдсон кастодианд анх байгуулсан кастодианы үйлчилгээний гэрээнд заасан хугацаанд эсхүл талуудын харилцан тохиролцсон хугацааны дотор хүлээлгэн өгнө.

30.7.Энэхүү хуулийн 30.6-д заасан баримт бичиг болон нэмэлт тэтгэврийн хөрөнгө бүрэн шилжих хүртэл кастодиан үүрэг хариуцлагаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

30.8.Кастодиан нь энэ хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн эсхүл зөрчих боломжтой гэж үзсэн, эсхүл гишүүний ашиг сонирхолд эрсдэл үүсгэсэн үйлдэл, эс үйлдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, Хороонд ажлын 1 өдрийн дотор мэдэгдэнэ.

30.9.Энэ хуульд заасны дагуу кастодиан үйлчилгээнд байршуулсан нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь кастодианы хөрөнгөд тооцогдохгүй бөгөөд кастодиантай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл, дампуурлын хэрэг, эвлэрэл түүнтэй адилтгах бусад ажиллагаанд хамаарахгүй.

31 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын менежментийн компани

31.1.Хувийн тэтгэврийн сан нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулна. Урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар итгэмжлэн удирдуулж болно.

31.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэг болон хэд хэдэн хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгож болно.

31.3.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг энэ хуулийн 26.1.1, 26.1.2-т заасан хөрөнгийн ангилалд Хорооноос тогтоосон дээд хязгаарт багтаан хувийн тэтгэврийн сан нь хөрөнгө оруулж итгэмжлэн удирдаж болно.

31.4.Итгэмжлэн удирдах нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөд тооцогдохгүй бөгөөд хөрөнгө оруулалтын менежментийн компанитай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл, дампуурлын хэрэг, эвлэрэл түүнтэй адилтгах бусад ажиллагаанд хамаарахгүй.

31.5.Хөрөнгө оруулалтын менежментийн компани хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн өмнөөс хувьцаанд ногдох саналын эрхийг хэрэгжүүлэхдээ зөвхөн гишүүн, өвлөгчийн эрх ашгийг хамгаалах зорилготой байна.

31.6.Хөрөнгө оруулалтын менежментийн компани энэ хуулийн 31.5-д зааснаар санал өгөхдөө хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэх ба өгсөн саналаа үндэслэлтэй болохыг нотолно.

32 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур

32.1.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах шалгуурыг хангасан байна:

32.1.1.албадлагын ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, хүчингүй болгоогүй байх;

32.1.2.кастодиан, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд тухайн ажил олгогчийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл холбогдох этгээд биш байх.

32.1.3.сүүлийн нэг жилээс доошгүй хугацаанд сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдсан байх

32.1.4.мэргэжлийн удирдлагын баг, олон жилийн хөрөнгө оруулалтын туршлагатай байх;

32.1.5.засаглал нь олон улсын зарчимтай нийцэж байх;

32.1.6.хөрөнгө оруулагчид зориулсан мэдээллийн ил тод, шуурхай системтэй байх.

32.2.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь кастодиан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээд, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд ажил олгогчид зээл олгох, тэдгээрээс зээл авахыг хориглоно.

33 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах гэрээ

33.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах хөрөнгө оруулалтын менежментийн гэрээнд дараах агуулгыг тусгасан байна:

33.1.1.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлага;

33.1.2.хувьцааны саналын эрхийг хэрэгжүүлэх зааварчилгаа;

33.1.3.хөрөнгө оруулалтын менежментийн компанид төлөх хөлсийг тогтоож, түүний зардал, төлбөрийг хөрөнгө оруулалтын менежментийн удирдаж буй нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэдэн хувиар тооцоолох аргачлал.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан гэрээнд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг гэрээ байгуулсан кастодианаар дамжуулан хэрэгжүүлэхээр заана.

ТАВДУГААР БҮЛЭГ ГИШҮҮН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ХӨТӨЛБӨР ХООРОНД ШИЛЖИХ, ХӨТӨЛБӨРИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ

34 дүгээр зүйл.Гишүүн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих

34.1.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжиж болно.

34.2.Нэмэлт тэтгэврийн гэрээ, журамд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх нөхцөл, шаардлагыг тусгана.

34.3.Гишүүн хөтөлбөр хооронд шилжих хүсэлтээ хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид бичгээр болон цахимаар гаргана.

34.4.Хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 34.3-т заасны дагуу мэдэгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор гишүүний нэрийн дансны хөрөнгийг холбогдох зардлыг суутгаж, шилжүүлнэ.

34.5.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөрөнгөө өөр хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлэхэд татвар ногдуулахгүй.

34.6.Гишүүн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжихтэй холбогдсон журмыг Хороо батална.

35 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох

35.1.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөр дараах тохиолдолд дуусгавар болно:

35.1.1.энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу шилжсэн;

35.1.2.энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан төрлөөр авч дууссан;

35.1.3.гишүүн, өвлөгч нас барсан.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
НЭМЭЛТ ТЭТГЭВЭР ОЛГОХ**

36 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл

36.1.Гишүүн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан тохиолдолд нэмэлт тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.

36.2.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөөс тэтгэвэр тогтоолгох эрхтэй гишүүн дараах төрлийн нэмэлт тэтгэврийн аль нэгийг, эсхүл хослуулан зөвхөн 1 удаа сонгоно:

36.2.1.нэг удаагийн тэтгэвэр;

36.2.2.хугацаат тэтгэвэр;

36.2.3.насан туршийн тэтгэвэр.

36.3.Нэг удаагийн тэтгэврийн дээд хязгаарыг нэмэлт тэтгэврийн журам, гэрээнд тусгасан байх бөгөөд нийт дүнгээр эсхүл гишүүний нэмэлт тэтгэврийн хуримтлалын тодорхой хувиар тогтооно.

Тайлбар: “нэг удаагийн тэтгэвэр” гэж нэмэлт тэтгэврийн хөрөнгийг тэтгэврийн нэрийн данснаас гишүүнд нэг удаа олгох мөнгөн дүнг хэлнэ.

36.4.Гишүүнд хуваарьт тэтгэврийг 5-10 хүртэл жилийн хугацаанд олгох бөгөөд аргачлалыг нэмэлт тэтгэврийн гэрээ, журамд заана.

Тайлбар: “хугацаат тэтгэвэр” гэж гишүүнд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг тодорхой хугацаанд хуваарийн дагуу тогтсон дүнгээр тэнцүү олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

36.5.Насан туршийн тэтгэвэрт хамрагдахад шаардагдах тэтгэврийн нэрийн дансны хадгалагдсан эрхийн доод хязгаарыг нэмэлт тэтгэврийн журам, гэрээгээр тогтооно.

Тайлбар: “насан туршийн тэтгэвэр” гэж гишүүний тэтгэврийн наснаас хойш нэмэлт тэтгэвэр авах хугацааны илэрхийлэлд үндэслэн тооцож, нас барах хүртэл хугацаанд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

36.6.Гишүүн энэ хуулийн 36.2.2, 36.2.3-т заасны дагуу тэтгэвэр авах бол урт хугацааны даатгагчтай гэрээ байгуулна. Гэрээнд олгох тэтгэврийн хэмжээ, хугацаа, нас барсны дараа үүсэх өвийн зохицуулалтыг заавал тусгана.

36.7.Гишүүн энэ хуулийн 36.2.2, 36.2.3-т заасны дагуу тэтгэвэр авах бол хувийн тэтгэврийн сан урт хугацааны даатгагчтай гэрээ байгуулж нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлнэ.

38 дугаар зүйл.Нэмэлт тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

38.1.Гишүүн, өвлөгч нэмэлт тэтгэвэр тогтоолгоход дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гаргана:

38.1.1.тэтгэврийн төрлийг сонгож, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн баталсан маягтын дагуу гаргасан хүсэлт;

38.1.2.тэтгэвэр хүлээн авах банкны нэр, дансны дугаар;

38.1.3.шаардлагатай тохиолдолд гишүүний хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаныг нотлох баримт бичиг.

39 дүгээр зүйл.Нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, өргөдөл шийдвэрлэх хугацаа

39.1.Гишүүн, өвлөгч баримт бичиг бүрдүүлж, хүсэлт гаргаснаас хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажлын 10 өдрийн дотор нэмэлт тэтгэврийн хэмжээг тогтоож, сонгосон арилжааны банкны дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

39.2.Гишүүн насан туршийн тэтгэвэр авахаар тохирсон, тэтгэврийн асуудлыг шийдвэрлэхэд нэмэлт хугацаа шаардлагатай бол хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 39.1-д заасан хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, энэ тухай гишүүн, өвлөгчид мэдэгдэнэ.

39.3.Энэ хуульд заасан хугацаанд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч шийдвэр гаргаагүй бол гишүүн, өвлөгч нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гомдол гаргах эрхтэй. Хэрэв шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд энэ хуульд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

39.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүн, өвлөгчид нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, баримт бичиг бүрдүүлэх, хянах, өргөдөл, гомдол

шийдвэрлэх, үлдэгдэл хөрөнгийг шилжүүлэх харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

ДОЛООДУГААР БҮЛЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ, ТАЙЛАГНАЛ

40 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл

40.1. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ.

41 дүгээр зүйл. Аудит, актуарын тайлан

41.1. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

41.2. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд мэдээлж, Хороонд хүргүүлнэ.

41.3. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөрөнгөд актуарын тайлан, дүгнэлт гаргуулж, Хороонд хүргүүлнэ.

41.4. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт актуарын хяналт шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа актуарчаар хийлгэх бөгөөд актуарын хяналт шалгалтын тайланг Хороонд хүргүүлнэ.

41.5. Хороо актуарын хяналт шалгалтыг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн томилсон, эсхүл өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлж болно.

42 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаагаа тайлагнах

42.1. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүнд дараах мэдээллийг тайлагнана:

42.1.1. нэмэлт тэтгэврийн хөрөнгийн бүх гүйлгээ, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолж, тэтгэврийн нэрийн дансанд улирал тутам оруулан бүртгэж, тэтгэврийн нэрийн дансны нийт үлдэгдлийг илтгэсэн тайлан;

42.1.2. гишүүн бүрд хөрөнгө оруулалтын бодлого, захиран зарцуулж байгаа тэтгэврийн нийт хөрөнгө, хөрөнгө оруулалтын үр дүн, тэтгэврийн нэрийн дансны дэлгэрэнгүй мэдээллийг дараа жилийн эхний улиралд багтаан цаасан, эсхүл цахим хэлбэрээр.

42.2. Энэ хуулийн 42.1-д заасан мэдээлэлтэй цахим хэлбэрээр танилцах, хянах боломжийг бүрдүүлж, гишүүнийг нэвтрэх эрхээр хангана.

42.3. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах ажилтан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан өөрчлөгдсөн, хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт орсон тохиолдолд гишүүнд тухай бүр мэдэгдэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

43 дугаар зүйл.Мэдээллийн нэгдсэн сан

43.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн, өвлөгч, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбогдсон цахим мэдээллийн нэгдсэн сантай байна.

43.2.Мэдээллийн сан нь гишүүний дараах мэдээллийг агуулсан байна:

43.2.1.гишүүний төлсөн шимтгэлийн мэдээлэл;

43.2.2.баталгаат өгөөж, хөрөнгө оруулалтын бодит болон тооцоолсон өгөөж;

43.2.3.нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх, өвлүүлэхээр гаргасан хүсэлтийн мэдээлэл;

43.2.4.олгосон тэтгэвэр;

43.2.5.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хоорондын шилжилт;

43.2.6.гишүүний өвлөгчийн мэдээлэл, тэдгээрт төлөгдсөн мөнгөн дүн;

43.2.7.хөдөлмөрийн чадвар алдалтын талаар;

43.2.8.суутгасан татвар, татвар төлөлт;

43.2.9.кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэдээлэл.

43.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах бөгөөд сангийн мэдээллийг 70 ба түүнээс дээш жил хадгална.

43.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн мэдээллийн сангийн нууцлалыг хадгалах бөгөөд зөвхөн гишүүн нэвтрэх эрхтэй байна.

43.5.Эрх бүхий байгууллага нь зөвхөн хяналт тавих, шалгалт хийх, гишүүний гомдлыг барагдуулах зорилгоор мэдээллийн сангаас мэдээлэл гаргуулан авах эрхтэй.

43.6.Хороо энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, шалгалт хийх, тайлагнах, судалгаа хийх зорилгоор мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ашиглана.

43.7.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөр болон тэтгэврийн нэрийн дансны мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалт, мэдээлэл сэргээх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрмийг Хороо батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

44 дүгээр зүйл.Итгэмжлэгдсэн өмчлөгч үүрэг зөрчих, хариуцлага хүлээлгэх

44.1.Итгэмжлэгдсэн өмчлөгч нэмэлт тэтгэврийн хөрөнгийг итгэмжлэлийн хүрээнд зөвхөн гишүүн, өвлөгчийн ашиг сонирхолд нийцүүлэн итгэмжлэн удирдана. Бусад зорилгоор үйл ажиллагаа явуулсан бол итгэмжлэгдсэн өмчлөгчийг үүргээ зөрчсөнд тооцно.

44.2.Итгэмжлэгдсэн өмчлөгч өөртөө, өөрийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох бусад этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг захиран зарцуулсан бол итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргээ зөрчсөнд тооцно.

44.3.Энэ хуульд тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд нөгөө этгээд нь итгэмжлэгдсэн өмчлөгчийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох этгээд байхад тэдгээртэй нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр гүйлгээ хийсэн бол итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргээ зөрчсөнд тооцно.

44.4.Итгэмжлэгдсэн өмчлөгч нөгөө итгэмжлэгдсэн өмчлөгч зөрчил гаргасныг мэдсэн эсхүл мэдэх боломжтой байсан бол итгэмжлэгдсэн өмчлөгчийн зөрчилд мөн адил хариуцлага хүлээнэ.

44.5.Итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүрэг хариуцлагыг зөрчсөн ажилтны зөрчилд ажил олгогч мөн хариуцлага хүлээнэ.

44.6.Итгэмжлэгдсэн өмчлөгчийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

44.7.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхэлж буй хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, бусад итгэмжлэгдсэн өмчлөгчид нь хууль тогтоомж, гэрээ зөрчсөн тохиолдолд гишүүн, өвлөгчийн итгэмжилсэн хөрөнгөд хариуцлага хүлээнэ.

44.8.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн итгэмжлэгдсэн өмчлөгчтэй холбогдсон иргэний маргааныг шийдвэрлэхдээ энэ хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хохирлыг төлүүлнэ.

44.9.Итгэмжлэгдсэн өмчлөгчийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төлүүлэхээр гишүүн, өвлөгч нь дараах шаардлагыг итгэмжлэгдсэн өмчлөгчөөс хариу хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор Хороонд гаргах бөгөөд Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гаргаж болно.

44.9.1.гишүүн, өвлөгчид ногдох нэмэлт тэтгэврийн хөрөнгийг бүхэлд нь олгуулах;

44.9.2.гишүүн, өвлөгчийн бусад хохирлыг барагдуулах.

44.10.Хороо энэ хуулийн 44.9 дэх хэсэгт заасан шаардлагыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 60 хүртэл хоногоор сунгаж болно.

44.11.Итгэмжлэгдсэн өмчлөгч хүлээсэн үүрэг хариуцлагаа зөрчсөнөөс үүссэн бүх хохирлыг холбогдох гишүүн, өвлөгчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд төлж барагдуулна.

45 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой маргаан шийдвэрлэх

45.1.Нэмэлт тэтгэврийн журамд гишүүн, өвлөгчийн гомдлыг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч шийдвэрлэх үйл ажиллагааг тусгана.

45.2.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа бүртгэх журамд гомдол шийдвэрлэх нэгжийг бүрдүүлсэн эсэхийг хянаана.

45.3.Гомдол шийдвэрлэх нэгж нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид гишүүнээс гаргасан гомдлыг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

45.4.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн гомдол шийдвэрлэх нэгжид гомдол гаргасан гишүүн, өвлөгч нь гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй.

45.5.Хороо нь хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой гомдол шийдвэрлэх журмыг батална.

45.6.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь Хорооны гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

45.7.Хорооны маргаан шийдвэрлэсэн шийдвэрийг эс зөвшөөрсөн гишүүн, өвлөгч нь шүүхэд хандах эрхтэй.

45.8.Гишүүн урт хугацааны даатгагчийн төлөх насан туршийн тэтгэвэртэй холбоотой гомдлоо урт хугацааны даатгагч болон Хороонд гаргаж холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

46 дугаар зүйл.Хорооны чиг үүрэг

46.1.Хороо энэ хуулийн хэрэгжилтийг хангах, нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт шалгалт хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, гишүүн, өвлөгчийн эрх ашгийг хамгаалах, багц дүрэм, журам, заавар, аргачлал, удирдамж, маягт баталж мөрдүүлэх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

46.2.Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийнэ.

46.3.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг тайлагнах журам, маягтыг батална.

48 дугаар зүйл.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

48.1.Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалд даатгуулагчийн мэдээллийг эрх бүхий байгууллагаар дамжуулан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

49 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

49.1.Монгол Улсад нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байсан этгээд нь энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш нэг жил хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа энэ хуульд нийцүүлнэ.

49.2.Хороо энэ хуульд заасан дүрэм, журам, бусад шаардагдах бичиг баримтыг энэ хууль батлагдсанаас хойш зургаан сар хүртэлх хугацаанд боловсруулж батална.

50 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

50.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

51.1.Энэ хуулийг 2027 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.2.13 дахь заалт:

“13.2.13.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчоос төлсөн шимтгэлийн зардал нь тухайн татварын жилд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт ажилтанд олгосон цалин хөлсний зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна. Албан татвар төлөгчийн эрх бүхий албан тушаалтантай Татварын ерөнхий хуулийн 27.1.1-д заасан харилцан хамаарал бүхий ажилтан хамаарахгүй;

2/21 дүгээр зүйлийн 21.1.17 дахь заалт:

“21.1.17.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орлого.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “тэтгэврийн сан,” гэсний өмнө “хувийн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.10 дахь заалт:

“2.10 хувийн тэтгэврийн сан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан”

2/11 дүгээр бүлгийн 11.36 дугаар зүйл:

“11.36 дугаар зүйл. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль зөрчих

1. Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, бүртгэл, эрхгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн танилцуулгад худал, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл тусгаж нийтэд танилцуулсан, худал амлалт өгсөн, танилцуулгад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа өөрчлөлт оруулсан, хуулийг зөрчиж эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй танилцуулгыг нийтэд танилцуулсан, санхүүжилт татах зорилгоор бусад төрлийн мэдээллийг нийтэд нээлттэй зарласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Хуульд заасныг зөрчиж:

3.1. хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы үйл ажиллагааны журам зөрчсөн;

3.2. хориглосон үйл ажиллагаа явуулсан;

3.3. хуулиар зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлж, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулсан;

3.4. нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох шийдвэр гарснаас хойш нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хуульд тусгайлан заасны дагуу шилжүүлэхээс өөрөөр захиран зарцуулсан;

3.5. кастодиан нь нэг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн тухайд хөрөнгө оруулалтын менежментийн, кастодианы үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлсэн;

3.6. хөрөнгө оруулалтын менежментийн компани нь нэг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн тухайд хөрөнгө оруулалтын менежментийн, кастодианы үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлсэн;

3.7.хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын зардлын төлбөрөөс бусад төлбөр, хураамжийг нэмэлт тэтгэврийн хөрөнгөөс гаргасан;

3.8.хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, хувийн тэтгэврийн сангийн дүрэм, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг итгэмжлэн удирдах журмаар тогтоосон, хөрөнгө оруулалтын буюу эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичигт заасан, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа эсэхт нэмэлт тэтгэврийн хөрөнгийг гэрээгээр хадгалж байгаа кастодиан нь хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуульд заасан мэдээлэл, мэдэгдлийг зохих журмын дагуу холбогдох этгээдэд гаргаж өгөөгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нэмэлт тэтгэврийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдсон хэлцлийг өөрийн нэрийн өмнөөс хийгээгүй, эсхүл итгэмжлэн удирдлагыг хэрэгжүүлж байгаа гэдгээ мэдэгдээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Хуульд заасныг зөрчиж:

6.1.хувийн тэтгэврийн сангийн дэлгэрэнгүй, эсхүл товчилсон тэмдэглэгээг хэрэглэсэн;

6.2.нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргасан;

6.3.эрх бүхий байгууллагаас эрх олгосон, хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой зар сурталчилгаа явуулсан;

6.4.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай байгуулах гэрээнд хуулиар, эсхүл хувийн тэтгэврийн сангийн дүрмээр хөрөнгө оруулалтын менежментийн компани, эсхүл кастодианы хүлээхээр заасан үүрэг, хариуцлагыг бууруулах, эсхүл чөлөөлөх тухай заалт тусгасан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Татан буулгах комисс эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

2.39.хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
---	-----------------------------

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.18 дахь дэд заалтын “11.35” гэсний дараа “11.36” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.12 дахь заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

“4.1.12. хувийн тэтгэврийн сан;”

2 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “4.1.10” гэсний дараа “4.1.12” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн "... хэмжээ нь" гэсний дараа "ажил олгогчийн болон" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

"10.1. Нийгмийн даатгалын сан нь дараах мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна."

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь хэсгийн "... нийслэлийн" гэснийг "... дүүргийн" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.5, 37.6, 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн "... нийслэл" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг:

“2.1.5.ажилгүйдлийн тэтгэмж;
2.1.6.шимтгэлийн хөнгөлөлт.”

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шимтгэлийн төлбөрийг олгоно.” гэснийг “шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно.” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй,” гэснийг “тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн” гэснийг “тэтгэмжийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт:

“3.1.13.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

2/6 дугаар зүйлийн 6.2.11 дэх заалт:

“6.2.11.хувийн нэмэлт тэтгэврийн чиглэлээр Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалтын дугаарыг “3.1.14” гэж, 3.1.14 дэх заалтын дугаарыг “3.1.15” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалтууд нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.41 дэх заалт:

“4.1.41. “хувийн тэтгэврийн сан” гэж Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 5.1.5-д заасан хуулийн этгээдийг.”

2/24 дүгээр зүйлийн 24.1.20 дахь заалт:

“24.1.20. хувийн тэтгэврийн сангийн;”

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “тэтгэврийн” гэсний өмнө “хувийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “...-24.1.14-т” гэсний дараа “..., 24.1.20-т” гэж, мөн зүйлийн 24.5 дахь хэсгийн “24.1.13-т” гэснийг “24.1.13, 24.1.20-т” гэж, 24.6 дахь хэсгийн “24.1.14-т” гэснийг “24.1.14, 24.1.20-т” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт тус тус нэмсүгэй:

1/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн дагуу төлсөн шимтгэлийг 1,200,000 төгрөг хүртэл дүнгээр хасна.”

2/16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт:

“16.1.5.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 11.5-д заасан орлогыг нийт дүнгээр, Хувийн нэмэлт нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 36.2.1-д заасан орлогын нийт дүнгээр.”

3/25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэг:

“25.9.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч байна. Суутган төлөгч нь энэ хуулийн 16.1.5-д заасан орлогоос энэ хуулийн 25.1.2-т заасан журмын дагуу албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлнэ.”

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “тэтгэвэр” гэсний “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 36.2.1-д зааснаас бусад” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтад “16.1.4” гэсний дараа “16.1.5” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “16.1.4,” гэсний дараа “16.1.5,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 46¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“46¹ дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэвэр

46¹.1.Ажил олгогч нь өөрийн ажилтныг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчийн тэтгэврийн хөтөлбөрт хамруулж болно.

46¹.2.Нэмэлт тэтгэврийн гэрээг хөдөлмөрийн гэрээнээс тусад нь Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

46¹.3.Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдсон харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛНЫ ЯАМ

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

**ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

ГАРЧИГ

НЭГ.Асуудалд дүн шинжилгээ хийх

- 1.1.Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ
- 1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд
- 1.3.Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

ХОЁР.Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох

- 2.1.Гол зорилго, зорилт

ГУРАВ.Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулах

- 3.1.Асуудлыг зохицуулах хувилбарууд
- 3.2.Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай
- 3.3.Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

ДӨРӨВ.Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах

- 4.1.Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
 - 4.1.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.2.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

ТАВ.Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх

ЗУРГАА.Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

- 6.1.Хувийн нэмэлт тэтгэврийн үүрэг, нөлөө
- 6.2.Хувийн тэтгэврийн даатгалд хамрагдах
- 6.3.Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хандах олон улсын бодлого, чиг хандлага
- 6.4.Татварын хөнгөлөлттэй холбоотой улсын төсвийн зардал
- 6.5.Дүгнэлт

ДОЛОО.Зөвлөмж

НАЙМ.Эх сурвалж

НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх

1.1.Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ:

Нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, ажил олгогчоос хууль, тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр, эсхүл урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Дэлхийн улс орон бүрийн өмнө сүүлийн жилүүдэд тулгараад байгаа нэг сорилт бол өндөр настай иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх тухай асуудал юм.

Манай улсад 1990-ээд оноос өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт нь улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарч хуучин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэх шилжилтийн үеийн үр дүнд нийгмийн хамгааллын салбарт зөвхөн улсын төсвөөс санхүүжиж байсан тэтгэврийн хуучин тогтолцоог халж, ажил олгогч, даатгуулагч шимтгэл төлж сан бүрдүүлэх, хамтын хариуцлага хүлээх, мөн төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, уг сангаас тэтгэвэр олгох үндсэн концепци бүхий тэтгэврийн даатгалын тогтолцоог 1995 оноос шинээр нэвтрүүлсэн. Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлэн улмаар 29 жилийн дараа Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан.

Нийгмийн хамгааллын салбар нь нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу хөгжлийн олон бодит хүчин зүйл болох эдийн засаг, улс төр, соёл, хүн ам зүйгээс хамааран хөгждөг.

Нийгмийн хамгааллын чиглэлээр гарсан бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажил 1995 оноос эхлэн өнөөг хүртэл тодорхой хэмжээнд ахиц дэвшил гарсан боловч нийгмийн даатгалын мөн чанар, ач холбогдлыг ойлгох ойлголт иргэд, ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын дунд хангалтгүй байсаар байна. Энэ нь эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдэл, ядууралтай холбоотой бөгөөд, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээ нь амьдралын хэрэгцээг хангахгүй, шинэ, хуучин тэтгэврийн зөрүү арилаагүй, хөнгөлөлттэй нөхцөл, болзлоор эрт тэтгэвэрт гаргасан, гаргаж байгаа зэрэг нь амьжиргааны түвшин буурах, орлого багатай эмзэг бүлгийн иргэдийн тоог өсгөн, улмаар эдгээр иргэдийн нийгмийн баталгаа алдагдахад хүргэж байна.

Тэтгэвэр нь тэтгэвэр авагчийн амьжиргааны баталгааг хангах хангалттай эх үүсвэр болж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд нийгмийн даатгалын салбарт давхар даатгал, хувийн даатгал зэрэг олон төрөл, хэлбэрийн шинэ тэтгэврийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Монгол Улсын нийгмийн даатгалын сан нь даатгалын 4 төрөл тус бүрдээ бие даасан сантай ба орлогын эх үүсвэр нь дараах байдалтай байна. Үүнд:

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги;
- Улсын төсвөөс олгох санхүүжилт;
- Бусад эх үүсвэрийн орлого;

Эдгээр орлогууд нь бүх төрлийн татвараас чөлөөлөгддөг. Тэтгэврийн болон даатгалын сан өөрийн орлогоос гадна улсын төсвөөс санхүүжилт авдаг.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийт тэнцэл, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн хэмжээг сүүлийн 5 жилээр харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

					Хүснэгт 1
Үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Сангуудын орлого	1,811.1	2732.1	3512.5	4271.6	5574.0
Сангуудын зарлага	2494.0	2565.6	3415.7	4036.2	5097.5
Улсын төсвөөс олгох татаас болон алдагдлын нийт дүн	399.4	593.9	920.7	774.4	1175.0

Эх сурвалж: НДЕГ-ын мэдээллийн сангаас

Дээрх судалгаанаас харахад Монгол Улсын нийгмийн даатгалын сангийн алдагдал ялангуяа тэтгэврийн сангийн алдагдал жил бүр нэмэгдэж, улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж байгаа нь цаашид ч үргэлжлэх хандлагатай байна.

Одоогийн нийгмийн даатгалын тогтолцоонд бүрэн хамрагдахгүй байгаа мал аж ахуй, хөдөө аж ахуй болон албан бус салбарт ажиллагсад зориулсан тогтвортой баталгаат, үр дүнтэй тэтгэврийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна. Сүүлийн үеийн статистик мэдээллээс үзэхэд, Монгол Улсын нийт ажиллах хүчний талыг малчид болон албан бус салбарын ажиллагсад эзэлж байна.

Цалин хөлсний хэмжээнээс тодорхой хувь хэмжээгээр шимтгэл хэлбэрээр хураадаг зарчимтай нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоо нь байнгын бус орлоготой нийгмийн эдгээр бүлэгт тохиромжгүй. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд эдгээр бүлэгт сарын орлогоо өөрөө мэдүүлэх, шимтгэлээ хугацааны хувьд олон хувилбараар төлөх замаар нийгмийн даатгалд хамрагдах боломж олгодог ч хамрах хүрээ салбарын ажиллах хүчний тоотой харьцуулахад бага хэвээр байна.

Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг 2014 оноос хойш 9 жилийн дараа дундаж цалин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөд үндэслэн 2022 он суурьтай тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор баталсан.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээ 550 000 (таван зуун тавин мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440 000 (дөрвөн

зуун дөчин мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 396.4 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд 490.3 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 2023 онд 687.5 мянган төгрөг болсон.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540.0 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүх тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 572.4 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянган төгрөг болсон. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох дундаж тэтгэвэр 848.0 мянган төгрөгт хүрсэн.

Манай улсын 60 ба түүнээс дээш насны ахмад настны тоо 2010 байдлаар 5.8 хувь, 2021 оны байдлаар 7.9 хувь, 2024 онд 9.3 хувь байгаа бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох тооцоолол байна. Хүн амын дундаж наслалт (0 наснаас тооцоолсон) 2024 онд 71.7 жил болж 2000 оны дундаж наслалттай харьцуулахад 8.6 жилээр өссөн. Харин эрэгтэйчүүдийн дундаж наслалт мөн онтой харьцуулахад 7.5 жилээр нэмэгдэж 67.9 жил, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 11.0 жилээр нэмэгдэж 77.1 жил болж жилээс жилд өсөх хандлагатай байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч 2024 онд 531.8 мянга байсан бол 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэхээр байна. Өөрөөр хэлбэл, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 хүн, 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын хүн амын хэтийн тооцооллыг 2024 оны байдлаар эмэгтэй хүн 55 наснаас хойш 25 жил, эрэгтэй хүн 60 наснаас хойш 16 жил амьдарч байна гэж тооцсон. Ирээдүйд буюу 2050 онд уг хугацаа эмэгтэй хүний хувьд 28.4 жил, эрэгтэй хүний хувьд 19.6 жил болж өсөхөөр байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2024 онд 24.4 мянган хүн шинээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, 7.1 мянган хүний тэтгэвэр зогсож тэтгэвэр авагчдын цэвэр өсөлт 17.3 мянган хүн байжээ.

2024 онд тэтгэвэрт 4.6 их наяд төгрөг зарцуулсан бөгөөд 2023 онтой харьцуулахад 27.8 хувиар буюу 1.0 их наяд төгрөгөөр өссөн байна. Тэтгэврийн даатгалын сангийн 2024 оны зардалд өндөр насны тэтгэвэр 79%, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 9.4%, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3.1%, цэргийн тэтгэвэр 7.5%-ийг тус тус эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангийн 2023 оны зардал нэмэгдэхэд хүний тооны өсөлт болон дундаж тэтгэврийн өсөлт шууд нөлөөлсөн байна. Хэдийгээр нийгмийн даатгалын хамралт жил тутамд өсөж, 2024 оны эцсийн байдлаар 1.3 сая орчим даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдаж, тэтгэврийн даатгалын сангийн орлого жил бүр нэмэгдэж байгаа боловч хүн амын насжилт, нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жингийн өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зардал хурдацтайгаар нэмэгдэж байна.

Статистик судалгаанаас үзэхэд хүн амын тоо 2013 онд 2.9 сая байсан бол 2024 онд 3.5 сая болж өссөн бөгөөд энэ 10 жилд 19.6 хувиар өссөн бол мөн

хугацаанд ахмад настны тоо 56.5 хувиар буюу илүү хурдацтай өссөн байна. Түүнчлэн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2013 онд 4 хүн, 2020 онд 5 хүн байсан бол 2040 онд 8 хүн болох урьдчилсан тооцоололтой байна.

Монгол Улсын харьяат хүн амын тоог насны бүтцээр харахад 0-14 насны хүүхдийн эзлэх хувь 30 орчим хувьтай байгаа ба харин 65-аас дээш настай хөгшчүүдийн эзлэх хувийн жин тодорхой хувиар өсөхөөр байна. Тухайлбал, 2015 онд 65-аас дээш насныхан нийт хүн амын 3 хувийг эзэлж байсан бол 2045 онд 9 хувь болж 3 дахин нэмэгдэхээр байна.¹

Тэтгэврийн насны хүн ам 2015 онд хүн амын 8 орчим хувийг эзэлж байсан бол 2030 онд 12, 2045 онд 16 орчим хувь болохоор байна. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдээс илүү, мөн тэтгэвэрт гарах нас 5 насаар залуу байдагтай холбоотойгоор эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин илүү байна.

Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны одоогийн загвар, сангийн санхүүгийн нөхцөл байдлаас үзэхэд нэмэлт тэтгэврийн даатгалын эрэлт өндөр байгаа нь ажиглагдаж байна. Одоогийн өндөр настны тэтгэвэр нь цалинд жишсэн аргаар тэтгэвэр тогтоодог, тэтгэвэр тогтоолгохоор сонгосон цалинг индексжүүлэн тооцдог бөгөөд (үүнд 1960 оноос хойш төрсөн боловч хөнгөлөлттэй тэтгэврийн нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгосон иргэд багтана) оруулалтын хувь нь даатгуулагчийн цалингийн 55-60 хувьтай тэнцүү байна. Гэвч ирээдүйн тэтгэврийн талаарх хамгийн сүүлийн санхүүгийн төсөөллөөс харахад ирээдүйд тэтгэврийн хэмжээ цалингийн 30 хувь хүртэл буурахаар байна.²

Уг төсөөллөөс үзэхэд тэтгэврийн хэмжээг цалингийн 30 хувьд байлгахын тулд төрөөс олгох санхүүжилтийн хэмжээг улсын ДНБ-ий 2 хувиас 6 хувь болгон өсгөхөөс нааш санхүүжүүлэх боломжгүй юм. Урт хугацааны хувьд тэтгэврийн тогтолцоог тогтвортой, тэнцвэрт байдалд хүргэхийн тулд тэтгэврийн насыг нэмэгдүүлэх эсвэл тэтгэврийн хэмжээг бууруулахаас өөр гарцгүй. Тэтгэврийн өнөөгийн тогтолцоонд өөрчлөлт оруулахгүй нөхцөлд тэтгэвэр авагчдын багагүй хэсэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан тэтгэврийн доод хэмжээг авах болно. Энэхүү доод хэмжээ нь 1960 оноос хойш төрсөн иргэдийн хувьд нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгох даатгуулагч нь сүүлийн цалингийн 30 орчим хувьтай тэнцэх хэмжээнд хүрч буурахаар байна.

Тэтгэврийн даатгалын одоогийн тогтолцоог урт хугацааны турш санхүүгийн хувьд тогтвортой байлгах, түүнчлэн тэтгэврийн доод хэмжээг үлдээх тохиолдолд тогтолцоо нь баялгийг дахин хуваарилах шинж чанартай, тэтгэврийн доод хэмжээ хүртэгсэд буюу нийгмийн орлого багатай иргэдэд илүү ашигтай тогтолцоо болон хувирах юм. Ингэснээр улсын тэтгэврийн тогтолцоо нь өндөр настнуудад зөвхөн амьжиргааны доод түвшний баталгааг олгох бөгөөд орлого өндөртэй иргэдийн хувьд хэрэглээний түвшин огцом буурах эрсдэлтэй юм.

Монгол Улс шиг социалист, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн, түүнчлэн уул уурхайн салбараар хөгжих төлөвтэй эдийн засагт иргэдийн дундаж цалингийн хэт зөрүүтэй байдал үүсэх нь гарцаагүй байдаг. Өндөр орлоготой (*боловсрол өндөртэй, залуу, хот сууринд амьдардаг*

¹ Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, ҮСХ

² Тайланд дурдсан тэтгэврийн ирээдүйн тооцоолол, санхүүгийн байдлын үнэлгээ нь Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн хүрээнд Насир Уайндын PROST загварыг ашиглан гаргасанд тооцооллуудад үндэслэсэн болгосон болно.

нийгмийн бүлэг) иргэд болон тэтгэврийн тогтолцооны шилжилтийн үеийн даатгуулагчид тэтгэврийн хэмжээгээ нэмэгдүүлэх, бага орлоготой иргэд ирээдүйн тэтгэврийн орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага бий болох үзэгдэл ажиглагддаг.

Баялгийг дахин хуваарилах улсын тэтгэврийн тогтолцоо нь бага орлоготой иргэдийг ядуурлаас хамгаалахаас гадна улс төрийн хувьд чухал нөлөөтэй юм.

Өнөөдөр иргэдийн дунд цалингийн зөрүү их байгаа. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн 38.8 хувь нь цалингийн доод хэмжээнээс дөрөв дахин өндөр цалинтай байна.³ Өндөр орлоготой иргэд тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоонд нийтлэг байдаг татварын шууд бус хөнгөлөлт болон урамшууллыг баялгийн дахин хуваарилалтыг тэнцүүлэх зорилгоор ашиглах сонирхол нэмэгддэг.

Ажил мэргэжлийн, нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоо нь хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажилладаг, ийм нөхцөлд ажилласны улмаас дундаж наслалт буурах, эрт хөдөлмөрийн чадвараа алдах магадлал өндөртэй ажилчдын дунд эрэлт өндөртэй байдаг.

Тэтгэвэр тогтоолгох насыг үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа энэ үед эрт тэтгэвэрт гарах боломжийг бий болгох нэмэлт даатгалын тогтолцоо нь тэтгэврийн наснаас доогуур дундаж наслалттай эдгээр иргэдэд нэн шаардлагатай юм. Ихэнх улс оронд уурхайчид болон цацраг туяаны нөлөөлөлтэй орчин зэрэг хортой нөхцөлд ажиллагсдад зориулсан тусгай нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоо байдаг.

Хортой нөхцөлийн ажил мэргэжлийн хамгийн нийтлэг нэмэлт даатгал нь нүүрсний уурхайчдад зориулагдсан байдаг бөгөөд үйлдвэрчний эвлэл болон хамтын хэлэлцээрээр зохицуулж хэрэгжүүлдэг байна.

Улсын тэтгэврийн тогтолцооны хамрах хүрээ:

Тэтгэврийн хэмжээтэй холбоотой бас нэгэн хүчин зүйл нь улсын тогтолцооны хамрах хүрээ юм. Нэмэлт тэтгэврийн тогтолцоо нь өндөр орлоготой иргэдэд тэтгэврийн нэмэлт орлогын эх үүсвэр болохоос гадна тэтгэврийн тогтолцооны гадуур байдаг албан салбарт оролцох боломжгүй иргэдийг тэтгэврийн тогтолцоонд хамрагдах боломжийг олгодог. Албан бус салбарын тогтмол цалин хөлсгүй иргэдийн дунд тэтгэврийн хуримтлал үүсгэх уламжлалт бус даатгалын эрэлт өндөр байдаг.

Латин Америк, Төв болон Зүүн Европын хуучин социалист орнуудын туршлагаас үзэхэд албан бус салбарт ажиллагсдыг тэтгэврийн заавал даатгалд хамруулах нь бэрхшээлтэй байдаг. Эдгээр улс орнуудад зах зээлийн эдийн засагт шилжсэн, төрийн албаны нийгмийн хангамж буурсан зэрэг нь албан бус салбар зонхилох нөхцөлүүдийг бүрдүүлсэн байна.

Энэ нь улсын тэтгэврийн тогтолцооны хамрах хүрээ зогсонги байдалд орох, зарим тохиолдолд хумигдахад хүргэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд эдгээр ажилчдыг тогтмол шимтгэлтэй, "хосолсон" урамшууллын аргаар тэтгэврийн даатгалд хамруулах шинэчлэл хийгдэж эхэлсэн байна. Мөн алслагдсан бүс нутаг, хөдөө аж ахуйн салбарын ажиллагсдад хүртээмжтэй тэтгэврийн хуримтлалын тогтолцоог

³ Насир Уайндын PROST-ын төсөөлөлд ашиглагдсан НДЕГ-ээс өгсөн мэдээлэл

зарим улс орнууд, ялангуяа Энэтхэг улс эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн.

Хүн амын санхүүгийн чадавх, санхүүгийн хэрэгсэл ашиглах чадвар:

Хувийн тэтгэврийн тогтолцоонд хамрагдах сонирхол, оролцоо нь иргэдийн санхүүгийн суурь боловсрол, санхүүгийн хэрэгслүүдийн талаарх мэдлэг, хуримтлалын талаарх хандлага, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн худалдан авах чадвар, хүсэл зэрэг хүчин зүйлсээс шалтгаална. Эдгээр хандлагыг иргэдийн "санхүүгийн чадавх" ба хүн амын "санхүүгийн оролцоо"-ны түвшин гэж хэмжиж, үнэлдэг.

Монгол Улсад иргэдийн санхүүгийн оролцоо нь банкны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд өндөр байгаа нь хувийн тэтгэврийн тогтолцоонд хамрагдах сонирхолд чухал ач холбогдолтой юм. Улс орнуудын дунд санхүүгийн чадавхыг хэмжиж, харьцуулалт хийх хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл байхгүй ч харьцуулан судалгаа хийж үзэхэд Монгол Улс холбогдох үзүүлэлтээрээ дээгүүр жагсаж байгаа юм. 2012 оны Дэлхийн Findex судалгаанаас үзэхэд Монгол Улсын нийт өрхийн 78 хувь нь албан ёсны санхүүгийн байгууллагад данс нээлгэж байсан байдаг. Энэ үзүүлэлт нь Зүүн Ази болон Номхон далайн бүс нутагт 55 хувь, түүнчлэн Монгол Улстай ижил хүн тус бүрт ногдох ДНБ-тэй улс орнуудад 28 хувь байдаг байна. Мөн Монгол Улсын нийт өрхийн 61 хувь дебит карт эзэмшдэг, сүүлийн нэг жилд 25 хувь нь санхүүгийн байгууллагаас зээл авсан зэрэг үзүүлэлтүүд нь санхүүгийн байгууллага, тэдний бүтээгдэхүүнд оролцох оролцоо өндөр байгааг харуулж байна.⁴

Банкны салбараас гадуур болон хөдөө орон нутагт иргэдийн санхүүгийн хэрэгслүүдийн талаарх мэдлэг хомс байгаа ч хадгаламжийн бүтээгдэхүүнд идэвхтэй оролцож байгаа нь нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах тал дээр эерэг үзүүлэлт юм.

Иргэдийн дийлэнх нь банкнаас бусад санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн талаар мэдлэг бага, дөнгөж 15 хувь нь хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн хэрэглэж үзсэн байна. Гэсэн хэдий ч банкнаас бусад санхүүгийн хэрэгслүүд харьцангуй сүүлд нэвтэрсэн, хүртээмж хязгаарлагдмал байгаа Монгол Улсад энэхүү үзүүлэлт нь өндөрт тооцогдож болох талтай. Иргэдийн санхүүгийн суурь боловсрол, чадвар дундаж хэмжээнд байна. Судалгаанаас үзэхэд иргэдийн дийлэнх нь санхүүгийн анхан шатны тооцоо хийж чаддаг, 30 хувь нь энгийн хүүний талаар ойлголтгүй, 42 хувь нь нийлмэл хүүний талаарх асуултад зөв хариулж чадахгүй, 60 хувь нь хөрөнгө оруулалтын төрөлжүүлэлт буюу диверсификацийн талаар ойлголтгүй байсан байна.

Тэтгэврийн хуримтлал үүсгэхэд хамгийн нөлөөлөхүйц сөрөг үзүүлэлт нь иргэдийн 60 хувь нь хуримтлалын үнэ цэнэд инфляцын нөлөө ямар байхыг ойлгохгүй байгаад оршино. Санхүүгийн мэдлэгийн түвшин нь орлогын түвшнээс шууд хамааралтай байгаа нь санхүүгийн салбарын хөгжил өндөртэй улс оронд ч ажиглагддаг хэв маяг билээ.

Судалгаанаас харагдах гол эерэг үзүүлэлт нь иргэдийн хандлага ба зан байдал юм. Монгол иргэдийн дийлэнх нь өрхийн санхүүг төсөвлөж, зарцуулалтаа хянаж чаддаг гэж хариулсан байдаг.

⁴ Global Findex database at : <http://datatopics.worldbank.org/financialinclusion/country/mongolia>

Хамгийн сонирхолтой нь орлого багатай иргэд, малчид үүнд илүү итгэлтэй байсан байна. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь ирээдүйдээ төлөвлөх сонирхолтой, төлөвлөөгүй худалдан авалтыг хязгаарлах, санхүүгийн зөвлөгөө авах, санхүүгийн шийдвэр гаргахдаа бүтээгдэхүүн, хэрэгслүүдийг харьцуулах сонирхол, чадвартай гэдэг нь харагдаж байна.

Бусад улс орнуудтай нэгэн адилаар энэхүү чадавх (*төсөвлөх чадвараас бусад*) нь нас, орлого, санхүүгийн бүтээгдэхүүний оролцооноос шууд хамааралтай байна. Дүгнэн хэлэхэд Монгол иргэд бусад ижил түвшний орлого, хөгжилтэй улсуудтай харьцуулахад харьцангуй өндөр санхүүгийн төлөвлөлтийн талаар мэдлэгтэй, зөв хандлагатай байгаа харагдаж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн бүтэц ба ирээдүйн чиг хандлага:

Эдийн засгийн хурдацтай хөгжил, 1990-ээд оны үед төрөгсдийн тоо буурсан, өндөр ур чадвар ажил мэргэжлийн эрэлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь ирэх арван жилд өндөр ур чадвартай ажиллах хүчний төлөө өрсөлдөөнийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Өрсөлдөөнт энэ нөхцөлд өндөр зэрэглэлийн ажиллах хүчийг өөртөө татах, авч үлдээхдээ цалингийн хурдацтай өсөлтийг сааруулах арга замыг хайх нь гарцаагүй. Ажиллах хүчний эрэлтийн өсөлт нь боловсрол, мэргэшил шаардсан ажил мэргэжил (*менежер, техникч, туслах техникч, механик, туслах ажилчид*)-ийн хувьд өндөр байх төлөвтэй. Эдгээр ажил, мэргэжлийн эрэлт нь эдийн засгийн шилжилттэй холбоотой хүн амын өсөлт өндөртэй томоохон хотуудад илүү өндөр байдаг. Ажиллах хүчний эрэлтээс гадна ажиллах хүчний дундаж нас нэмэгдэнэ. Өрсөлдөөн ихтэй хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүчний насжилт гэсэн хоёр хүчин зүйл нь ажил, мэргэжлийн тэтгэврийн даатгалын эрэлтийг нэмэгдүүлж ажил олгогчийн зүгээс хүний нөөцийн хэрэгсэл болон хувирна.

Хэд хэдэн банкууд сүүлийн жилүүдэд өөрсдийн ажилчдад зориулан нэмэлт тэтгэврийн даатгалын сан байгуулсан нь ажил олгогчийн зүгээс сонирхол, дэмжлэг, хэрэгцээ, шаардлага өндөр байгааг илтгэж байна. Ажил олгогчийн зүгээс хувийн тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлэх сонирхол хэр их байгааг хэмжих найдвартай шалгуур байхгүй ч ажил олгогч болон ажил олгогч эздийн байгууллагуудын хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс тэдний байр суурийг харж болох юм.

Холбогдох хууль эрх зүйн орчин, санхүүгийн урамшуулал байхгүй ч сүүлийн хэдэн жилийн дотор Монгол Улсад хөрөнгийн зах зээлийн салбарын дийлэнхийг төлөөлөх гурван томоохон банк, мөн нэг хөрөнгө оруулалтын сан өөрсдийн ажилчдадаа зориулан тэтгэврийн сан бий болгожээ. Эдгээр байгууллагуудын хүний нөөцийн ахлах мэргэжилтнүүдтэй уулзахад тэтгэврийн санг ажиллагсдаа тогтвортой ажиллуулах, авч үлдэх сонирхлын үүднээс байгуулсан хэмээн онцолж байв.

Эдгээр цахиур хагалсан тогтолцоонууд нь ажиллагсдад нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах урамшуулал бий болгосноос гадна уг тогтолцооны үр өгөөжийг эдлэхийн тулд тодорхой хугацааны турш байгууллагадаа ажиллах нөхцөл тавьдаг байна. Эдгээр байгууллагуудын ажилчдын 50 хүртэл хувь нь нэмэлт тэтгэврийн тогтолцоонд хамрагдаад байгаа юм. Үүнээс гадна, хөрөнгө оруулалт хийх үүрэг бүхий хувийн тэтгэврийн сан Монгол Улсад бий болсон бөгөөд бусад ажил олгогчдод тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүн санал болгож эхлээд байгаа юм.

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр гишүүн байгууллагуудын дунд нэмэлт тэтгэврийн тогтолцоог

чадварлаг ажиллах хүчийг авч үлдэх хүний нөөцийн бодлогыг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх сонирхол өндөр байдаг хэдий ч хууль, эрх зүйн орчин, татварын хөнгөлөлт, урамшууллын тогтолцоо байдаггүйгээс нэвтрүүлэхэд бэрхшээл тулгарч байгааг хэлж байсан.

Хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоог нэвтрүүлэх хуулийн төсөл хоёр жилийн өмнө боловсруулагдсан боловч УИХ-д өргөн барьж чадаагүй байна. Үйлдвэрчний эвлэлийн албан хаагчидтай хийсэн уулзалтын үеэр мөн л хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх сонирхол өндөр, дэмжихэд бэлэн гэсэн байр суурьтай байсан ч Үйлдвэрчний эвлэлийн талаас санаачилсан арга хэмжээ байхгүй, цаашдын чиг баримжаа тодорхойгүй гэж байсан.

Тэтгэврийн санг зохион байгуулах, үйл ажиллагааг эрхлэхэд шаардагдах хууль, эрх зүйн орчин

Монгол Улсад хувийн тэтгэврийн санг зохион байгуулах, үйл ажиллагаа эрхлэх үндэс суурь болох Тэтгэврийн сангийн хууль эрх зүйн орчин байхгүй. Аливаа хувийн тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлэхэд сангийн хөрөнгийг эзэмших, хөрөнгө оруулах хэлбэрийг зохион байгуулах, тэтгэврийн сангийн өндөр стандартуудад нийцэх оновчтой шаардлагуудыг хэрэгжүүлэх, хянах, орлогын албан татварын болон татварын бусад хууль тогтоомжид тэтгэврийн сангийн талаарх баримтлах бодлого зэрэг цогц хууль эрх зүйн орчин бүрэлдүүлэх шаардлагатай байдаг.

Мөн тогтолцооны загварын талаар бодлогын үндсэн шийдвэрүүдийг гаргах, энэ бодлогыг хууль тогтоомж болон зохицуулах дүрэм журамд хөрвүүлэх нь Монгол Улсад хувийн тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх анхан шатны бэрхшээл болох юм.

Хууль эрх зүйн орчны зарим чухал зарчмууд болон суурь ухагдахуунууд саяхан батлагдсан Үнэт цаасны тухай болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд багтсан байна. Эдгээр хуульд "Хамтын хөрөнгө оруулалтын сан", "Хөрөнгө оруулалтын сан" гэсэн хоёр ойлголтыг шигтгэж өгсөн нь тэтгэврийн бүтээгдэхүүн санал болгох арилжааны тэтгэврийн сангийн бүтэц, үйл ажиллагаатай дөхөж очих юм.

Хуульд дурдсан лиценз болон бүртгэлийн шаардлагууд нь "Тэтгэврийн сан" хэмээх хөрөнгө оруулалтын сангийн гурав дахь төрөлд нийцэх бөгөөд ижил төстэй журам, стандартыг ашиглан нэг зохицуулах байгууллагаас лицензийг олгох боломжтой болж байгаа юм. Хуулийн болон жинхэнэ өмчлөгч, хөрөнгийн хуулийн итгэмжлэл, гүйлгээ хийхэд кастодиан ашиглах, удирдлагын бүтэц, аудитын шаардлага, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах дүн шинжилгээнд шаардагдах доод стандартууд болон ашиг сонирхлын зөрчлийн эсрэг заалтууд эдгээр хуулиудад их бага хэмжээгээр багтсан хэдий ч хувийн тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэхэд одоогийн хууль эрх зүйн орчинд орхигдсон олон чухал асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсад Траст буюу Хөрөнгө оруулалтын итгэмжлэлийн тухай хууль гэж байдаггүй. Ихэнх улсад ийм төрлийн хууль нь ажил олгогчийн ивээл дор байх тэтгэврийн сангийн зохион байгуулалтын анхдагч суурь болдог. Тэтгэврийн хэмжээ, бодолт, шимтгэл, хөрөнгө оруулалтын удирдлагын талаарх шийдвэр (*бие даасан, лицензтэй тэтгэврийн сангийн удирдлага бүхий тогтолцоонд ч өрсөлдөгч хөрөнгө оруулалтын сангуудаас сонгох, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний шимтгэл гэх мэт*), хяналтын үр дүн, ажилчдад (*даатгуулагчдад*) тайлагнах зэрэг ойлголтуудыг хуульчлах шаардлагатай. Ажил олгогчийн тэтгэврийн тогтолцооны

стандартуудыг ашиг сонирхлын зөрчил, сангийн хөрөнгийг ажилтны ажил олгогчийн үнэт цаасанд хөрөнгө оруулах, авлигал, үйлчилгээний шимтгэл хэт өндөр байх болон бусад эрсдэлүүдээс сэргийлэн боловсруулсан байх шаардлагатай.

Тэтгэврийн сангаас хөрөнгө оруулалтыг хийхэд тавигдах стандартууд

Тэтгэврийн сангийн суурь зохион байгуулалт, хяналтын стандартуудтай нягт холбоотой ч Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль нь Монгол Улсын онцлогт тохируулан Тэтгэврийн сангийн үйл ажиллагааг дэмжих стандартууд, хязгаарлалтуудыг тусгаж өгөөгүй байна. Хөрөнгө оруулалтыг ерөнхий ангиллаар хязгаарлах эдгээр стандартууд нь өндөр орлоготой иргэдийн нэмэлт орлогоос хөрөнгө оруулалт хийхэд тохиромжтой ч хувийн тэтгэврийн санд даатгуулагчдыг хамгаалахад хангалтгүй юм.

Хөрөнгө оруулалтын ерөнхий ангиллуудыг тодорхойлсон стандартуудыг тэтгэврийн сангийн онцлогт нийцүүлэн нарийвчилж боловсруулснаар тэтгэврийн орлогын баталгааг хангах зорилгоор хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах юм. Үүнийг хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын багц бүрт тусгайлан зориулсан стандартуудад хөрөнгийн ангилалд бүрт дээд, доод хэмжээг зааж өгөх замаар хэрэгжүүлж болдог. Үүнтэй зэрэгцэн, сүүлийн үед зарим улс орнуудад эрсдэл багатай, өгөгдмөл хөрөнгө оруулалтын багц эсвэл даатгуулагчийн насанд дүйцүүлэн эрсдэлийн түвшинг багцын хуваарилалтаар тохируулах заавал тогтолцоог хэрэгжүүлэх болсон байна. Энэ нь даатгуулагчдын санхүүгийн суурь боловсрол дутмаг, эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтын багцыг сонгох эрсдэлийг бууруулах зорилготой юм.

Тэтгэврийн баталгаат байдлыг хангах бүтээгдэхүүнүүд, байгууллага

Монгол Улсад өнөөдрийн байдлаар тэтгэврийн даатгалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, тэдгээр нь ямар эрх зүйн орчинд ажиллаж байгааг үзвэл:

а. Санхүүгийн зохицуулах хорооноос Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Даатгалын тухай хуульд нийцүүлэн багц дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага нэг (*даатгалын компани*) байна.

б. Эрх бүхий байгууллагаас ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүй авдаггүй, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийцүүлэн хязгаарлагдмал хүрээнд (*зөвхөн нэг байгууллага дотор хэрэгжиж байгаа*) болон олон нийтэд санал болгох замаар хэрэгжүүлж байгаа нийт 4 аж ахуйн (*ХХК*) нэгж болон төрийн бус байгууллагын хэлбэрээр (*ТББ*) үйл ажиллагаа явуулж байна.

Нэгэнт нийгэмд болон зах зээлд энэ төрлийн үйлчилгээ, бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлага байгаа учраас нэг талаас дээр дурдсан аж ахуйн нэгжүүд энэ төрлийн үйлчилгээг зохих түвшинд үзүүлж, нөгөө талаас иргэд, даатгуулагчид энэ төрлийн үйлчилгээг худалдаж авч байгаа нь зах зээлийн жам ёсны хэрэгцээ шаардлага хэдий ч даатгуулагчийн эрх ашиг, ирээдүйн баталгааг бүрэн хангахгүй, хамгаалсан хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль батлагдсанаар төрийн зохицуулах байгууллагын (Санхүүгийн зохицуулах хороо) тусгайлсан зохицуулалт, хяналт

шалгалтын доор үйл ажиллагаа явуулах хувийн тэтгэврийн даатгалын сан бий болж, тэдгээр нь татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогод хамрагдах боломжтой болсноор зах зээлийн жамаар одоогийн ажиллаж буй сангууд (ТББ, ХХК, байгууллага доторх сангууд) хуулийн этгээдийн хэлбэрээ өөрчилж, тусгай зохицуулалттайгаар үйл ажиллагаа явуулж, эдийн засгийн болон эрх зүйн боломжийг ашиглахыг хичээх болно.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрмийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос урт хугацаат даатгалын компанийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, эрсдэлийн удирдлага болон төлбөрийн чадварын харьцааг байнга хангаж ажиллахыг шаардаж байгаа нь даатгуулагчийн ирээдүйн тэтгэврийн хөрөнгийг эрсдэхээс сэргийлэх, эрсдэх нөхцөл байдал учирсан тохиолдолд зохицуулалтын арга хэмжээг авах, эрсдэлийн түвшинг даатгалын компанийн өөрийн хөрөнгийн хэмжээтэй уях байдлаар ажиллана.

Олон улсын туршлагаар тэтгэврийн сангууд нь урт хугацааны сан тул хөрөнгийн болон санхүүгийн салбарт урт хугацаат өрийн бичиг, бонд, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх боломжийг бүрдүүлдэг. Энэ нь өнөөгийн хөгжил багатай дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэд, хувийн хэвшлийн хөрөнгийн зах зээлээр санхүүгийн эх үүсвэр, хөрөнгө оруулалт татах сонирхлыг төрүүлэх, хамгийн гол нь зах зээлд санхүүгийн эх үүсвэрийн зардал болох хүү, купоны хувь хэмжээ буурах, хугацаа уртсах боломжтой болно.

Даатгалын багц дүрэм журмын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос хувийн тэтгэврийн даатгалын сангаас хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн төрөл, хэлбэр, хэмжээ, хязгаар зэргийг нарийвчлан заах, дараагийн санхүүгийн жилд хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөг хянаж батлах, даатгалын компаниуд тухайн батлагдсан төлөвлөгөөг дагах, аливаа эрсдэлийн хэмжээ өссөн тухай бүрт Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх, тайлагнах, хариу авч байх үүрэгтэй.

Тэтгэврийн хувийн даатгалын тогтолцоог дэмжих чадалтай хөрөнгө оруулалтын хэрэгслүүд бий болох найдвар байгаа ч шаардлага өндөртэй хувийн тэтгэврийн тогтолцооны түвшинд хүртэл багагүй хугацаа шаардагдахаар байна. Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хувийн салбарын вексель олгогчийн удирдлага, ил тод байдлыг сайжруулсан бөгөөд "Бизнес эрхлэх нь" тайланд "Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах" болон "Гэрээний биелэлт" үзүүлэлтүүдээр Монгол Улс бүсийн дунджаас дээгүүр үнэлгээтэй авсан байна. Барьцаат зээлийн хоёрдогч зах зээлийг байгуулах санаачилга ид өрнөж байгаа бөгөөд Монголын ипотекийн корпорац нь үнэт цаасыг зах зээл дээр гаргах ажлаа эхэлсэн байна. Хэрэв эдгээр үнэт цаас нь барьцаат зээл болон эрсдэлийн далд үнэ цэнийг тусгаж чадсан, зах зээлийн үнэ ханштай байж чадвал ирээдүйд тэтгэврийн хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох боломж харагдаж байна.

Данс бүртгэл, шимтгэлийн гуйвуулга хийхэд шаардагдах баталгаат систем

Хувийн тэтгэврийн санд даатгуулагчдын (Даатгуулагч, Ажил олгогч болон Төрөөс гэсэн 3 төрлийн эх үүсвэр байх магадлалтай) шимтгэлийг төвлөрүүлэх, даатгуулагчийн тэтгэврийн дансанд хуваарилах үйл ажиллагаа нь эрсдэлд өртөх магадлал өндөр байдаг тул энэ нь тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Ганц ажил олгогчийн хувийн тэтгэврийн сан нь ажил олгогчийн цалингийн тооцоо, данс

бүртгэлийн тогтолцоог (орлогын албан татвараас зайлсхийхээс сэргийлж) хянахыг шаарддаг. Арилжааны тэтгэврийн сан буюу тэтгэврийн мэргэшсэн сангийн хувьд шимтгэл төвлөрүүлэх, тэтгэвэр тэтгэмж олгох ажлыг төрийн байгууллагаар дамжуулан гүйцэтгүүлж болдог. Үүнийг тусгай зориулалтын тооцооны байгууллагаар дамжуулан эсвэл нийгмийн даатгалын байгууллагаар дамжуулан гүйцэтгэж болдог байна.

Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл болон орлогын албан татвар төвлөрүүлэх үр дүнтэй тогтолцоо байгаа, мөн банкууд иргэдэд хүрч ажиллаж чаддаг болсноор нэмэлт даатгалын тогтолцоонд шимтгэл төвлөрүүлэх суваг тавигдсан байна гэж үзэж болно. Урт хугацаат даатгалын компани өөрийн дэд бүтэц, борлуулалтын сувгаас гадна дээрх байгууллагуудын чадавхыг ашигласнаар хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог богино хугацаанд бүрдүүлэх, хот суурин газар болон орон нутагт хэрэгжүүлэхэд дөхөм болно. Албан бус салбар, хөдөө орон нутагт хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгод хүрэхийн тулд банкны дэд бүтцийг ашиглаж болох юм. Харин албан секторын, тогтмол цалин хөлстэй ажилчдад нэмэлт даатгалын тогтолцоог санал болгохын тулд одоогийн нийгмийн даатгалын байгууллагын нэгэнт тогтсон дэд бүтцийг ашиглах нь давуу тал болно. Одоогийн байдлаар нийгмийн даатгалын байгууллагын бүтэц нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төв, 331 сум болон Бүгд Найрамдах Солонгос Улсад байгуулагдан ажиллаж байгаа юм.

Тэтгэврийн сангийн онцлогт тохирсон зохицуулалтын болон хяналтын чадавх

Хувийн тэтгэврийн сангууд загвар шийдэл, зорилгоос үл хамаараад дээд зэргийн хяналт, зохицуулалтыг шаарддаг. Энэ нь санд хөрөнгийг урт хугацаагаар байршуулах шаардлага, даатгуулагчдын санхүүгийн суурь боловсрол хязгаарлагдмал ба тэтгэврийн орлогын эрсдэл өндөр байдагтай холбоотой юм. Ихэнх улсад зохицуулалт, хяналтыг мэргэшсэн байгууллага болох төрийн санхүүгийн зохицуулалт, хяналтын байгууллагад тусгайлсан хэлтэс, газар байгуулан хэрэгжүүлдэг.

Одоогоор Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хяналтыг хариуцсан төрийн нэгж, газар байхгүй байна. Хяналт хийх боломжтой байгууллагууд нь шинэ үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд багагүй бэрхшээлтэй тулгарч болзошгүй боловч хуульд хяналт тавих байгууллагуудын эрх, үүрэг, оролцоог тодорхой тусгаж өгснөөр учирч болох бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх боломжтой. Хувийн тэтгэврийн тогтолцоог дэмжих дэд бүтцийн зайлшгүй нэг хэсэг бол хяналт, зохицуулалтын механизм юм.

Дээр дурдсан олон нөхцөл шаардлага, хязгаарлалтуудаас харахад тэтгэврийн сангуудад төрөөс тусгай зөвшөөрөл олгох замаар зохицуулах нь зөв юм.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын бичиг баримтад зааснаар Хувийн нэмэлт тэтгэврийн санг хувийн хэвшлийн урт хугацаат даатгалын компани эрхлэхээр заасан тул хяналт, зохицуулалтын үүргийг Санхүүгийн зохицуулах хороо гүйцэтгэх шаардлагатай.

Хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх урамшуулал болон дэмжлэгийн бодлого, тогтолцоо

Олон улсад хувийн тэтгэврийн тогтолцоо нь сайн дурын болон албан журмын

даатгалын тогтолцоотой байна. Ихэнх сайн дурын нэмэлт хувийн тэтгэврийн тогтолцоотой улс орнууд тухайн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэхэд төрөөс санхүүгийн болон татварын бодлогоор дэмждэг байна. Манай улсын хувьд хувийн тэтгэврийн тогтолцоо нь сайн дурын үндсэн дээр нэмэлтээр даатгуулах зарчимд суурилж байгаа тул төрөөс татварын бодлогоор дэмжсэн тохиолдолд цаашид энэ хууль хэрэгжих, хамрах хүрээ өргөсөх, эдийн засаг болон санхүү, хөрөнгийн зах зээлд өгөөж, ашиг тусаа өгөх боломжтой болно.

Монгол Улсын иргэдийн дундаж цалин дэлхий жишгээс хэд дахин бага, амьжиргааны баталгаажих түвшин доогуур, иргэд даатгуулагчид тэтгэвэрт гарсан даруйд бага орлоготой ангилалд шилждэг зэргээс харахад төрөөс иргэдийг ажиллаж байх хугацаандаа тэтгэврийн хуримтлал хийхийг урамшуулах, тэтгэвэрт гараад олон эх үүсвэрээс баталгаат орлоготой байх, амьжиргааны түвшинг бууруулахгүй амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд нь дэмжих шаардлагатай.

Иргэд тэтгэврийн наснаас хойших орлого болон үүнд шаардагдах хуримтлалаа бодитой тооцож чаддаггүй, өндөр насны орлого тасалдах эрсдэлийг дутуу үнэлдэг учир хувь хүнийг өөрийн ирээдүйгээ төлөвлөх сэдлийг өдөөх зорилгоор төрөөс санхүүгийн болон татварын урамшууллын бодлогоор дэмждэг. Хувь хүний энэхүү зан төлөвийн хэв маягийг сүүлийн 20 жилийн турш хэд хэдэн удаагийн санхүүгийн зан төлөвийн судалгаагаар нотолсон байдаг. Олон улсын туршлагаас үзэхэд ихэнх улс орнуудад тэтгэврийн даатгалын санд шимтгэл цуглуулах болон тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийг татвараас чөлөөлөх замаар урамшууллын тогтолцоог хэрэгжүүлдэг. Тухайлбал, Оросын Холбооны Улсад даатгуулагч өөрөө хувийн тэтгэврийн даатгалын санд шимтгэлд төлсөн хэмжээгээр төрөөс дэмжин давхар төлдөг, Бүгд Найрамдах Унгар Улсад даатгуулагч хэрвээ хүсвэл өөрийн төлсөн хувь хүний орлогын албан татварын 20 хүртэл хувийг өөрийн хувийн тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлэх боломжийг хуулиар хангаж өгсөн байдаг. Мөн зарим улс орнууд нэрийн дансны эхний үлдэгдлийг төрөөс санхүүжүүлэх, ажил олгогчоос шимтгэл төлөх замаар орлогын албан татвар бага төлдөг иргэдийг оролцуулах боломжтой байдаг.

Санхүүгийн ямар нэг урамшуулал олгодоггүй хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоо нь өндөржүүлсэн хяналтын тогтолцооноос бусдаар урт хугацааны хуримтлалаас ялгарах онцлоггүй юм. Ийм нөхцөлд оролцогчдод дарамт учруулж нэмэлт зардал гаргах шаардлагатай эсэх тал дээр олон нийт дургүйцэх нь тодорхой. Орлогын албан татварын тухай эдийн засгийн онол нь урт хугацааны хөрөнгийн хуримтлал үүсгэхэд татварын хөнгөлөлт үзүүлэхийн ач холбогдлыг онцолдог.

Ажилчид хувийн тэтгэврийн тогтолцоонд хамрагдсанаар гар дээр авах цалингийн хэмжээ буурах сөрөг талыг татварын хөнгөлөлтөөр нөхөх юм.

Одоогийн манай улсын татварын болон бусад хууль тогтоомжид хувийн тэтгэврийн санг байгуулах, шимтгэл төлөх, даатгуулагч болон ажил олгогчийн оролцоог дэмжсэн, урамшуулсан заалт, зохицуулалт байхгүй байна. Бусад орны туршлагаас үзэхэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь хувийн тэтгэврийн даатгалын тогтолцооны хамрах хүрээг тэлэхэд чухал ач холбогдолтой нь харагдаж байна. Төрөөс үзүүлэх санхүүгийн болон татварын урамшууллын бодлогогүйгээр хувийн тэтгэврийн тогтолцооны хамрах хүрээг хангалттай түвшинд хүргэхэд бэрхшээлтэй.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах болон маргаан шийдвэрлэх механизм

Тэтгэврийн хуримтлалын хугацаа урт, өндөр настнуудын ядууралд нэрвэгдэх эрсдэл өндөр, даатгуулагч болон тэтгэврийн сангийн удирдлагын санхүүгийн мэдлэгийн зөрүүтэй байдал зэрэг шалтгаанууд нь даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, маргаан шийдвэрлэх оновчтой шийдэл боловсруулах шаардлагыг бий болгодог. Аль ч тогтолцоог хэрэгжүүлэхэд, ялангуяа эхний үе шатанд, тогтолцооны шударга байдал, тэтгэврийн баталгаанд даатгуулагчдын итгэх итгэл хамгийн чухал байдаг. Үүнд хяналт, зохицуулалтын тогтолцоо тодорхой үүргийг хүлээх боловч хяналтын байгууллагууд даатгуулагч тус бүрийн гомдлыг хэлэлцэх нөөц бололцоо байдаггүй, тэтгэвэр тэтгэмжийн төлөлт болон тэтгэврийн сангийн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдалд анхаарал, нөөц бололцоогоо хандуулдаг бодлогын шинж чанартай асуудал юм.

Одоогоор Монголд хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцооны шаардлагад нийцэх даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, гомдол барагдуулах, маргаан шийдвэрлэх тогтолцоо байхгүй байна. Арилжааны зорилгоор тэтгэврийн нэрийн дансны хуримтлалын бүтээгдэхүүн борлуулах тогтолцоонд даатгуулагчдын эрх ашгийн асуудал нэн чухал байдаг. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүргийг одоогоор гурван байгууллага хариуцаж байна. Эдгээр нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо ба Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар юм. Эдгээр байгууллагууд хоорондын ажил үүргийн хуваарилалт тодорхойгүй бөгөөд зарим чиг үүрэг давхацсан хэвээр байна. Хувийн тэтгэврийн даатгалын харилцаанд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон асуудлууд нь харьцангуй шинэ учир үр дүнтэй тогтолцоог бий болгоход тусдаа дүрэм, журам боловсруулах шаардлагатай.

Дүгнэлт:

Монгол Улсад Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцооны эрэлт, хэрэгцээг илтгэх хэд хэдэн шинж чанарууд байна. Одоогийн нийгмийн даатгалын тогтолцоо нь ирээдүйн дийлэнх тэтгэвэр авагчдыг хангалттай орлогоор хангаж чадахгүй нь статистик судалгаанаас харагдаж байна. 1960 оноос хойш төрсөн даатгуулагчдын тэтгэвэр сүүлийн цалингийн 30 орчим хувьтай тэнцэх тооцоо гарсан. Ирээдүйн санхүүгийн төсөөллөөс үзэхэд энэхүү 30 хувийг санхүүжүүлэхэд ч хүндрэлтэй тул тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бууруулах буюу тэтгэврийн насыг нэмэгдүүлэх зэрэг параметрын өөрчлөлт хийхээс өөр аргагүйд хүрнэ. Тэтгэврийн даатгалын тогтолцоо нь одоогоор ажиллах хүчний тал хувийг ч хамруулж байгаа хэдий ч хөдөө аж ахуйн салбарын ажилчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулах хөтөлбөрүүд ерөнхийдөө хангалтгүй байна. Бусад шилжилтийн эдийн засагт тулгарсан дарамтууд Монгол Улсад тохиолдвол хамрах хүрээ буурах хандлага ажиглагдана.

1990-ээд оны үед төрөлт буурсан, ДНБ-ний хурдацтай өсөлт, уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил нь хувийн тэтгэврийн тогтолцооны эрэлтийг нэмэгдүүлнэ. Энэ эрэлт доорх хэд хэдэн шалтгаанаас үүснэ:

1. Нийгмийн даатгалын тогтолцоо нь ирээдүйд ядуурлаас бууруулах, баялгийг дахин хуваарилах шинж чанартай болсноор өндөр орлоготой иргэдийн тэтгэврээс өмнөх орлогыг нөхөх;

2. Чадварлаг ажиллах хүчний төлөө ажил олгогчдын дунд үүсэх өрсөлдөөнөөс үүдэн шилдэг ажиллах хүчийг өөртөө татах хүний нөөцийн бодлого нэмэгдэнэ;

3. Хүнд, хортой нөхцөлд ажиллагсдад эрт тэтгэвэрт гарах нөхцөл

бололцоогоор хангах;

Хууль, эрх зүйн орчин, санхүүгийн болон татварын урамшууллын тогтолцоо бүрэлдээгүй ч банк, санхүүгийн салбарт дээрх асуудлууд болон бизнесийн боломжийг олж харсан ажил олгогчид хувийн тэтгэврийн санг байгуулж эхэлсэн төдийгүй ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлийн төлөөллүүд нэмэлт тэтгэврийн орлого шаардлагатай байгааг ухамсарлан ийм төрлийн тогтолцоог нэвтрүүлж эхлээд байна. Улс төрийн оролцогчдын үзэл баримтлал мөн л эерэг хандлагатай байгаа бөгөөд хувийн, нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоо хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа юм.

Монгол Улсын дийлэнх иргэд санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөн хэрэглэдэг, тэр дундаа банкны үйлчилгээг тогтмол хэрэглэдэг, санхүүгийн мэдлэг боловсрол нь хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн орнуудын түвшинд дүйцэхүйц байна. Улсын тэтгэврийн тогтолцооны цоорхойг нөхөх нэмэлт тэтгэврийн тогтолцооны эрэлт, хэрэгцээ өндөр байгаа, түүнчлэн банк санхүүгийн үйлчилгээ иргэдэд сайн хүрч чаддаг зэрэг нь хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлэх боломжтойг илтгэж байна.

Гэвч одоогоор Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн орчин болон зохицуулалт, хяналтын тогтолцоо бүрэлдээгүй байна.

Үнэт цаасны тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон түүний дагалдах дүрэм журмаар хувийн тэтгэврийн даатгалын үйл ажиллагаа, бүрэн харилцааг нарийвчлан зааж өгөөгүй байгаа тул тусгайлан зохицуулсан цогц эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай байна.

Зах зээлд энэ төрлийн санхүүгийн үйлчилгээ хэрэгцээтэй байгааг харуулж байгаа хэдий ч даатгагч, даатгуулагчийн эрх үүргийг тодорхойлсон, тэтгэврийн сангийн удирдлага, хөрөнгийн найдвартай байдалд хяналт тавих, урт хугацаанд даатгуулагчийн эрх ашгийг бүрэн хамгаалах, төрөөс бодлогоор дэмжих хэмжээнд хууль, эрх зүйн орчин дутмаг байна.

Банкны тогтолцоо давамгайлсан санхүүгийн системтэй, харьцангуй эрсдэл өндөр учир санхүүгийн эх үүсвэрийн зардал өндөр, хугацаа богино байгаа нь хувийн тэтгэврийн даатгалын сангууд үүсэж хөгжөөгүйтэй холбоотой. Тэтгэврийн хуримтлалыг бусад өөр төрлийн урт хугацааны хуримтлалаас ялгах санхүүгийн урамшуулал болон бусад төрлийн давуу эрх олгосон заалтууд Татварын хуульд байхгүй байна. Ийм төрлийн урамшууллын тогтолцоо байхгүйгээр хамрах хүрээг тэлэх, ажил олгогчийн зүгээс дэмжлэг үзүүлэх боломжгүй.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, гомдол барагдуулах хүртээмжтэй, бүрэн цогц тогтолцоо бүрэлдээгүй байна. Ийм тогтолцоог бий болгох нь хувийн тэтгэврийн тогтолцоонд иргэдийн итгэх итгэл, баталгаат байдлыг бий болгоход маш чухал юм.

Нэг талаас Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлэх хэрэгцээ, сонирхол өндөр байгаа бөгөөд бодлогын зорилтыг тодорхойлох, салбарын харилцааг бүхэлд нь цогц байдлаар шийдвэрлэж чадахуйц хууль эрх зүйн орчинг бий болгох, хяналт, зохицуулалтын байгууллагын эрх үүргийг тодорхой болгох, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээг цогцоор хэрэгжүүлэх шаардлагатай юм. Түүнчлэн тэтгэврийн даатгалын үйл ажиллагаа нь *нэгдүгээрт*,

урт хугацаанд явагддаг, хоёрдугаарт, бусад олон салбаруудтай харилцан хамааралтайгаар холбогддог учраас тусгайлсан хуулиар асуудлыг цогц байдлаар бүхэлд нь зохицуулахгүй бол иргэд даатгуулагч, ажил олгогч нарт учирч болох эрсдэл өндөр юм.

1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

1.Тухайн хувь хүн даатгалын компанитай хувийн нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулан даатгуулах харилцаанд нэгдүгээрт, даатгуулагч буюу иргэд болон ажил олгогч, хоёрдугаарт, эрх бүхий даатгалын компаниуд буюу даатгагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөнө.

2.Даатгалын шимтгэл төлөх, тухайн шимтгэлийг тэтгэврийн санд хуримтлуулах, татварын чөлөөлөлт, ногдуулалтад хамрагдах харилцааны хүрээнд даатгагч, даатгуулагч болон ажил олгогч, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, ашиг сонирхол хөндөгдөнө.

3.Санд хуримтлагдсан хөрөнгийг итгэмжлэн удирдах, сангийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхлэх болон сангийн хөрөнгийг хадгалах, бүртгэх, хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангах, хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны зохицуулалт бүхий харилцаанд тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий даатгалын компани, сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах эрх бүхий хуулийн этгээд, даатгуулагч иргэдийн эрх, ашиг хуульд заасан шаардлагын хүрээнд хөндөгдөнө.

4.Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулах үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулагч болон хөрөнгө хүлээн авагч компаниудын эрх, ашиг сонирхол хөндөгдөнө.

5.Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын хүрээнд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий даатгалын компани, сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах хуулийн этгээд, төрийн хяналт тавих, зохицуулах байгууллагын эрх, ашиг сонирхол хөндөгдөнө.

6.Тэтгэврийн даатгалын шинэ төрөл, хэлбэрийн хүрээнд иргэд буюу даатгуулагч, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий даатгалын компани, хяналт тавих, зохицуулалт хийх төрийн байгууллага тухайлбал, төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, ашиг, сонирхол хөндөгдөнө.

1.3.Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

1.Нийгмийн даатгалын сангийн алдагдал, улсын төсвөөс олгох татаасын хэмжээ жил ирэх өсөн нэмэгдэж байгаа, тэтгэвэр авагч иргэдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2013 онд 4 хүн, 2020 он гэхэд 5 хүн, 2040 онд 8 хүн болох урьдчилсан тооцоолол гарсан зэргээс шалтгаалан нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоонд шинэчлэл хийж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог тогтолцоог нэвтрүүлэх шаардлага үүсээд байна.

Даатгуулагч зөвхөн нэг давхаргат тэтгэвэр буюу Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг ба дунджаар 2025 оны эхний улирлын байдлаар 848.6 мянган төгрөг байгаа нь тэтгэвэр авагчийн нийгмийн баталгааг бүрэн хангаж чадахгүй байна.

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал ихэсч байгаагаас хамааран энэхүү дундаж тэтгэвэр хангалттай өсөх боломжгүйд хүрээд байна.

2.Өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл:

2.1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйл, 34 дүгээр зүйл /Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо/;

2.1.2.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.1, 44 дүгээр зүйлийн 44.7, 44.7.3 дахь заалт;

2.1.3.Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.5, 6.6, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 16 дугаар зүйлийн 16.1, 51 дүгээр зүйл;

2.1.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18, 4.1.19, 4.1.32;

Дээрх хуулийн заалтууд нь Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг нэг мөр зохицуулж чадахгүй байгаа тул шинэ зохицуулалт, хууль, эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай байна.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан бол Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ” гэж заасан.

4.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.1-д “нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ” гэж заасан.

5.Улсын Их Хурлын 2015 оны 53-р тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 3.2.18-д “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн гүйцэтгэх бөгөөд эрх бүхий байгууллага эдгээр санд тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих” гэж заасан бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжийн хүрээнд хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулахад хүндрэлтэй, хуулийн зохицуулалтууд хоорондоо харилцан уялдаагүй байгаагаас үүдэн хүндрэл үүсээд байна.

6.Тэтгэврийн шинэ тогтолцоог нэвтрүүлээгүй, уг харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалан олон улсын туршлага, дэвшилтэт талыг нэвтрүүлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ.

ХОЁР.Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох

2.1.Гол зорилго, зорилт

Зорилго 1.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулах тухай хуулиар тэтгэврийн шинэ харилцааг нэвтрүүлнэ:

- a. Даатгуулагч ирээдүйд тэтгэвэр авах олон эх үүсвэртэй болно;
- b. Нэмэлт тэтгэвэр авч амьжиргааны түвшинг сайжруулах;
- c. Төрөөс тэтгэвэр нэмэх ачааллыг хувийн хэвшилд шилжүүлэх.

Зорилго 2.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулах:

- a.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн үйлчлэх хүрээ, зохицуулах харилцааг тодорхой тусгах;
- b.Хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тусгах,
- c.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

Зорилго 3.Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53-р тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хүрээнд нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоог шинэчлэх:

- a. Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх;
- b. Тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн хамрах хүрээг нэмэгдүүлэх;
- c. Тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгал хэлбэрээр дэмжих;
- d. Даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах.
- e. Даатгуулагчийн ирээдүйн тэтгэвэр нь түүний төлсөн тэтгэврийн шимтгэл, өгөөжөөс хамааран тогтоно.

Зорилго 4.Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх:

- a.Дэлхийн улс орнуудын сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх;
- b.Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалт, бодлого, хяналт болон удирдлагыг сайжруулах;
- c.Тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор өндөр орлоготой иргэдийн оролцоог түлхүү хангах;
- d.Олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжоор хангах.

Зорилго 5.Нийгмийн даатгалын харилцаанд үүсэх шинэ харилцааны шинэ төрөл хэлбэрийн зохицуулалтыг бий болгоно:

- a.Шинээр бий болох нийгмийн даатгалын харилцаанд оролцох талуудын эрх, үүргийг тодорхойлох;
- b.Шинэ хуулийн хүрээнд бий болох шинэ санхүүгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн эрх, үүргийг тодорхойлох,
- c.Хадгаламжаас өндөр өгөөжтэй тэтгэврийн хуримтлалтай болсноор хуримтлалын тогтолцоонд шинэчлэл хийнэ.

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, зэрэг болон сөрөг талыг харьцуулах

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

➤ “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:

Дээр тодорхойлсон асуудлууд нь одоогийн хүчин төгөлдөр хуульд зохицуулалт байхгүйгээс үүдэн гарч байгаа тул “тэг” хувилбар оновчгүй нь илэрхий байна.

➤ Хэвлэл, мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:

Уг асуудал нь хуулиар зохицуулагдаагүй тул сурталчилгаа хийснээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

➤ Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:

Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагааг урт хугацааны даатгалын байгууллага эрхлэн гүйцэтгэх учир Санхүүгийн зохицуулах хороо тусгай шаардлагуудыг тавих шаардлагатай. Үүнд:

- a. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;
- b. Дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох;
- c. Хөрөнгө оруулалтын бодлогод зохицуулалт хийх журам;
- d. Бусад шаардлагатай эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглах гэх мэт.

Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалыг даатгуулагч иргэд, ажил олгогч аж ахуйн нэгжүүдэд тэгш, хүртээмжтэй, сайн дураар даатгуулах сонирхлыг төрүүлж, улмаар даатгуулагчийн ирээдүйд нэмэлт баталгаат тэтгэврээр санхүүгийн баталгааг нь хангах зорилгоор урт хугацааны даатгалд төлсөн даатгалын хураамжийг зохих татвараас чөлөөлөх, хөнгөлөгдөх зайлшгүй шаардлагатай бөгөөд хэрэв эдгээр арга хэрэгслүүдийг ашиглахгүй бол хувийн тэтгэврийн нэмэлт даатгал хэрэгжих үндсэн нөхцөл бүрдэхгүй юм.

Иймд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль гарснаар зорилго, хэрэгжүүлэх арга зам, хяналт зэрэг бүхий л асуудлууд цогц байдлаар шийдэгдэх боломжтой гэж үзлээ.

➤ Төрөөс санхүүгийн интервенц хийх:

Төрөөс санхүүгийн интервенц хийх замаар дээрх асуудлуудыг шийдвэрлэх боломжгүй.

➤ Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн гол чиглэл, үйл ажиллагаанд тодорхойлсон асуудлууд нь шинэ зохицуулалт бий болгохтой холбогдохоос гадна хэрэгжүүлэх тал дээр хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран гүйцэтгэхээр тусгаж болох хэдий ч эрх зүйн зохицуулалт бүрэн биш тул энэ хувилбараар шийдвэрлэгдэх боломжгүй юм.

➤ Захиргааны шийдвэр гаргах:

Тухайн асуудлуудыг захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актаар зарим талаар шийдвэрлэх магадлалтай ч бүрэн зохицуулах боломжгүй.

➤ Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах замаар дээрх асуудлуудыг тусгасан зохицуулалтуудыг оруулж цогцоор нь шийдвэрлэх бүрэн боломжтой.

Дээрх хувилбаруудыг нягталж үзэхэд “Тэг” хувилбар, Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар, Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх хувилбар, Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар, Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбарууд үр дүнгүй болох нь харагдлаа. Иймд асуудлуудыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбараар шийдвэрлэх нь зорилгод хүрэх хамгийн үр нөлөөтэй хувилбар гэж үзлээ.

3.2.Зохицуулалтын хувилбаруудын зэрэг болон сөрөг талыг харьцуулсан тухай

1.Захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулсан харьцуулалт:

Хүснэгт 2

№	Зорилго	Сонгож авсан хувилбар	
		Захиргааны шийдвэр гаргах	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах
1	Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулах тухай хуулиар тэтгэврийн шинэ харилцааг нэвтрүүлнэ.	Шинээр нэвтрүүлэх Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаа нь бусад салбар эрх зүйн харилцаатай уялдах тул тухайн харилцааг захиргааны акт гаргах замаар нэвтрүүлэх боломжгүй байна.	Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо нь Монгол Улсын Нийгмийн даатгалын тогтолцоонд шинээр нэвтэрч байгаа тул хууль боловсруулах замаар эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.
2	Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулах	Захиргааны шийдвэр гаргах замаар Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг бүхэлд нь зохицуулж, холбогдох бусад хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулж тухайн харилцааг зохицуулах боломжгүй.	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг баталснаар тухайн харилцааг бүрэн цогц байдлаар шийдвэрлэж, уг хуультайгаа нийцүүлэн бусад хууль, тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.
3	Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53-р тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/-”-ын хүрээнд нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоог шинэчлэх	УИХ-ын 2015 оны 53-р тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын 3.2.18-д “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн	“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 4.2.1-д “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн төслийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах /2015-2016 он/” гэж заасан бөгөөд

		гүйцэтгэх бөгөөд эрх бүхий байгууллага эдгээр санд тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих” гэж заасан бөгөөд нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоог бүхлээр шинэчилж хувийн хэвшлийн оролцоог бий болгох асуудлыг дан ганц захиргааны шийдвэр гаргаснаар зохицуулах боломжгүй.	үүнд Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой хуулийн төсөл мөн хамаарч байгаа юм.
4	Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх	Захиргааны шийдвэр гаргах замаар олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх боломжтой боловч хувийн тэтгэврийн даатгалын харилцаа нь Монгол Улсад шинээр нэвтэрч байгаа тул уг харилцааг хууль боловсруулан зохицуулах нь хамгийн үр дүнтэй байна.	Олон улсад хувийн тэтгэврийн харилцааг хэрхэн зохицуулж ирсэн сайн туршлагыг өөрийн орны онцлогт тулгуурлан нэвтрүүлсэн зохицуулалт бүхий хууль, тогтоомж шинээр боловсруулан уг асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой.
5	Нийгмийн даатгалын харилцаанд үүсэх шинэ харилцааны шинэ төрөл хэлбэрийн зохицуулалтыг бий болгоно	Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудад тэтгэврийн харилцааны шинэ төрөл, хэлбэрийн зохицуулалтууд байхгүй тул эдгээр асуудлуудыг шууд захиргааны шийдвэрээр зохицуулах боломжгүй.	Шинэ төрөл, хэлбэрийн тэтгэврийн тогтолцооны зохицуулалт агуулсан хууль боловсруулах замаар зорилгод хүрэх боломжтой.

Захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулсан харьцуулалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3

Сонгож авсан хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Шинээр нэвтрүүлэх Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаа буюу тэтгэврийн шинэ тогтолцоо, хамрах хүрээг тогтоох, даатгуулагч нэмэлт даатгалд даатгуулах, шимтгэл төлөх, сан бүрдүүлэх, зарцуулах, хөрөнгө оруулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулах, оролцогч талуудын эрх, үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлно.	Хууль хэрэгжүүлэх зорилгоор оролцогч талуудаас тодорхой зардал гарах боловч иргэний хувьд нэмэлт тэтгэврийн орлоготой болох, ажил олгогчийн хувьд ажилтнаа тогтвортой ажиллуулснаар зах зээлд амжилттай оршин тогтнох, тэлэх, эдийн засгийн хувьд хөрөнгө оруулалтын шинэ хэлбэр болсноор эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ.	Үр дүнтэй гэж дүгнэж байна.
Захиргааны шийдвэр гаргах	Асуудлыг байгууллагын хүрээнд шийдвэрлэх боловч Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог цогц байдлаар шийдвэрлэх боломжгүй.	Тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлүүлэхээр зардал байнга гарах боловч асуудлыг шийдвэрлэж, зорилгыг хэрэгжүүлж чадахгүй.	Зардал бага гарах боловч үр өгөөж багатай байхаар байна.

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Сонгогдсон хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан

судлахад, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтнүүд, хувийн хэвшлийн даатгалын компаниуд, ард иргэд, ажил олгогч, ажилтны хууль ёсны эрх, ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийн санал дүгнэлт, судалгааны байгууллагуудын санал, зөвлөмжөөс үзвэл хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй хувилбар болох нь харагдаж байна.

Хуулийн төсөл нь 11 бүлэгтэй байна. Үүнд:

Хуулийн төсөл нь 11 бүлэгтэй бөгөөд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт, хуулийн зорилт, хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр томъёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, нэмэлт тэтгэврийн гэрээ, шимтгэл төлөх, нэмэлт тэтгэврийн нэрийн данс, зардлын ангилал, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн эрх зэргийг тодорхойлно.

Гуравдугаар бүлэгт, хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулах, нэр, дүрэм, хувийн тэтгэврийн сангийн удирдлага, зохион байгуулалт, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхлэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгүүлэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох, бүртгэлээс хасах, дуусгавар болгох үед авах арга хэмжээ, татан буулгах комисс, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн зар сурталчилгаа зэргийг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт хийхэд баримтлах зарчим, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын ангилал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, кастодиан, кастодианд хориглох зүйл, кастодианы үйл ажиллагаанд тавих хяналт, хөрөнгө оруулалтын менежментийн компани, хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах гэрээ, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах зэргийг тусгана.

Тавдугаар бүлэгт, гишүүн хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хооронд шилжих, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг дуусгавар болгох зэргийг тусгана.

Зургадугаар бүлэгт, нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл, эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх, нэмэлт тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг, нэмэлт тэтгэвэр тогтоох, олгох, өргөдөл шийдвэрлэх хугацаа зэргийг тусгана.

Долдугаар бүлэгт, нягтлан бодох бүртгэл, аудит, актуарын тайлан, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч үйл ажиллагаагаа тайлагнах зэргийг тусгана.

Наймдугаар бүлэгт, мэдээллийн нэгдсэн санг тодорхойлно.

Есдүгээр бүлэгт, итгэмжлэгдсэн өмчлөгч үүрэг зөрчих, хариуцлага хүлээлгэх, нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалтыг тодорхойлно.

Аравдугаар бүлэгт, хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд оролцогч төрийн даатгалын байгууллагын чиг үүргийг тодорхойлно.

Арваннэгдүгээр бүлэгт, шилжилтийн үеийн зохицуулалт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг шаардлагатай холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах

4.1.Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Хүснэгт 4

ХҮСНЭГ 14

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, бусад холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж хүн бүр эрх тэгш байдлыг бий болгоно.	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Хүн бүр хувийн нэмэлт тэтгэврийн орлоготой болсноор амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх боломжтой.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ биш болно.

1.2.Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Энэхүү хууль нь бүх хүмүүст ижил тэгш үйлчлэх зарчим дээр үндэслэх тул нийгмийн эмзэг бүлэг, тахир дутуу хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, өндөр настай хүмүүсийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн харилцаанд дахь тэтгэврийн нөхцөлийг сайжруулах зэрэг асуудлууд хөндөгдсөн бөгөөд эдгээр зохицуулалтууд нь олон улсын болон үндэсний хэм хэмжээнүүдэд нийцсэн.
1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Хуулийн төсөл батлагдсанаар аливаа иргэн, хуулийн этгээдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал бий болохгүй.
1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Хуулийн төсөлд ажил хөдөлмөр эрхэлж байгаа мөн хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүн бүр хувийн тэтгэврийн харилцаанд орсноор өндөр настны тэтгэвэрт гарах үедээ орлогын олон талт эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг хийж байгаа бөгөөд нийгмийн даатгал, тэтгэврийн харилцаанд ямар нэгэн ялгаварлан гадуурхах, давуу байдлыг бий болгох зохицуулалт тусгагдаагүй болно. Түүнчлэн аливаа хүн насан туршдаа хөдөлмөрлөсөн хөдөлмөрийнхөө үр шимийг дээд зэргээр хүртэх, өндөр настай хүмүүс бусдаас хамааралгүй амьжиргааны доод түвшинөөс дээгүүр амьдрах боломжийг бий болгож байгаа.
1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан "Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай" 102 дугаар конвенцэд ⁵ дурдсан нийгмийн хамгааллын доод хэмжээний зөвлөмжтэй нийцэж байгаа болно. Мөн Дэлхийн банк, Эдийн засаг болон хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагаас өгсөн зөвлөмжийг тусгасан.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд тэтгэврийн харилцаанд гарсан зөрчилд ногдуулах хариуцлагыг тусгасан.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Хуулиар хүний эрхийг хязгаарлаагүй.

⁵ ОУХБ "ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл" УБ 2012, 330 дугаар тал

	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Хуулиар хүний эрхийг хязгаарлаагүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Төр институт, ажил олгогч, хөдөлмөр эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өндөр настан зэргийн Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд хэрхэн оролцох эсэхийг тодорхойлно.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй оролцох тул эмзэг байдлаар нь ялгах шаардлагагүй болно.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		Шинээр гарах хууль нь сайн дурын, нэмэлт даатгалын байх тул хэн бүхэнд тэгш боломж олгож, одоогийн байгаа нөхцөл байдлыг зохих түвшинд дээрдүүлэх бүрэн боломжтой юм.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй оролцоно.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд, ажил олгогч, хөдөлмөр эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилтны төлөөллүүд, өндөр настан зэрэг нь хуулиар тогтоох харилцаанд үүрэг хүлээх ба эдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгасан.
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Хүйсээр ялгаварлахыг хориглох агуулга хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд тусгагдана.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Хүснэгт 5

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуудлууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүд ижил тэгш байдлаар үйлчлэх тул ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Сайн дурын үндсэн дээр явагдах арга хэмжээ тул шинээр зах зээлд орж байгаа аж ахуйн нэгжид ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм		Хууль тогтоомжийг биелүүлэх үүднээс тэтгэврийн даатгалын шимтгэлд төлөх зардал нэмэгдэнэ. Гэхдээ татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх тул зардал буурах хандлагатай.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт) бий болгох эсэх	Тийм		Мэдээлэл, тайлан, хамтын гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг нэмэлт захиргааны зардал гарна. Гэхдээ энэ зардлын хэмжээ нь хуулийн этгээдэд дарамт болохгүй хэмжээнд байна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		Санхүү болон даатгалын шинэ бүтээгдэхүүн бий болно.

	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд хамрагдсанаар тухайн хүн тэтгэврийн нэмэлт орлоготой болж, ирээдүйн нийгмийн баталгаа хангагдах урт хугацааны зэрэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Улс орны хэмжээнд нэгэн адил үйлчилнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн тэтгэврийн асуудлыг сайжруулна.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Урт хугацааны туршид төрийн нийгмийн даатгалын сангаас төлөх тэтгэврийн ачааллыг бууруулж улсын төсөвт зэрэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Санхүүгийн зохицуулах хороо одоогийн бүтцээр ажиллах боломжтой. Нэмж хувийн тэтгэврийн даатгал хариуцсан мэргэжилтэн, хянан шалгагч авч ажиллуулах боломжтой.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Санхүүгийн зохицуулах хороо хувийн даатгалын харилцааг зохицуулах чиг үүрэг үүснэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ажил эрхлэлтийг дэмжиж тэтгэврийн нэмэлт орлого бий болсноор эдийн засагт зэрэгээр нөлөөлөх боломжтой.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Хувийн тэтгэврийн сангууд бий болсноор тухайн хөрөнгөөр хуульд заасан зохицуулалтын дагуу ур хугацааны хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдэн, хөрөнгө оруулалтын салбар болон санхүү, хөрөнгийн зах зээлд зэрэг нөлөө үзүүлнэ.
	10.3. Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Хүснэгт 6

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Хувийн тэтгэврийн даатгалын сангууд бий болсноор Санхүү болон Даатгалын салбарт шинээр ажлын байр бий болно. Санхүүгийн болон хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалт, санхүүжилт хийснээр жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, ажлын байрыг олноор нэмэгдүүлэх зэрэг нөлөөтэй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Хуулийн төсөлд заасан зохицуулалтууд нь ажил олгогчид шууд болон шууд бус утгаар эдийн засгийн томоохон дарамт, хүндрэл учруулахгүй бөгөөд ажилтныг халах, цомхотгох аливаа нөхцөл байдлыг үүсгэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Шинээр бий болох хуулиар тодорхой ажил, мэргэжлийн болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд эерэг нөлөөллийг бий болгоно. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд оролцож өндөр настны тэтгэврийн асуудлыг өөрт тааламжтай байдлаар зохицуулах боломжтой болно.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бага орлоготой иргэд тэтгэврийн орлого нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгох бөгөөд хүмүүс ажил хөдөлмөр эрхлэх байдлыг дэмжинэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		Хуулийн төсөлд ажилтан хувийн нэмэлт тэтгэврийн шимтгэл төлөх сонголтыг бий болгосноор нэмэлт тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Шинээр ажлын стандарт гаргах шаардлага үүсэхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Тэтгэврийн шинэ харилцааг зохицуулах үүрэг бий болно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		Тэтгэврийн шинэ харилцааг зохицуулах, хяналт тавих үүрэг бий болно.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Хүснэгт 7

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцсэн байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл (Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ)-ийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, 6 дахь хэсэгт “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1 дүгээр зорилтын 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ” гэж зорилт тавьсан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.1-д “нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.3.5.5. Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдүүлж ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.” гэж тус тус заажээ.

Мөн Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн 1-д “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж тус тус заасан.

Иймд сонгож авсан хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцтэй⁶ нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, хууль тэгшээр үйлчлэх зарчимд бүрэн нийцэж байгаа болно.

ТАВ. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх

5.1. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судлахад Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомжийн хүрээнд тулгарч буй а/ Олон улсын хууль тогтоомжид нийцүүлэх, б/ Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулсан бие даасан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, в/ Даатгагч, даатгуулагч, зохицуулах байгууллага болон оролцогч этгээдүүдийн эрх, үүргийг тодорхойлж, зохицуулах зүйл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, г/ Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд төрөөс үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг, д/ Хувийн нэмэлт тэтгэврийн сан, түүнийг бүрдүүлэх, удирдах, хөрөнгө оруулалт хийх, хяналт тавих ажиллагааг хуульчлах, е/ Даатгуулагч этгээд даатгалын гэрээнд заасны дагуу хуульд заасан хугацаанд хүрсэн тохиолдолд нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлж, санхүүгийн хувьд амьжиргааны хэрэгцээгээ бүрэн хангах боломжийг бүрдүүлэхтэй холбогдсон таван үндсэн асуудлыг шийдвэрлэхэд боломжит тэг хувилбар, сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар, эдийн засгийн хэрэгслийг ашиглах хувилбар, санхүүгийн интервенц хийх хувилбар, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хувилбар, захиргааны шийдвэр гаргах /журмаар зохицуулах/ хувилбаруудаас илүүтэйгээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй, оновчтой болох нь харагдлаа.

5.2. Энэхүү тандан судалгаагаар захиргааны шийдвэр гаргах, хууль, тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудыг нарийвчлан харьцуулж үзсэн

⁶ ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ 2012, 330 дугаар тал

бөгөөд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дэлгэрэнгүй судалсан болно.

5.2.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг судалж үзэхэд:

- Холбогдох олон улсын конвенциудад нийцүүлсэн зохицуулалт учир ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх нөхцөлийг бүрэн хангасан;
- Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулахгүй;
- Тодорхой эрх бүхий этгээдүүдийн ялгаатай хэрэгцээг тооцсон зохицуулалтыг тусгасан;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцсэн болох нь харагдаж байна.

5.2.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний хувьд уг хувилбар нь аж ахуйн нэгжүүдэд эдийн засгийн сөрөг нөлөө, нэмэлт зардал учруулахгүй бөгөөд урт хугацаанд Монгол Улсын хөрөнгийн болон санхүүгийн зах зээлд эерэг байдлаар нөлөөлж, хөрөнгийн зах зээлээр дамжуулан эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлж, хурдасгах үндсэн хөшүүрэг, томоохон дэмжлэг үзүүлэх боломжтой байна.

5.2.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөөг судалж үзэхэд:

- Тэтгэврийн заавал даатгалын тогтолцоонд нэмэлтээр, сайн дураар, хуримтлалын зарчимд тулгуурлан хийгдэж байгаа учраас даатгуулагчийн ирээдүйн санхүүгийн баталгааг илүү найдвартай, сэтгэл ханамжтай байх нөхцөлөөр хангах;
- Хувийн нэмэлт тэтгэвэр нь сайн дурын үндсэн дээр хийгдэх даатгал тул тогтмол орлоготой, орлого нь тодорхой бус, албан болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа, малчин хэн бүхэн хамрагдах боломжтой учраас нэг талаас тэтгэврийн асуудлаар төрд ирж буй дарамтыг багасгах, нөгөө талаас иргэд тэтгэвэрт гарсны дараа санхүүгийн баталгаагаар төлсөн хураамжийн хэмжээнээсээ хамаарч хангагдах;
- Төрөөс иргэдэд үзүүлэх нийгмийн хамгааллын бодлогын нэгэн томоохон хэсэг нь болж, МОНГОЛ ХҮН-ий сайн, сайхан амьдрах баталгаа тодорхой хэмжээгээр нэмэгдэх зэрэг олон эерэг нөлөөлөлтэй байна.

5.2.4. Уг зохицуулалтын хувилбар нь байгаль орчны асуудалтай шууд болон шууд бусаар тодорхой холбоогүй байна.

Энэхүү тандан судалгаагаар үндсэн таван асуудал болон бусад холбогдох асуудлуудыг шийдвэрлэх, мөн олон улсын туршлага, цаашдын чиг хандлагад нийцүүлэн шийдвэрлэхийн тулд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

ЗУРГАА. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Аливаа тэтгэврийн орлогын тогтолцооны зорилго нь настай буюу тэтгэвэр тогтоолгосон хүмүүс хэвийн амьдралаар амьдрах боломжийг бүрдүүлэх эх үүсвэрээр хангахад оршино. Өнөөдрийн тэтгэврийн насны хүмүүсийн орлого хуучны тэтгэврийн тогтолцооноос ихээхэн хамааралтай учраас шинэ үеийн тэтгэврийн тогтолцоо хэрхэн үр нөлөө үзүүлж байгааг нарийн судлах боломж мөн хомс юм.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын үүднээс Хувийн тэтгэврийн тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн мөн дэлхийд тэтгэврийн тогтолцооны сайн жишгийг тогтоосон нийт 33 улсын тэтгэврийн тогтолцоо, хууль эрх зүйн зохицуулалтыг судлан үзсэн болно. Тухайлбал тэтгэврийн тогтолцооны төрөл, шимтгэлийн хэмжээ, хамрагдах байдал, сангийн удирдлага

зэрэг асуудлын зохицуулалтыг харьцуулан судалсан билээ.

Мөн түүнчлэн Эдийн засаг болон хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын хийсэн Даатгал болон хувийн тэтгэврийн тогтолцооны талаарх харьцуулсан судалгааг судалж улс орнууд өөрсдийн тэтгэврийн тогтолцоог хэрхэн бүрдүүлж боловсронгуй болгосон талаар мөн хувийн тэтгэврийн тогтолцоог шинээр хэрхэн нэвтрүүлсэн талаар харьцуулсан судалгааг гүйцэтгэсэн болно.

Сүүлийн 20-иод жилийн турш улс орнууд эв санаа нэгдлийн болон цалингаас жиших тэтгэврийн тогтолцоог өөрчлөн шимтгэлд суурилсан болон хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх болсон нь судалгаануудаас харагдаж байна. Энэ нь тэтгэврийн орлогод хувийн тэтгэврийн даатгалын тогтолцооны эерэг нөлөө, хувийн тэтгэврийн төлөвлөлтийг хэрэгжүүлсэн эсвэл зайлшгүй байх тулгуур хэсгээр хуульчилсан нь улс орнуудад тодорхой харагдаж байна. Энэхүү судалгаагаар хувийн тэтгэврийн тогтолцооны зохицуулалтыг хэд хэдэн улс орнуудын хүрээнд харьцуулсан бөгөөд хувийн тэтгэврийн хамгийн сайн тогтолцоо бүхий улс орнуудын зохицуулалтыг танилцууллаа. Улс тус бүрээр хувийн тэтгэврийн тогтолцоо, оролцоо, шимтгэлийн хувь, хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтын зохицуулалт гэсэн дэд хэсэг бүрээр нарийвчлан харуулсан.

Зарим нэг улс орны жишээнээс харахад орлогын хэмжээнээс хамаарах тэтгэвэр нь Финланд, Нидерланд болон Швед улсад шууд хувийн тэтгэвэрт хамаардаг. Финланд улсын хувьд ажил мэргэжлийн тэтгэвэр нь хуулиар тогтоосон байдаг бол Нидерланд, Швед улсад хамтын хэлэлцээрээр шийдвэрлэдэг байна. Нөгөө талаар Канад, ХБНГУ, Япон, Их Британи болон АНУ-д ажил олгогч сайн дурын үндсэн дээр шимтгэл төлдөг байна. Ажлаас халагдсан тэтгэмжийг Өмнөд Солонгос Улсад нэг удаагийн төлбөрөөр ажлаас гарч байгаа ажилтанд олгодог зохицуулалт үйлчилдэг байна. Энэ төлбөрийг ажлаас гарч байгаа аль ч насны хүн авах эрхтэй бөгөөд үүнийг хүмүүс өндөр настай болсон хойно ашиглах боломжтой байдаг байна.

Улс бүрийн тэтгэврийн тогтолцооны зохицуулалт өөр байгаа боловч хувийн тэтгэврийн тогтолцоог бүгд нэвтрүүлэн, заавал болон сайн дураар хамрагдах байдлаар шийдвэрлэсэн байна. Ихэнх тохиолдолд өндөр настай хүмүүс амьжиргааны доод түвшинээс дээгүүр амьдрах боломжийг бий болгохоор холбогдох зохицуулалт болон хамгаалалтыг хийсэн нь харагдаж байна. Хуулийн төслийн тандан судлах ажлын хүрээнд гадаад улс орнуудын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийхдээ хувийн тэтгэврийн сайн туршлагыг хэрэгжүүлж, илүү дэвшилттэйгээр зохицуулж байгаа Унгар, Австрали, Казахстан, Польш, Чили, Канад, Швед, Нидерланд, Солонгос, Япон болон АНУ гэсэн улсуудын хувийн тэтгэврийн тогтолцооны товч баримтуудыг энэхүү тандан судалгааны баримт бичигт хавсралт байдлаар оруулсан болно.

Сүүлийн 20-иод жилийн турш улс орнууд цалин авахдаа төлдөг тэтгэврийн тогтолцоог өөрчилж хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх болсон билээ. Тэтгэврийн орлогод хувийн тэтгэврийн тогтолцооны эерэг нөлөө хувийн тэтгэврийн төлөвлөлтийг хэрэгжүүлсэн эсвэл зайлшгүй байх үндсэн хэсгээр хуульчилсан нь улс орнуудын туршлагаас тодорхой харагдаж байна. Энэхүү судалгаагаар хувийн тэтгэврийн тогтолцооны зохицуулалтыг хэд хэдэн улс орнуудын хүрээнд харьцуулан судалсан бөгөөд Монгол Улстай эрх зүйн тогтолцооны хувьд ижил төстэй, мөн газар зүйн тив болгоноос улс сонгож Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын /ЭЗХӨХБ/ улсууд орнуудын

туршлага дээр тулгуурласан болно. Улс тус бүрт хувийн тэтгэврийн тогтолцоо, оролцоо, шимтгэлийн хувь, хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтын зохицуулалт зэргийг тусгасан бөгөөд мөн улс тус бүрийн эрх зүйн эх сурвалжийн онцлогийг харгалзан үзсэн болно.

6.1.Хувийн нэмэлт тэтгэврийн үүрэг, үр нөлөө

ЭЗХАХБ-ын гишүүн Зүүн Азийн орнуудад цалинтай хөдөлмөр эрхлэлт болон хувиараа хөдөлмөр эрхлэлт 65-аас дээш насны иргэдийн орлогын маш чухал эх үүсвэр байдаг. Жишээлбэл Япон Улсад 44 хувь, БНСУ-д 59 хувь байдаг байна.⁷ Хөдөлмөр эрхлэлтээс олох орлого Чех, Грек, Ирланд, Португали, Испани болон АНУ-ын ахмадуудын орлогын дөрөвний нэгээс доошгүй хувийг бүрдүүлдэг. Эдгээр орнуудын заримд нь ахмадууд улсын тэтгэвэрт хангалттай хугацаагаар шимтгэл төлөөгүй тул ажил хийж орлогоо нэмэгдүүлэхээс аргагүй байдгаас тэтгэврийн насанд хүрсэн хойноо үргэлжлүүлэн хөдөлмөр эрхэлдэг. Харин эсрэгээр Франц, Нидерланд болон Швед зэрэг орнуудад хөдөлмөр эрхлэлтээс олох орлого ахмадуудын орлогын 10 хүрэхгүй хувийг бүрдүүлдэг байна.

Орлогын бүрдэл нь орлогын түвшингээс ихээхэн хамааралтай бөгөөд бага орлоготой ахмадуудын орлогын дийлэнх хэсгийг төрөөс олгох тэтгэвэр, тэтгэмж эзэлдэг бол өндөр орлоготой ахмадуудын хувьд хувийн тэтгэврийн сангийн орлого гол эх үүсвэр болж байна. Үүнээс үүдэн дэлхийн олон оронд албан журмын хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгон хөгжүүлэх бодлого хэрэгжиж байна.

Чили, Эстони, Мексик, Польш, Словак, Швед зэрэг орнуудад хувийн тэтгэвэр нь улсын тэтгэврийг бүхэлд нь, эсвэл орлогоос хамаарах хэсгийг нь хэсэгчлэн орлохоор зохион байгуулагдаж байгаа бол, харин Австрали, Норвеги зэрэг улсуудад хувийн тэтгэврийн систем нь одоо байгаа улсын тэтгэврийн даатгал дээр нэмж даатгалын үйлчилгээ санал болгодог. Нийт ажиллах хүчний 60 хувь нь албан ёсоор тэтгэвэрт хамрагддаг Чили улсын ахмад настнууд орлогынхоо 80 хувийг хувийн тэтгэврээс авч байна.⁸

Дээрх улсуудын нөхцөл байдлаас харахад улсын тэтгэврийн тогтолцооноос олгох тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ буурч байгаа нь хувийн тэтгэврийн тогтолцоонд шилжих нэг гол хүчин зүйл болж байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын тэтгэврийн тогтолцоо⁹

						Хүснэгт 8
No	Улсууд/ Тогтолцоо	Нийгмийн халамжийн тогтолцоо	Олон нийтийн заавал тэтгэврийн тогтолцоо	Олон нийтийн сайн дурын тэтгэврийн тогтолцоо	Хувийн заавал тэтгэврийн тогтолцоо	Хувийн сайн дурын тэтгэврийн тогтолцоо
1	Аргентин	+	+			+
2	Австрали	+	+	+	+	+
3	Боливи	+			+	
4	Бразил		+			+
5	Канад	+	+			+
6	Чили	+			+	
7	Колумб		+			+
8	Коста Рика	+	+			+

⁷ Ричард Хинз, Роберт Холзменн, Дэвид Туеста, Норуюки Такаяма, "Шимтгэлд дүйцэх татаастай тэтгэврийн хөтөлбөрүүд", х-9, Дэлхийн Банк, MSTA Project, 2015 он.

⁸ ЭЗХАХБ, Вайтхауз, 2009 он.

⁹ Эх сурвалж: (OECD, 2008) Судлаачийн нэгтгэл

9	Чех		+			+
10	Эл Салвадор		/DC - fully funded/			
11	Эстони		/DC - fully funded/			+
12	Хонг Конг	+	+	+		+
13	Унгар	+	+		+	+
14	Япон	+	+	+		+
15	Казахстан	+	/defined contribution/			
16	Мексик		/defined benefit/		+	+
17	Нидерланд		+	+		+
18	Перу	+			+	+
19	Польш	+	+	+	+	+
20	Швед		+		+	+
21	Их британи	+	+	+		+
22	АНУ	+		+		+
23	Уругвай	+				+
Тогтолцооны хувь		65%	78%	30%	35%	83%

Дээрх улс орнуудын хувьд нийгмийн халамжийн тогтолцоо, олон нийтийн заавал тэтгэврийн төлөвлөгөө, олон нийтийн сайн дурын тэтгэврийн төлөвлөгөө, хувийн заавал тэтгэврийн төлөвлөгөө, хувийн сайн дурын тэтгэврийн төлөвлөгөө хэмээх 5 тогтолцоо нь ялгаатай байгааг харж болохоор байна. ЭЗХАХБ-ын гишүүн улсуудын 65 хувь нь нийгмийн халамжийн тогтолцоо буюу шимтгэл төлсөн эсэхээс үл хамааран тодорхой тэтгэвэр болон тэтгэмж авах боломжтой болох нь харагдаж байна.

Мөн 78 хувь нь олон нийтийн заавал даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд зарим улс орнуудын хувьд шимтгэлд суурилсан бүрэн хуримтлалын тогтолцоотой байдаг бол зарим улс орнуудын хувьд тэтгэвэрт суурилсан PAYG тогтолцоотой байдаг нь судалгаагаар ажиглагдсан. Энэхүү тогтолцоо нь ихэвчлэн төрийн удирдлагад явагддаг бөгөөд ажил олгогч болон ажилтан тодорхой хувь хэмжээгээр шимтгэл төлдөг бөгөөд тэдний төлсөн шимтгэл нь тогтолцооноос хамааран хуримтлагдах, үл хуримтлагдах системээр ажилладаг.

Дээрх тогтолцоонуудаас харахад хамгийн их буюу 83 хувийг сайн дурын хувийн тэтгэврийн төлөвлөгөө эзэлж байгаа нь тухайн улс орнуудын хувьд олон нийтийн заавал даатгал болон халамжийн тогтолцооноос орж ирэх орлогын хэмжээг хангалттай гэж үзэхгүй байгаа учраас сайн дурын тэтгэврийн тогтолцоог хүчтэй хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгардаг байна.

6.2.Хувийн тэтгэврийн даатгалд хамрагдах

ЭЗХАХБ-ын гишүүн 34 орны 14-т хувийн тэтгэврийн даатгал албан журмын, эсвэл хагас албан журмын байдлаар хэрэгжиж байна. Ажиллаж буй байгууллагаар дамжуулан даатгагдах тэтгэврийн даатгал Финлянд, Исланд, Норвеги болон Швейцарьт албан журмын хэлбэртэй бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын 70-80 хувь нь энэ даатгалд хамрагддаг. Хагас албан журмын даатгал Дани, Нидерланд, Швед улсуудад маш өргөн дэлгэрсэн бол ЭЗХАХБ-ын гишүүн 8 орон хувиараа даатгуулах албан журмын даатгалын тогтолцоотой.

Сайн дураар даатгуулах даатгалд хамрагдалтын хувь хэмжээ Чех, ХБНГУ, Шинэ Зеланд, Норвеги, Их Британид 50 хувиас илүү байдаг бол Грек, Люксембург, Мексик, Португали, Турк зэрэг орнуудад маш бага байдаг байна. /Хүснэгт-1/

Хувийн тэтгэврийн даатгалын хамрагдалт болон иргэдийн нас, орлогын

хоорондын хамаарал Канад, Ирланд, Их Британи, АНУ зэрэг орнууд төстэй байдаг бол ХБНГУ-д залуучууд болон бага орлоготой ажилчдын дунд хамрагдалт өндөр байдгаараа бусад орнуудаас ихээхэн ялгаатай. Энэ нь англо саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад тэтгэврийн систем нь суурь тэтгэврийн системээр, эсвэл тэтгэврийн тооцооллын томьёонд орлогоос хамаарах механизм суулгах замаар мөн энэ хоёр аргыг хослуулсан байдлаар хэрэгжүүлдэг. Их Британи зэрэг улсад өндөр орлоготой иргэдээс бага орлоготой иргэдэд орлогыг дахин хуваарилах нөхцөлтэй холбоотой байх магадлалтай. Иймд эдгээр орнуудад бага орлоготой болон өндөр орлоготой тэтгэвэр авагчдын авах тэтгэврийн ялгаа их байдаггүй, харин ХБНГУ-д энэ ялгаа нь өндөр байна.

6.3.Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хандах олон улсын татварын бодлого, чиг хандлага

Хувийн тэтгэврийн даатгалд хамрагдалтыг урамшуулах гол бодлого нь энэ төрлийн тэтгэврийн тогтолцоонд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх явдал юм. Тухайлбал, тэтгэврийн хуримтлалд өндөр хүү олгосноор иргэдэд даатгалд хамрагдах урамшуулал өгнө гэсэн санааны илэрхийлэл юм.

Тэтгэврийн хуримтлалыг нэмэгдүүлэх зорилгоор Хувийн нэмэлт тэтгэврийн сан бүрдүүлэх асуудлыг төрөөс дэмжиж ирсэн байна. Ялангуяа сайн дурын хувийн тэтгэврийн даатгалын хамралтыг өсгөхийн тулд санхүүгийн хөшүүрэг зайлшгүй шаардлагатай юм. Төрөөс сайн дурын хувийн тэтгэврийн хуримтлал бий болгох асуудлыг дэмжих зорилгоор олон улс орнууд татварын чөлөөлөлт, хөнгөлөлт болон санхүүгийн бусад урамшууллын бодлогыг санал болгодог. Нөгөө талаар татвараас зайлсхийх, зугтаах сэдлийг хязгаарлаж өгөхийн тулд урамшуулал, дэмжлэгийн дээд хязгаарыг хуулиар зааж өгдөг, зохицуулдаг байна.

Судалгаагаар улс орнуудын татварын хөнгөлөлт болон санхүүгийн бусад урамшуулал нь тэтгэврийн хураамжид хэрхэн нөлөөлдөг талаар судалсан болно. Татварын хөнгөлөлт нь ихэнх тохиолдолд тэтгэврийн хуримтлалыг дэмжих зорилгоор шимтгэл болон хөрөнгө оруулалтын орлогыг татвараас чөлөөлдөг бөгөөд тэтгэвэр олголт, эсвэл сангаас буцаан олголтод татвар ногдуулдаг байна. Үүнээс гадна санхүүгийн бусад урамшууллууд байдаг бөгөөд эдгээр нь нийт дүнгийн төлбөр (lump sum payment), хуваарьт буцаан олголт, насан туршийн тэтгэмж (annuity benefit) зэрэгт өөр өөрөөр нөлөөлдөг. Судалгаагаар дийлэнх улс орнуудад даатгуулагч иргэний төлөх хувийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх, ажил олгогчийн зүгээс ажилтныхаа хувийн тэтгэврийн санд төлөх шимтгэлийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, татвар ногдох орлогоос хасагдах зардлын тооцоо, хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийг орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх, даатгуулагч тэтгэвэр авах үед нөхөж авах, тэтгэвэр олгох хүртэл хойшлуулах зэрэг олон арга замаар шийдсэн байна.

Эв санааны болон цалинд жишсэн улсын тэтгэврийн тогтолцооноос хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоо руу бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн шилжих явцад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон урамшууллын бодлого нь нэн чухал ач холбогдолтой. Дээр дурдсанаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэт өндөр тавих нь тэтгэврийн хуримтлалыг дэмжих хэдий ч улсын болон орон нутгийн татварын орлогын төсөв алдагдалд орох, талуудын татвараас зайлсхийх сэдлийг өдөөх магадлалтай. Мөн өндөр орлоготой иргэд илүү ихээр татварыг хөнгөлөлтөд хамрагдах боломж бий болсноор хуваарилалтын үр дагавар нь мөн таагүй гарах

магадлалтай. Тухайлбал, тэтгэврийн тогтолцоо нь төлөвшсөн Нидерланд, АНУ, Швейцар болон Англи улсуудад тэтгэврийн сан нь дунджаар Дотоодын нийт бүтээгдэхүүний 85 хувийг эзэлдэг байна. Хувийн тэтгэвэр нь хувийн хэвшлийн хуримтлалын урсгалын нэг чухал хэсэг бөгөөд салбарын мөнгөн хуримтлалын чухал бүрэлдэхүүн болж тэтгэврийн орлогод томоохон байр суурь эзлэх болсон. Энэхүү тоон баримтууд тэтгэврийн тогтолцоонд татварын хөнгөлөлтийн асуудлыг анхааран авч үзэх нь чухал ач холбогдолтойг харуулж байна.

Хувийн тэтгэврийн даатгалын харилцааны дараах 3 үе шатанд татвар ногдуулах болон татвараас хөнгөлөх, чөлөөлөх боломжтой байдаг. Үүнд:

1. Даатгуулагч болон ажил олгогчоос хувийн тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлөх үед,
2. Тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын болон хуримтлалын орлого, өгөөж бий болсон тохиолдолд,
3. Даатгуулагч тэтгэвэр авах, нэг доор болон хэсэгчлэн буцаан авалт хийх үед.

Нэгдүгээр хувилбар, тэтгэврийн шимтгэл цуглуулалт болон сангийн хөрөнгө оруулалтын орлогыг татвараас чөлөөлж, тэтгэвэр олгох үед татвар ногдуулдаг. Үүнийг татвараас чөлөөлөх, чөлөөлөх, ногдуулах (EET - exempt, exempt, taxable) гэж томъёолдог. Энэ хувилбарын хувьд хувийн тэтгэврийн даатгалын хамрагдалтыг өсгөх, богино хугацаат хуримтлалаас урт хугацаат тогтвортой хуримтлал үүсгэх, тухайн хуримтлалыг эдийн засагт үр ашигтайгаар ашиглах зорилгоор төрөөс татварын бодлогоор дэмжиж буй хэлбэр буюу өнөөдрийн татварыг ирээдүй уруу хойшлуулж буй систем юм. Хоёрдугаар хувилбар нь төлж буй шимтгэлд татвар ногдуулж, харин сангийн хөрөнгө оруулалтын орлого болон тэтгэвэр олгоход татвараас чөлөөлдөг байна. Үүнийг татвар ногдуулах, чөлөөлөх, чөлөөлөх хувилбар буюу TEE - Taxable, exempt, exempt гэж томъёолно. Энэ хувилбар бол ихэвчлэн хувийн тэтгэврийн заавал буюу албан журмын даатгалын тогтолцоотой нөхцөлд байдаг, сангийн хөрөнгө оруулалт болон ирээдүйн тэтгэврийг татваргүй олгох төрийн дэмжлэг бодлого юм.

Гурав дахь хувилбар нь шимтгэл болон сангийн хөрөнгө оруулалтын орлого хоёрт татвар ногдуулж, тэтгэврийн олголтыг татвараас чөлөөлдөг. Үүнийг ногдуулах, ногдуулах, чөлөөлөх буюу TTE-taxable, taxable, exempt гэж томъёолно. Мөн зарим тохиолдолд шимтгэлийг татвараас чөлөөлж сангийн хөрөнгө оруулалтын орлого болон тэтгэвэр олголт дээр татварыг ногдуулах хувилбар буюу үүнийг чөлөөлөх, ногдуулах, ногдуулах буюу ETT-exempt, taxable, taxable байдаг.

Судалгаагаар хувийн тэтгэврийн даатгалын шимтгэлд болон сангийн хөрөнгө оруулалтын орлогод ногдуулах татварын хөнгөлөлтийн хэмжээн улс болгонд өөр өөр байгаа нь тухайн улс хувийн тэтгэврийн даатгалын хамралт, ач холбогдлыг хэрхэн анхааран дэмжиж байгаагаас шалтгаална.

Хэдийгээр төр өнөөдөр хураах татварын зарим хэсгийг татвараас хөнгөлж, чөлөөлж өгснөөр татварын орлого бүрдүүлэлтэд сөрөг нөлөөлөх ч тэтгэврийн даатгалын сангууд нь урт хугацаатай, даатгуулагч болон ажил олгогчийн төлсөн шимтгэл сангаар дамжих улс орны эдийн засагт хөрөнгө оруулалт байдлаар үр ашгаа өгч байдаг. Тэтгэврийн сангийн хөрөнгийн зарим хэсгээр Засгийн газрын үнэт цаас, Нийслэлийн болон орон нутгийн бонд худалдан худалдан авснаар улсын болон орон нутгийн төсвийн алдагдлыг нөхөх, төсвийн удирдлагын бодлогод эергээр нөлөөлөх боломжтой байдаг. Төр өнөөдөр татварын орлогоор төсөв тасарч

буй мэт харагдавч урт хугацаандаа төр, эдийн засаг, аж ахуй нэгж байгууллагууд, иргэд бүхий л талууд тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашгийг хүртдэг байна.

6.4. Татварын хөнгөлөлттэй холбоотой улсын төсвийн зардал

Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд татварын бодлогоор дэмжлэг үзүүлснээр төсөвт орох байсан тодорхой хэмжээний орлого алдагдах бөгөөд эдгээрийг татварын зардал хэлбэрээр тоон утгад шилжүүлэн тооцоолж ирсэн.

Төсвийн зардлаа хэмнэхийн тулд ЭЗХАХБ-ын гишүүн олон оронд зардлуудаа нэгтгэх арга хэмжээ авч байна. Жишээлбэл, Чили болон Польш улсуудад сүүлийн жилүүдэд сайн дураар даатгалд хамрагдах байдлыг нэмэгдүүлэх үүднээс тэтгэврийн хөтөлбөрт олгох татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх хуулийг баталж татварын урамшуулал олгосон байна.

Австрали, Исланд, Норвег болон Швейцар зэрэг улсад сайн дураар даатгуулах хувийн даатгалд хамрагдах байдал өндөр байсаар ирсэн бөгөөд Засгийн газраас ажил олгогчдод ажилчдаа тэтгэврийн даатгалд хамрагдах боломж олгон тэдний өмнөөс шимтгэл төлөх шаардлага тавьж ирсэн билээ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагын орнуудын Хувийн нэмэлт тэтгэврийн татварын харилцаа:

Хүснэгт 9

Хүснэгт 9

Улс	Шимтгэл	Тэтгэврийн сан		Тэтгэврийн үнэлгээ		Тайлбар	
		ХОАТ	Улсад татвар	ХОАТ/ХОТ			
		Сангийн орлого	Сангийн орлого	Сангийн үнэлгээ	Тэтгэврийн хөтөлбөр		Нэг дор төлөх
Австрали	9.5%						Анхны 1000 А\$ шимтгэлд 10 хувийн татварын хөнгөлөлт олгоно. Орлого 27 000 \$А хэтэрсэн үед хасна, сангийн орлого дээр 15 хувийн татвар ногдуулдаг, 77 000 А\$ дээш нэг удаагийн төлбөрт 16.5% татварын ногдуулна, тэтгэврийн орлого 15% татварын хөнгөлөлт үзүүлнэ, суутгаж буй шимтгэлийг нэмэлт тэтгэмж гэж үзнэ
Ажилчин			1%			PE/16.5%	
Ажил олгогч			1%			PE/16.5%	
Австри	T/PE						Шимтгэлийн 50%-д сутгалын таазыг зааж өгдөг, хувь хүний шимтгэлийн тэтгэврийн төлбөрийн 25% татвар ногдуулна, буцаан олголтыг эрт авсан тохиолдолд 30% татварын торгууль төлнө
Ажилчин					T/PE	T/PE	
Ажил олгогч							
Бельги	T/PC						Шимтгэлийн суутгал дээр хязгаарлалт хийдэг, сангийн хөрөнгө дээр
Ажилчин				0.17%	T/PC	10%	
Ажил олгогч				0.17%	T/PC	16.5%	

							0.17% татвар ногдуулна, тэтгэврийн төлбөр дээр татварын кредит олгодог бол эрт авсан тохиолдолд 10% татвар төлнө
Канад							
Ажилчин	E	E	E	E	T	T	Тэтгэврийн орлогын 1000 C\$ дээр 17% үндсэн хураамжийн тэтгэврийн орлогын хөнгөлөлт
Ажил олгогч							
Дани						T	Жинхэнэ хүүнд татвар ногдуулна
Ажилчин		E	15%	E	T	40%	
Ажил олгогч							
Финланд							Шимтгэлийн 60% нь тодорхой тааз хүртэл суутгалтай
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Франц							
Ажилчин	T	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Герман							
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Исланд							
Ажилчин	T	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Ирланд							
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Япон							Шимтгэлийн цэвэр орлого дээр стандарт хураамж бүхий татвар төлдөг, 500 000 иеннээс дээш нэг удаагийн тэтгэврийн буцаан олголтонд 50%-д татвар ногдуулна
Ажилчин							
Ажил олгогч	T	E	E	E	T	E	
Люксембург							
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Нидерланд							
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Шинэ Зеланд	21%						
Ажилчин	T	E	33%	E	E	E	
Ажил олгогч	T		33%				
Норвеги							
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Португали					T	T	
Ажилчин	E	E	E	E	20%PE	T/PE	
Ажил олгогч					20%PE	T/PE	
Испани							
Ажилчин	E	E	E	E	T	T	
Ажил олгогч							
Швед			T				
Ажилчин	E	E	15%	E	T	T	
Ажил							

олгогч							
Швейцарь							
Ажилчин	Е	Е	Е	Е	Т	Т	
Ажил олгогч							
Англи							
Ажилчин	Е	Е	Е	Е	Т	Т	
Ажил олгогч							
АНУ							
Ажилчин	Е	Е	Е	Е	Т	Т	59 наснаас өмнө тэтгэврийн хуримтлалаа авсан тохиолдолд 10 татварын торгууль төлнө
Ажил олгогч							
Солонгос							
Ажилчин	Е	Е	Е	Е	Т	Т	
Ажил олгогч							
Унгар							
Ажилчин	Т	Е	Е	Е	Е	Е	Заавал хамрагдах буюу төлөгдөх шимтгэлд татвар ногдуулна, харин сайн дурын шимтгэлийг татвараас чөлөөлнө
Ажил олгогч							
Польш							
Ажилчин	Е	Е	Е	Е	Т	Т	
Ажил олгогч							

ХХОАТ–Хувь хүний орлогын албан татвар;

ХОТ–Хөрөнгийн орлогын татвар;

Е–татвараас чөлөөлсөн;

Т–татвар ногдуулсан;

РЕ–татвараас хэсэгчилсэн хөнгөлөлт;

РС–татварын кредит.

Тэтгэврийн хадгаламжид ногдох татварын урамшууллын бусад хадгаламжтай харьцуулсан хэмжээ улс орнуудын хооронд ихээхэн ялгаатай байна. Тухайлбал Мексик болон Шинэ Зеландад урамшуулал бараг тэгтэй тэнцүү байхад Чех улсад 40 хувь байдаг. Ихэнх орнууд 10 хувиас дээш урамшуулалтай ба улсуудын дундаж урамшууллын хэмжээ 20 орчим хувьтай байна.

Хүснэгт 10¹⁰

д/д	Улсууд	Шимтгэлийн түвшин			Тайлбар
		Ажил олгогч	Ажилтан	Нийт	
1	Унгар	18.0%	8.5%	26.5%	Ажил эрхлэгчийн төлж буй шимтгэлийн 1.5 хувь нь PAYGO системд үлдсэн 7.5% нь хувийн дансруу явдаг байна. Хуучин системийг сонгож буй хүмүүсийн хувьд нийт 19.5 хувийн шимтгэлтэй бөгөөд ажил олгогч 18 хувийг, ажил эрхлэгч 1.5 хувийг төлдөг байна.
2	Польш	9.8%	9.8%	19.5%	Нийт шимтгэлийн 12.2 хувийг төр удирддаг бол 7.3 хувийг хувийн тэтгэврийн сан удирддаг. Нийт шимтгэлийн хэмжээ дундаж цалингийн 2.5 дахин нэмэгдүүлсэн дүнгээс хэтрэхгүй байхаар тогтоодог.
3	Их Британи	14.5%	4.3%	18.8%	
4	Швед	9.3%	9.3%	18.5%	Нийт шимтгэлийн 16 хувийг хийсвэр нэрийн дансанд байршуулах бол үлдсэн 2.5 хувийг бүрэн хуримтлал бүхий хувийн дансанд байршуулдаг.

¹⁰ Эх сурвалж: (OECD,) Судлаачийн нэгтгэл

5	Канад	18.0%	18.0%	Ажил олгогч болон ажилтнаас авах шимтгэлийн хэмжээ хамгийн ихдээ 18 хувь бөгөөд 18,000 Канад доллараас хэтрэхгүй байна. Ажил олгогчийн төлөх шимтгэл хамгийн багадаа 1 хувь байна.
6	Нидерланд	10.8%	5.3%	16.1%
7	Колумб	4.0%	12.0%	16.0%
8	Уругвай		15.0%	15.0%
9	Япон	7.1%	7.1%	14.2%
10	Эл Салвадор	6.8%	6.8%	13.5%
11	Аргентин	11.0%	1.6%	12.6%
12	Чили		12.3%	12.3%
13	Болив		12.2%	12.2%
14	Перу		10.5%	10.5%
15	Хонг Конг	5.0%	5.0%	10.0%
16	Казахстан		10.0%	10.0%
17	Бразил		4-10%	10%
18	Австрали		9.0%	9.0%
19	АНУ		7.3%	7.3%
20	Коста рика	4.8%	2.5%	7.3%
21	Мексик	1.1%	5.4%	6.5%

22	Эстони	4.0%	2.0%	6.0%	Ажилчдын төлж буй шимтгэлийн 33% нь нийгмийн татвар болдог бөгөөд нийгмийн халамжийн тэтгэмжид төлөгддөг. Хувь хүний зайлшгүй тэтгэврийн дансанд нэмэлтээр сайн дурын шимтгэл байршуулах боломжгүй байдаг байна.
23	Чех		<CZK 100/month	0.0%	Шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоотой учир шимтгэлийн хувь хэмжээг зааж өгдөггүй. Ихэнх тохиолдолд 50 - 150 CZK хооронд шимтгэлийн хэмжээ хэлбэлздэг. Нийт ажил олгогчдын 3 хувь нь хувийн тэтгэврийн дансанд нь хуримтлал үүсгэдэг.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувьд шимтгэлийн хувьд хэмжээ дээрх байдалтай байдаг байна. Унгар улсын хувьд хамгийн өндөр шимтгэлийн хувийг санал болгодог бөгөөд ажил олгогч тал дийлэнх хэсгийг буюу 18 хувийг төлдөг байна. Дээрх улс орнуудын хувьд тэтгэвэрт суурилсан, шимтгэлд суурилсан тогтолцоотой бөгөөд тогтолцооны шинж чанараас хамааран шимтгэлийг ялгаатай байдлаар хуваарилдаг.

6.5.Дүгнэлт

Олон улсын туршлагыг судлахад бүх оронд тохирох тэтгэврийн тогтолцооны туйлын хувилбар гэж байхгүй бөгөөд улс орон бүр эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээл, татварын орчин, хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин зэрэг өөрийн онцлогуудад тохирсон тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлж ирсэн байна. Тэтгэврийн тогтолцооны үндсэн зорилго нь ахмад настны амьдралын баталгааг хангах, ажил хөдөлмөрийн чадваргүй болсон үед ядуурлаас хамгаалах гол зорилгыг агуулж байдаг тул хөдөлмөр эрхэлж байх үедээ тэтгэврийн даатгалд хамрагдах, тухайн хамрагдах сэдлийг төрүүлж, санхүүгийн болон татварын бодлогоор төрөөс дэмжих, сангийн удирдлага, хөрөнгө оруулалтыг хариуцан эрхэлж байгаа хуулийн этгээдэд татварын таатай нөхцөлийг санал болгох байдлаар хэрэгждэг байна.

ДОЛОО. Зөвлөмж

Монгол Улсад одоогоор хэрэгжиж буй тэтгэврийн нэг давхаргат тогтолцооны хүрээнд тэтгэвэр авагч иргэдийн ихэнх хэсэг тэтгэврийн доод хэмжээний тэтгэвэр авдаг, авч буй тэтгэвэр нь иргэдийн амьжиргаа, нийгмийн баталгааг хангахад хангалтгүй, хүрэлцээ муутайгаас ядуурлыг бууруулж, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч 2024 онд 531.8 мянга байсан бол 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэхээр байна. Өөрөөр хэлбэл, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 хүн, 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байна.

Өнгөрсөн зуунд улсын, цалинд жишсэн тэтгэврийн DB систем дэлхий дахинд голлох системийн төрөл болж байсан бол хүн амын насны бүтэц өөрчлөгдөх, тэтгэврийн систем төлөвшихийн хэрээр хуваарилалтын тогтолцоо нь санхүүжилтийн хувьд тогтворгүй болж, хуримтлалын DC тогтолцоонд шилжих хандлага ихэссэн. Түүнчлэн иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг цаашид төр дангаар хариуцах бус хувийн хэвшлийн оролцоог хувийн тэтгэврийн нэмэлт даатгал хэлбэрээр татан оруулах, төрд үүсэж буй эрсдэл болон зардлыг хамтран хүлээх

эрмэлзэл бий болсон.

Хувийн тэтгэврийн нэмэлт даатгал нь бүрэн хуримтлалын системд тулгуурлаж буй нөхцөлд хэд хэдэн тулгамдаж буй асуудлууд байгаа нь даатгуулагчийн эрх ашгийн хамгаалах зохицуулалт, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлого, хяналт, засаглал удирдлагын тогтолцоо байна. Бага болон дунд орлоготой орнуудын хувьд зөвхөн цалинд жишсэн тогтолцоогоор явах нь ирээдүйд бага хэмжээний тэтгэвэр тогтоолгох магадлал өндөр тул тэтгэврийн доод хэмжээг дээш татахын тулд өндөр орлоготой иргэдийн оролцоог түлхүү хангах, хувийн тэтгэврийн орчинг бүрдүүлэх замаар ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжоор давхар дэмжих нь чухал юм.

Манай улсын хувьд хэдийнээ хувийн тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүнүүдийг даатгалын компани, төрийн бус байгууллага, хязгаарлагдмал хувьцаат компаниуд олон нийтэд болон хаалттай хэмжээнд санал болгож, борлуулаад эхэлсэн байна. Мөн нэлээд олон төрлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд ийм төрлийн үйл ажиллагааг эхлүүлэх санал санаачилга гаргаж, зарим нь судалгаа шинжилгээ хийгээд эхэлсэн байна. Хэдий тийм боловч тухайн үйл ажиллагаа нь банкны хугацаат хадгаламжаас ялгарах давуу талгүй, хууль эрх зүйн орчин бүрдээгүй, санхүүгийн болон татварын бодлогоор дэмжээгүй, урт удаан хугацаанд оршин тогтнох баталгаагүй зөвхөн ажил олгогчийн зүгээс дэмжсэн тохиолдолд даатгуулагч, ажилтан хамрагддаг хандлагатай байна.

Монгол Улсын нийт хүн амын дийлэнх хэсэг санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг өргөн хэрэглэдэг, тэр дундаа банкны үйлчилгээг тогтмол хэрэглэдэг, санхүүгийн мэдлэг боловсрол нь тэтгэврийн нэмэлт тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн орнуудын түвшинд дүйцэхүйц байна. Энэ нь хувийн тэтгэврийн нэмэлт даатгал хөгжих үндсэн суурь хүчин зүйл бөгөөд, тэтгэврийн шинэчлэлийг эхлүүлэх цаг хугацаа нэгэнт болсныг илтгэн харуулж буй хэрэг юм. Цаашлаад улсын тэтгэврийн тогтолцооны сул талыг нөхөх, нэмэлт тэтгэврийн тогтолцооны эрэлт хэрэгцээ өндөр байгаа, банкны үйлчилгээ иргэдэд сайн хүрч чаддаг зэрэг нөхцөлүүд нь хувийн тэтгэврийн даатгал хэрэгжүүлэх боломжтойг илтгэж байна.

Иймд эдгээр асуудлуудаас шалтгаалан нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоонд шинэчлэл хийж, шинэ тогтолцоог нэвтрүүлэх, олон улсын чиг хандлага, туршлага зэргийг харгалзан үзэж Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалтай холбоотой бүхий л харилцааг бүрэн цогц байдлаар зохицуулсан бие даасан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Улсын их хуралд өргөн барьж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Нэг талаас энэхүү харилцаа нь нийгмийн өргөн хүрээг хамарсан, олон хүний эрх ашиг, санхүүгийн баталгааг удаан хугацаанд баталгаажуулах зэрэг ирээдүйд үүсэх харилцааг зохицуулах шаардлагатай болох бөгөөд нөгөө талаас олон даатгуулагчийн урт хугацаанд цуглуулж, хуримтлуулсан сан /мөнгөн хөрөнгө/-г хэрхэн зөв, оновчтой удирдах, баталгаажуулах, хяналт тавих, зохицуулах зэрэг асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай юм.

Өнөөгийн эрх зүйн тогтолцооны хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаа, даатгагч, даатгуулагчийн эрх үүргийг тодорхойлсон, сангийн хөрөнгийн найдвартай байдалд хяналт тавих, урт хугацаанд даатгуулагчийн эрх ашгийг бүрэн хамгаалах хэмжээнд хууль, эрх зүйн орчин дутмаг байна. Иймээс төрийн бодлогын хүрээнд дээрх шинэчлэлийг хийхэд нэн тэргүүнд хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж,

Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулах бие даасан хууль боловсруулах шаардлагатай байна.

Бие даасан хуулиар дараах асуудлуудыг нарийвчлан зохицуулах шаардлагатай. Тухайлбал:

1.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааны хамрах хүрээ, зарчим, тухайн харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлон хуульчлах;

2.Хувийн нэмэлт тэтгэврийн шимтгэлийн хэмжээний дээд хязгаарыг тогтоох болон шимтгэлийн хэмжээг тогтооход баримтлах бодлого *ДНБ, инфляцийн түвшинтэй уялдуулах гэх мэт*-ыг хуульчлах;

3.Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болзол, шалгуур, зөвшөөрөл олгох журмыг тогтоох;

4.Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн бүрдэл, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог нарийвчлан хуульчлах;

5.Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн удирдлага, хөрөнгө оруулалт хийх хөрөнгө, түүний дээд хязгаар, тархаан байршуулалт, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалтад хяналт тавих эрх бүхий этгээдийг тогтоож, хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоо, стандартыг тодорхойлж даатгуулагчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;

6.Аудит, нягтлан бодох бүртгэлийн асуудлыг тодорхойлон хуульчлах;

7.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаан дахь төрийн оролцоо, төрөөс үзүүлэх дэмжлэг, татварын чөлөөлөлтийн асуудлыг хуульчлах;

8.Маргаан шийдвэрлэх;

9.Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх салбаруудыг нарийвчлан тогтоох, санг удирдах эрх бүхий хуулийн этгээдүүдийн дүрмийн сангийн хэмжээг тогтоож, санхүүгийн баталгаа, баталгаат өгөөжийн түвшинг тогтоох, хянах зэргээр сангийн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах;

10.Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал зэргийг тодорхойлох;

11.Төрийн байгууллага болон хуулийн этгээдийн хамтын ажиллагаа, эрх, чиг үүргийг тодорхойлох зэрэг тус тус болно.

ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД

Хүснэгт 10

Төрөл	Дугаар	Хууль тогтоомжийн нэр	Зүйл, заалт	Хүчинтэй эсэх
Монгол Улсын хууль	1.	Монгол Улсын Үндсэн хууль	16 дугаар зүйлийн 16.5. “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”	Тийм

2.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	37 дугаар зүйлийн 37.14.5. “нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх”	Тийм
3.	Иргэний хууль	432 дугаар зүйлийн 432.1. “Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна”	Тийм
4.	Даатгалын тухай хууль	3 дугаар зүйлийн 3.6. “Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-3.5-д зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” 6 дугаар зүйлийн 6.1. “Даатгалыг урт хугацааны даатгал, ердийн даатгал гэж ангилна” 6.2. “Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна” 6.5. “Сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно” 6.6. “Даатгагчийн үйл ажиллагаа нь энэ хуулийн дагуу тодорхойлсон ангилал, төрөл, хэлбэрээс өөр байна гэж үзвэл энэ хуульд нийцүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо даатгагчид даалгаж болно” 14 дүгээр зүйлийн 14.1. “Даатгалын үйл ажиллагааг Зохицуулах хорооноос баталсан даатгалын багц дүрмээр зохицуулна” 15 дугаар зүйлийн 15.1. “Зохицуулах хорооноос даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно” 15.2. “Даатгагч энэ хуулийн 15.1-д заасан журмыг заавал дагаж мөрдөх үүргийг хүлээхгүй боловч ийнхүү дагаж мөрдөөгүй нь даатгагчид хариуцлага ногдуулахад түүнийг даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмших тохиромжтой бус этгээд, эсхүл үйл ажиллагаагаа зохистой явуулаагүй гэж үзэх нөхцөл болж болно” 16 дугаар зүйлийн 16.1. “Энэ хуулийн 16.3, 17.2-т зааснаас бусад этгээд Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” 51 дүгээр зүйлийн 51.1. “Урт хугацааны даатгагч нь эрхэлж буй даатгалын төрөл тус бүрт тусгайлсан данс нээж, тусгайлсан сан байгуулна” 51.2. Урт хугацааны даатгагчийн хөтлөх нягтлан бодох бүртгэлийн болон бусад тайланд дараахь үзүүлэлтийг тус тусад нь гаргаж харуулна: 51.2.1. сан тус бүрд хамаарах хөрөнгө; 51.2.2. даатгалын төрөл тус бүрд хамаарах үүрэг. 51.3. “Тухайн сангийн хөрөнгийг зөвхөн тухайн төрлийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах бөгөөд сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно” 51.4. Дараах тохиолдолд энэ хуулийн 51.3 дахь хэсэг хамаарахгүй:	Тийм

		51.4.1. тухайн сангийн хөрөнгийн үнэлгээ нь актуарын тооцоогоор тухайн төрлийн даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээс хэтэрч байвал ийнхүү хэтэрсэн хэсэгт; 51.4.2. урт хугацааны даатгагчийн сангийн хөрөнгийг зах зээлийн үнээр нь өөр хөрөнгөөр солиход. 51.5. “Энэ хуулийн 51.4.1-д зааснаас бусад тохиолдолд урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд зориулж байгуулсан сангийн хөрөнгийг даатгагчийн өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно” 51.6. “Урт хугацааны даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд урт хугацааны даатгагчийн сангийн хөрөнгийн хэмжээ хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч, түүний хараат болон охин компани ногдол ашиг төлөх болон төлөхөөр зарлахыг хориглоно” 51.7. “Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон компанид энэ хуулийн 51 дүгээр зүйл нэгэн адил хамаарна”	
5.	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль	3 дугаар зүйлийн 3.2. “Тусгай хуулиар зохицуулагдсан сан, түүний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцаа энэ хуульд хамаарахгүй” 44 дүгээр зүйлийн 44.7. “Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ хуульд заасан үйл ажиллагааг зөвхөн доор дурдсан үйл ажиллагаатай хавсран эрхэлж болно” 44.7.3. “хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах”	Тийм
6.	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	4 дүгээр зүйлийн 4.1.18. “мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа” гэж хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгөөр энэ хуулийн 4.1.19-д заасан банк бус санхүүгийн байгууллага, андеррайтер, дилерээс бусад этгээд мэргэжлийн түвшинд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг” 4.1.19. ““мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч” гэж мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, андеррайтер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд зэрэг хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэж үзсэн бусад этгээдийг” 4.1.32. “хөрөнгө оруулалтын сан” гэж хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар энэ хуулийн 4.1.18-д заасан үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг”	Тийм
7.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай	5 дугаар зүйлийн 5.2. “Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт	Тийм

		зөвшөөрлийн тухай хууль	шаардлагад нийцүүлэн, зөвхөн бүртгэх байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно" 5.4. "Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ" 7-р зүйлийн 7.1. "Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.	
Эрх зүйн бусад акт	8.	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Санхүүгийн зохицуулах хорооноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, баримт бичгийн бүрдүүлэлттэй холбоотой харилцааг зохицуулна.	Тийм
	9.	Урт хугацааны даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам	Урт хугацааны даатгалын хураамжийн хувь хэмжээг тооцох.	Тийм
	10.	Урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийн урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.	Тийм
	11.	Урт хугацааны даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх журам	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдэд зайнаас хяналт тавих харилцааг зохицуулна.	Тийм
	12.	Урт хугацааны даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаа явуулах журам	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.	Тийм
	13.	Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлт, түүнд хяналт тавих журам	Урт хугацааны даатгалын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.	Тийм
	14.	Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага	Урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалт хийх харилцааг зохицуулна.	Тийм
	15.	Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам	Нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих харилцааг зохицуулна.	Тийм
Бодлогын баримт бичиг	16.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл	Тэтгэврийн тогтолцоог эдийн засгийн агуулгын хувьд сайжруулах хагас хуримтлалын тогтолцоонд шилжих	Тийм
	17.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар	Тэтгэврийн тогтолцоог нийгмийн зорилгын хувьд сайжруулах, олон давхаргат болон төр	Тийм

	баримтлах бодлого 2030	хувийн хэвшил оролцсон тогтолцоог бүрдүүлэх	
18.	Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	Мянганы хөгжлийн зорилтод нийцүүлэн Монгол улсыг бүх чиглэлд цогцоор хөгжүүлэх асуудлыг 14 жилийн хугацаатайгаар тодорхойлж гаргасан	Тийм
19.	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	Монгол улсын 2030 он хүртэл хөгжүүлэх үндсэн асуудлыг тусгасан	Тийм
20.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	Уг баримт бичгийн хүрээнд Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх цогц асуудлууд тусгагдсан	Тийм
21.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл	2017 онд хэрэгжүүлэх үндсэн ажлуудыг тусгасан	Тийм

НАЙМ. Эх сурвалж

1. legalinfo.mn - “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай
2. legalinfo.mn - Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого - 2015-2030
3. legalinfo.mn – Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
4. legalinfo.mn-Нийгмийн даатгалын ерөнхий хууль
5. legalinfo.mn-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
6. legalinfo.mn-Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
7. legalinfo.mn-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль
8. legalinfo.mn-Нийгмийн халамжийн тухай хууль
9. legalinfo.mn-Ахмад настны тухай хууль



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЫН ЯАМ

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсны үндсэн дээр бие даасан хуулийн төслийг шинээр боловсруулах хувилбарыг сонгон авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу гүйцэтгүүлнэ.” гэж заасан болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналын дагуу судлаач Ц.Дашдондог миний бие уг хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийлээ.

“Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль”-ийн төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн нийт 11 бүлэг, 51 зүйлтэйгээр боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр нийгэм, эдийн засагт ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, харилцан уялдааг тогтоох, хуулийн төслийн зүйл заалтыг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэллээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”¹ /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Зардал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх, мөн хуулийн төслийг тодорхой

¹ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь Гишүүнд зардлыг ил тод байлгах, бусад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн зардалтай харьцуулах боломж олгох зорилгоор нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд тооцогдох захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох аргачлал, тайлагнах зэрэг зохицуулалтыг тусгасан болно.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн зорилго нь хувийн нэмэлт тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, тэтгэвэр олгох, өвлүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг нэг удаагийн тэтгэвэр, хуваарьт тэтгэвэр, насан туршийн тэтгэвэр олгодог байхаар зохицуулах;
2. Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрхийг шилжүүлэх, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлдэг байхаар зохицуулах;
3. Хуулийн нэр томъёо, зарим зүйл заалтыг бусад хуультай нийцүүлэх.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

Зорилт 1: Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг нэг удаагийн тэтгэвэр, хугацаат тэтгэвэр, насан туршийн тэтгэвэр олгодог байхаар зохицуулах:

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хувийн нэмэлт тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, тэтгэвэр олгох, өвлүүлэх,

мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

36 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл

36.2.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөөс тэтгэвэр тогтоолгох эрхтэй гишүүн дараах төрлийн нэмэлт тэтгэврийн аль нэгийг, эсхүл хослуулан зөвхөн 1 удаа сонгоно:

- 36.2.1.нэг удаагийн тэтгэвэр;
- 36.2.2. хугацаат тэтгэвэр;
- 36.2.3.насан туршийн тэтгэвэр.

Зорилт 2: Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрхийг шилжүүлэх, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлдэг байхаар зохицуулах:

37 дугаар зүйл.Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх

37.1.Гишүүн тэтгэвэр тогтоолгохоос өмнө нас барсан бол хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч гишүүний нэмэлт тэтгэврийн хөрөнгийг эрх залгамжлагчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.

37.2.Гишүүн нь эрх залгамжлагчийг нэрлээгүй, эрх залгамжлагч нь нас барсан тохиолдолд өвлөгчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлнэ.

37.3.Иргэний эрх зүйн чадамжгүй, иргэний эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан эрх залгамжлагч, өвлөгчийн хувьд асран хамгаалагч, эсхүл харгалзан дэмжигч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гэрээ хийж, нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээнэ. Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг эрх залгамжлагч, өвлөгчид энэ хуульд заасны дагуу зарцуулна.

37.4.Эрх залгамжлагч, өвлөгч нь гишүүний амь насыг хохироосон нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол тухайн эрх залгамжлагч, өвлөгчид нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэхгүй.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан тохиолдолд болон гишүүн эрх залгамжлагчийг нэрлээгүй, хууль ёсны өвлөгч байхгүй бол хувийн тэтгэврийн нэрийн дансанд хүримтлагдсан хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

Зорилт 3: Хуулийн нэр томъёо, зарим зүйл заалтыг бусад хуультай нийцүүлэх.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг бусад хуультай нийцүүлэн томъёолов. Мөн хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.1-д гишүүн холбогдох хуульд заасан тэтгэврийн насанд хүрсэн гэж нийцүүлэн томъёолов.

36 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл

36.1.Гишүүн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан тохиолдолд нэмэлт тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч болон гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нарын хооронд үүсэх харилцааг энэ хууль болон Даатгалын тухай хууль, Иргэний хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.2.Ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хувийн нэмэлт тэтгэврийн шимтгэл төлөхтэй холбогдсон харилцааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

3.3.Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт, зохицуулалттай холбогдсон харилцааг энэ хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.4.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаатай холбогдсон кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг энэ хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар тус тус зохицуулна.

3.5.Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдох татварын харилцааг татварын хууль тогтоомжоор зохицуулна.

50 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

50.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 36.2 дахь хэсэг, 36.2.1, 36.2.2, 36.2.3 дугаар заалт, 37 дугаар зүйлийн үр нөлөөг үнэлэх хэсэгт тусгасан заалтууд.	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.

2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Зардал	Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалт	Гишүүнд зардлыг ил тод байлгах, бусад хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн зардалтай харьцуулах боломж олгох зорилгоор нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд тооцогдох захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох; Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалтын зардлыг ил тод тайлагнах; Захиргааны зардлыг суутгахдаа шимтгэлийн тодорхой хувь, хөрөнгийн хувь, дансны тогтсон дүн, эсвэл эдгээрийг хослуулах замаар тогтоох. /аргачлалын дагуу тусад нь хийх/
4	Харилцан уялдаа зэрэг болно.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1-3.6 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1, 50.2 дахь заалтууд.	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилт 1: Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг нэг удаагийн тэтгэвэр, хугацаат тэтгэвэр, насан туршийн тэтгэвэр олгодог байхаар зохицуулах үнэлгээ хийсэн байдал:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу хуулийн зорилтод “Энэ хуулийн зорилт нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, тэтгэвэр олгох, өвлүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан ба энэ нь хувийн нэмэлт тэтгэвэр авах боломжийг бүрдүүлсэн.

Хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөөс тэтгэвэр тогтоолгох эрхтэй гишүүн дараах төрлийн нэмэлт тэтгэврийн аль нэгийг, эсхүл хослуулан зөвхөн 1 удаа сонгоно:” гэж зохицуулсан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах зорилго, хэрэгцээ, шаардлагатай нийцэж байна.

Зорилт 2: Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрхийг шилжүүлэх, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлдэг байхаар зохицуулах гэсэн заалтад үнэлгээ хийсэн байдал:

Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Гишүүн нь эрх залгамжлагчийг нэрлээгүй, эрх залгамжлагч нь нас барсан тохиолдолд өвлөгчийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлнэ.” гэж, 37.3-т “Иргэний эрх зүйн чадамжгүй, иргэний эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан эрх залгамжлагч, өвлөгчийн хувьд асран хамгаалагч, эсхүл харгалзан дэмжигч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гэрээ хийж, нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээнэ. Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг эрх залгамжлагч, өвлөгчид энэ хуульд заасны дагуу зарцуулна.” гэж эрх шилжүүлэх харилцааг уян хатан байдлаар зохицуулсан байна.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээ хийлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь нийтдээ 11 бүлэг, 51 зүйлтэй, хуулийн төслийн бүтэц, хэлбэр, дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасантай нийцсэн байна.

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулах байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага:	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан. /Хуулийн төслийн 2 болон 3 дугаар зүйл нийцэж байна./
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан. /Хуулийн төсөл бүхэлдээ/
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.

29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангасан Хуулийг дагаж Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх

	тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан. Хуулийн төслийн 1.1-д хуулийн зорилгыг тодорхойлсон бөгөөд хувийн нэмэлт тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, хувийн нэмэлт тэтгэвэр олгох, өвлүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын этгээдийн эрх ашгийг хамгаалахаар тусгасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг захиргааны болон хөрөнгө оруулалтын гэж ангилна.” гэж, 10.2-т “Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь захиргааны болон хөрөнгө оруулалтын мэдээллийг нэмэлт тэтгэврийн журамд заавал тусгана.” гэж тус тус заасан.

Дээр дурдсан зүйл, заалтуудтай холбогдон гарах зардлын нарийвчилсан судалгааг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцож, хавсаргасан болно.

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/Д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Шаардлага хангасан
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлага хангасан
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Шаардлага хангасан Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Шаардлага хангасан Хуулийн төсөлд төрийн чиг үүргийг давхардуулан тусгаагүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Шаардлага хангасан
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Шаардлага хангасан Албан татвар, төлбөр хураамж тусгаагүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Шаардлага хангасан Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгасан
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Шаардлага хангасан Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Шаардлага хангасан
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Шаардлага хангасан Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Шаардлага хангасан Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх	Шаардлага хангасан

	хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хариуцлагын хэм хэмжээтэй холбоотой зохицуулалт тусгасан
--	--	---

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлтээр дараах байдлаар үнэлж, дүгнэлээ. Үүнд:

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа эсэх, хуулийн төсөлд тусгасан зүйл, заалтууд нь хуулийн төслийн зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэх, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилт 1-3-ыг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон байна гэж дүгнэлээ.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал болон ажлын хэсэг, олон нийтээр хэлэлцүүлэхэд гарсан саналуудад дүн шинжилгээ хийж, үнэлэхэд хуулийн төслийн ойлгомжтой байдалтай холбоотой ямар нэг санал ирүүлээгүй тул хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна гэж дүгнэлээ.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултуудын дагуу үнэлж, шалгахад хуулийн төсөл нь уялдаа холбоог хангаж байна гэж дүгнэлээ.

Дээрх шалгуур үзүүлэлтүүдээр хийсэн үнэлгээ, дүгнэлтүүдээс харахад уг хуулийн төсөл нь зорилготойгоо нягт уялдсан байгаа нь харагдаж байна. Түүнчлэн уг хуулийн төсөл батлагдсанаар эдийн засгийн болон бусад эерэг нөлөөллийг нийгэмд үзүүлэхээр байгаа нь судалгаагаар тодорхойлогдоод байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээнд үндэслэсэн зөвлөмж:

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд уг хуулинд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн зорилготой уялдаж байгаа бөгөөд хууль батлагдсаны дараа нийгэмд эерэг нөлөө үзүүлэх үр дагавартай байна.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэхэд ямар нэгэн ойлгомжгүй байдал үүсэхгүй бөгөөд хэрэгжүүлэх байгууллага тодорхой, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтууд хуулийн төсөлд бүрэн тусгагдсан байна.

Иймээс "Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын 5.4-т заасны дагуу хуулийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй байна.

---oOo---



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хуулийн үндэслэл:

Шинээр боловсруулсан Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов.

Зардлын тооцоо хийсэн аргачлал:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэнэ. Энэ тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан зардлын төрлөөр тооцлоо.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд зааснаар хуулийн этгээд, иргэн нэмэлт тэтгэвэрт шимтгэл төлж хамрагдах тул зардал гарна.

Мөн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах гол чиг үүрэг төрийн байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хороонд оногдож байгаа тул хүний нөөц, үйл ажиллагааны урсгал зардал болон бусад материаллаг зардал гарахаар байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

1. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараах үе шаттайгаар гаргалаа.

Үүнд:

1.1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;

- 1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;
- 1.3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
- 1.4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;

1.1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох:

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон.

Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх хэмжих боломжтой ажлыг хамаарууллаа. Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзэв. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил=ажлын 252 өдөр (нэг сард ногдох ажлын өдрийг 21 өдрөөр тооцов);

1 өдөр=ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/;

1 цаг=ажлын 60 минут;

Жилд 252 ажлын өдөр буюу /252x8/ 2016 ажлын цаг буюу 121 920 минут ажиллана гэсэн үг.

Төрийн захиргааны байгууллагад үүсэх зардал тооцсон байдал

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд Санхүүгийн зохицуулах хороо дараах шинэ чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

1. Хувийн тэтгэврийн сангийн захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг хянах;
2. Хувийн тэтгэврийн сангийн өөрийн хөрөнгө болон тэтгэврийн хөрөнгийн зохистой харьцааг хянах;
3. Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
4. Хувийн тэтгэврийн санд хяналт шалгалт хийх;
5. Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн дагуу холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх;
6. Хувийн тэтгэврийн сангийн харилцаанд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгагчийн болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, чиг үүргийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох, маргаан шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, бусад харилцааг зохицуулах зэрэг тус тус болно.

46 дугаар зүйл.Хорооны чиг үүрэг

46.1.Хороо энэ хуулийн хэрэгжилтийг хангах, нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт шалгалт хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх ашгийг хамгаалах, багц дүрэм, журам, заавар, аргачлал, удирдамж, маягт баталж мөрдүүлэх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

46.2.Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, кастадион, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийнэ.

46.3.Хороо нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг тайлагнах журам, маягтыг батална.

1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох:

Холбогдох ажилтнуудын ажилбарт зарцуулагдах ажлын байрны зураг авалтын үр дүнг доорх хүснэгтүүдэд харуулав.

Ажил үйлчилгээ гүйцэтгэхтэй холбоотой зардлын тооцоо

Хүснэгт 1

Д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	Сар бүр Жилд 12 удаа	Нийт хугацаа
1	Урт хугацааны даатгагч, хувийн тэтгэврийн сангийн захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг хянах	Материал хүлээн авах	15	10	150
		Материал хянах	1200	12	14400
	Нийт				14650
Шаардлагатай хүний нөөц = $14650/60\text{минут} = 242.5\text{цаг}/8 = 30.3$ өдөр					

Хүснэгт 2

Д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	Сар бүр Жилд 12 удаа	Нийт хугацаа
2	Урт хугацааны даатгагч, хувийн тэтгэврийн сангийн өөрийн хөрөнгө болон тэтгэврийн хөрөнгийн зохистой харьцаанд хяналт тавих	Материал хүлээн авах	15	10	150
		Материал хянах	1200	12	14400
	Нийт				14550
Шаардлагатай хүний нөөц = $14550/60\text{минут} = 242.5\text{цаг}/8 = 30.3$ өдөр					

Хүснэгт 3

Д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	Сар бүр Жилд 12 удаа	Нийт хугацаа
3	Урт хугацааны даатгагч, хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих	Материал хүлээн авах	15	10	150
		Материал хянах	1200	12	14400
	Нийт				14400
Шаардлагатай хүний нөөц = 14,550/60минут = 242.5цаг/8= 30.3 өдөр					

Хүснэгт 4

Д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Давтамж	Нийт хугацаа
4	Урт хугацааны даатгагч, хувийн тэтгэврийн санд хяналт шалгалт хийх	Материал хүлээн авах	120	1	120
		Хурал зохион байгуулах	180	1	180
		Материал хянах	2400	1	2400
		Газар дээр ажиллах	2400	1	2400
		Хурлаар хэлэлцүүлэх	240	1	240
		Холбогдох шийдвэр гаргаж мэдэгдэх	10	1	10
	Нийт				5350
Шаардлагатай хүний нөөц = 5350/60минут = 89.1цаг/8 =11.1 өдөр					

Хүснэгт 5

Д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Давтамж	Нийт хугацаа
5	Хувийн тэтгэврийн тухай хуулийн холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх, сайжруулах	Дүрэм, журмыг боловсруулах, сайжруулах	1440	13	18720
		Дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих	1200	13*12=156 удаа	187200
	Нийт				205920
Шаардлагатай хүний нөөц =205920/60минут =3432цаг/8=429 өдөр					

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүчний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Хүснэгт 6

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ буюу нийт цаг	Жилд шаардагдах ажлын цаг	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Төрийн захиргааны байгууллага	4248.7	2016	2.1

Дээрх тооцооллоос үзэхэд төрийн захиргааны төв байгууллагад 254 920 минутын ачаалал үүсэж байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 2.1 буюу 2 ажилтан шаардлагатай байна.

1.3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардал:

Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдад хамаарах албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн баталсан.

Санхүүгийн зохицуулах хорооны референт нь АА-6 зэрэглэлд хамаардаг бөгөөд сарын цалин 2,370,000 төгрөг байна.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг шууд тооцоолох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм.

Хүснэгт 7

Зардлын нэр	Цалингийн хэмжээ	Хувь	Хэмжээ
Үндсэн зардал	2,370,000		2,370,000
Нийтлэг зардал	2,370,000	15%	355,500
Дагалдах зардал	2,370,000	10%	237,000
Нэмэгдэл урамшууллын зардал	2,370,000	30%	711,000
Нийт			3,673,500

Хүснэгт 8

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
Ажилтан	3,673,500	2	12	88,164,000
Нийт хүний нөөцийн зардал				88,164,000

1.4.Бусад буюу материаллаг зардал:

Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбоотой нийтлэг зардал буюу тухайн үүргийг гүйцэтгэж буй албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг хамааруулдаг. Тухайлбал, ажлын байр, эд хөрөнгө, техник хэрэгсэл, тэдгээрийн элэгдэл хорогдол, бусад ахуйн зардлыг тооцох шаардлагатай.

Тус зардлыг тооцохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох аргачлал"-ын

хавсралтыг үндэслэж нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 9

Хүснэгт

№	Зардлын төрөл	Зардлын нэрс	Зардал, төгрөг
1	Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
2		Шуудан холбоо	167,881
3		Тоног төхөөрөмж, компьютер	4,999,000
4		Тавилга, эд хогшил	900,000
Нэг ажилтанд оногдох			6,188,166

Дээрх тооцооллоос харахад төрийн байгууллагад үүсэх нийт зардал нь жилд:

Хүснэгт 10

Зардлын нэрс	Зардал, төгрөг
Хүний нөөцийн зардал	88,164,000
Материаллаг зардал	12,376,332
Нийт зардал	100,540,332

1.5. Улсын төсөвт үзүүлэх зардлын нөлөөлөл

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд үүнд ажил олгогчийн шимтгэл төлөх цалин, хөлсний дээд хэмжээнд даатгуулагчтай адил хязгаарлалт тогтоохоор заасан.

Улсын төсөвт нөлөөлөх зардлын тооцоолол

Хүснэгт 11

Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс дээших цалингийн сан /тэрбум төгрөг/	Шимтгэлийн хувь	Нийт буурах шимтгэлийн хэмжээ /тэрбум.төг/
2,291.0	10.5-12.5	252.0

Ажил олгогчийн шимтгэл төлөх цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү болгох тооцооллыг тооцоолж үзэхэд хуулийн төсөл батлагдаж, хэрэгжсэн эхний жилд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 252.0 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг дагаж Хувь хүний орлогын албан татварын тухай дагах хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын үр дүнд улсын төсөвт нөлөөлөх зардлыг доорх хүснэгтээр харуулав.

Улсын төсөвт нөлөөлөх зардлын тооцоолол

Хүснэгт 12

Үзүүлэлт	Тоо Мян.хүн	Татварын чөлөөлөлтийн дүн /тэрбум.төг/
Хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд оролцогчдын тоо	145.4	10.7

Орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зардлын тооцооллыг тооцоолж үзэхэд хуулийн төсөл батлагдаж, хэрэгжсэн эхний жилд 10.7 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлт буюу хойшлуулалт гарахаар байна.

2.Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Ажил олгогч болон ажилтны төлөх шимтгэлийг цалин хөлсний тодорхой хувиар, эсхүл тогтсон дүнгээр тооцно.” гэж заасан. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай байгуулах ажил олгогчийн гэрээ болон ажилтны байгуулах нэмэлт тэтгэврийн гэрээнд төлөх шимтгэлийн дүн, хувь хэмжээ, шимтгэл төлөх давтамж, хугацааг заасан байна.

Манай улсад нэвтрүүлэх хувийн нэмэлт тэтгэвэрт албан журмаар эсвэл сайн дураар нийгмийн даатгалд даатгуулсан иргэн өөрийн хүсэлтээр хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдахаар хуулийн төсөлд тусгасан. Хувийн нэмэлт тэтгэвэрт урт хугацааны даатгагч эсвэл хувийн тэтгэврийн сангаар дамжуулан авах ажилтан нь шимтгэлийг ажил олгогчтойгоо хамтран төлөхөөр хуулийн төсөлд заасан тул хуулийн этгээдээс тодорхой хэмжээний зардал гарах юм.

Олон улсын жишиг болон одоогоор манай улсад хэрэгжүүлж байгаа жишгээр ажил олгогчоос төлж байгаа дүн нь тухайн иргэний цалингийн 1.8-2.0 хувь байгаа болно. Иймд хуулийн этгээдээс гарах зардлыг дундаж цалингийн 2 хувь байхаар тооцлоо.

Хуулийн этгээдээс хувийн тэтгэврийн сан, урт хугацааны
даатгагчид төлөх шимтгэлийн хэмжээ

Хүснэгт 13

№	Үзүүлэлт	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/
1	Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид төлөх шимтгэл	2

Манай улсад хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүй ч, зарим байгууллагууд өөрсдийн ажиллагчдыг хамруулсан хувийн тэтгэврийн сангуудыг үүсгэн байгуулж, үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Даатгалын тухай хуульд нийцүүлэн багц дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага нэг байна.

Эрх бүхий байгууллагаас ямар нэгэн тусгай зөвшөөрөл авдаггүй, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нийцүүлэн хязгаарлагдмал хүрээнд (зөвхөн нэг

байгууллага дотор хэрэгжиж байгаа) болон олон нийтэд санал болгох замаар хэрэгжүүлж байгаа 5 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 145.4 мянган иргэн хамрагджээ.

Хуулийн этгээдээс гарах зардлын тооцоо

Хүснэгт 14

Зардлын төрөл	Дундаж цалин /мян.төг/ ¹	Шимтгэлийн хувь хэмжээ	Нийт даатгуулагчийн тоо /мян/ ²	Нэг жилд гарах нийт зардал /тэрбум.төг/
Ажил олгогчоос төлөх шимтгэл, хураамжийн зардал	2,713.9	2%	145.4	94.7
Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс дээших цалингийн сангаас төлөх шимтгэл				-252.0
Нийт				-157,3

Хуулийн этгээд буюу ажил олгогч хэдийгээр өөрөөс зардал гаргаж байгаа мэт боловч энэхүү гаргаж байгаа зардал нь иргэний буюу ажилтны ирээдүйн нийгмийн хамгааллыг хангах тул ажилтан тогтвор суурьшилтай, бүтээмж өндөртэй ажиллахад нөлөөлж улмаар хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлөх болно.

3. Иргэнд үүсэх зардлын тооцоо:

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 792.0 мянган төгрөг, шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ 7,920.0 мянган төгрөг болсон.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөх дээд хязгаараас давсан өндөр орлоготой даатгуулагч 2024 оны байдлаар 29.7³ мянга байна.

Өндөр орлоготой даатгуулагчдын зүгээс шимтгэл төлөх дээд хязгаараас давсан орлогоосоо нэмэлт шимтгэл төлөх замаар ирээдүйд авах тэтгэврийн хэмжээгээ өсгөх сонирхолтой байдаг. Зөвхөн өндөр орлоготой давхарга ч бус дундаж орлоготой иргэдийн хувьд өрхийн орлого, цалингаа зөв зохистой зарцуулснаар өөрийн хувийн нэмэлт тэтгэврийн санд хуримтлал үүсгэх боломжтой юм. 2024 оны жилийн эцсийн байдлаар одоо нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад нийт 145.4 мянган иргэн хамрагджээ. Иймд иргэнээс гарах зардлын судалгааг хийхдээ энэ тоог баримталж, мөн төлөх шимтгэлийн хувь хэмжээг дээр дурдсан ажил олгогчийн төлөх хувь хэмжээтэй ижил буюу 2 хувь байхаар тооцлоо.

¹ www.1212.mn ҮСХ-ны 2025 оны 3 дугаар улирлын мэдээ

² Голомт банкны үүсгэн байгуулсан Тэтгэврийн ууган сан ТББ, Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф ХХК, Мандал лайф ХХК-аас авсан судалгаагаар, 2024 оны жилийн эцсээр

³ Нийгмийн даатгалын мэдээллийн сан

Иргэнд үүсэх зардлын тооцоо

Хүснэгт 15

Зардлын төрөл	Дундаж цалин /мян.төг/	Шимтгэлийн хувь хэмжээ	Нийт даатгуулагчийн тоо /мян/	Нэг жилд гарах нийт зардал /тэрбум.төг/
Иргэнд үүсэх зардлын хэмжээ	2,713.9 ⁴	2%	145.4 ⁵	94.7

Иргэн буюу ажилтан хэдийгээр өөрөөс зардал гаргаж байгаа мэт боловч энэхүү гаргаж байгаа зардал нь ирээдүйд тухай иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход тэтгэвэр авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, орлогыг өсгөх, нийгмийн хамгааллыг сайжруулахад чухал нөлөөтэй. Энэ ч утгаараа энэхүү зардал нь банкны хадгаламжтай төстэй юм. Хуулийн этгээд буюу ажил олгогч нь сайн ажилтныг урамшуулах зорилгоор иргэний төлөх шимтгэлийн зарим хэсгийг нэмж төлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан тул энэхүү зардал багасах боломжтой.

Нийт зардлын тооцоо:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд 200.2 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоолол гарч байна.

Хүснэгт 16
(тэрбум төгрөгөөр)

Зардлын төрөл	Хуулийн этгээдийн зардал	Иргэнд үүсэх зардал	Улсын төсөв буюу нийгмийн даатгалын санд үүсэх зардал	Нийт зардлын хэмжээ
Шимтгэлийн зардал	-157.3	94.7	-	-62.6
Ажил олгогчийн шимтгэл төлөх цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү болгох			252.0	252.0
Татварын чөлөөлөлтийн дүн /тэрбум.төг/			10.7	10.7
Хүний нөөцийн зардал	-	-	0.1	0.1
Нийт зардал	-157.3	94.7	262.8	200.2

⁴ www.1212.mn ҮСХ-ны 2025 оны 3 дугаар улирлын мэдээ

⁵ Голомт банкны дэргэдэх Тэтгэврийн ууган сан ТББ, Ард санхүүгийн нэгдлийн охин компани болох Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф ХХК, Мандал лайф ХХК урт хугацаат даатгалын компаниас авсан түүвэр судалгаа

4. Дүгнэлт, санал:

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад гарах зардлын тооцоог хийлээ.

4.1.Санхүүгийн зохицуулах хороо энэхүү хуулийг хэрэгжүүлэх, хянах байгууллага болох тул 2 ажилтан шинээр нэмж авах шаардлагатай. Цаашид хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдагсдын цар хүрээ ихсэх үед орон тоог нэмэх шаардлагатай.

4.2.Нийгмийн даатгалын байгууллага одоогийн орон тоонд нийцүүлэн хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд хуулийн төсөлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой гэж тооцлоо.

4.3.Хуулийн этгээдэд шимтгэл төлөх цалингийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү болгосноор хуулийн этгээдээс илүү зардал гарахгүй бол харин иргэнд 94.7 тэрбум төгрөг байна. Гэхдээ энэ нь шууд гарах зардал бус харин иргэний ирээдүйд ашиглах хөрөнгө буюу хуримтлал юм.

Ашигласан материал:

- 1.Хууль тогтоомжийн тухай хууль;
- 2.Хөдөлмөрийн тухай хууль;
- 3.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл;
- 4.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал";
- 5.Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт;
- 6.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт;
7. www.1212.mn;
- 8.Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн мэдээлэл;
- 9.Голомт банкны дэргэдэх Тэтгэврийн ууган сан ТББ, Ард санхүүгийн нэгдлийн охин компани болох Ард лайф ХХК, Нэйшнл лайф ХХК, Мандал лайф ХХК урт хугацаат даатгалын компаниас авсан түүвэр судалгаа.
- 10.PC mall цахилгаан барааны дэлгүүр <https://pc-mall.mn/>



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн тайлан

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/48 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталж, ажлын хэсэг нийт 7 удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэг бүрчлэн хэлэлцэж, хуулийн төсөлд тусгалаа.

Энэхүү хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын хөрөнгийн бирж, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын актуарчдын нийгэмлэг, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын холбоо, Голомт банкны дэргэдэх Тэтгэврийн ууган сан ТББ, Ардын тэтгэврийн данс ХХК, Нэйшнл лайф даатгал ХХК, Мандал лайф даатгал ХХК, бие даасан судлаач, актуарч нарын төлөөллийг оролцуулж, ажиллалаа.



Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд санал авах зорилгоор хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааны хамт ажлын хэсгийн гишүүн байгууллагуудаас санал авахаар 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1211 тоот албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн саналыг хуулийн төсөлд тусгасан.



Мөн Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүдэд 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн танилцуулгыг хийж, хэлэлцүүлээ.

Засгийн газрын гишүүд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хуулийн төсөлд санал авахаар 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/1446 тоот албан бичгээр тус тус хүргүүлж саналыг аваад байна.

Олон нийтээс санал авах зорилгоор тус яамны цахим хуудсанд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 2025 оны 02 дугаар сарын 12-ы өдөр байршуулсан.

[Нүүр](#)
[Яамны тухай](#)
[Бодлого, чиглэл](#)
[Мэдээ, мэдээлэл](#)

ХӨР-ийн үйлдвэрчний эвлэлийн холбооны байр

[Төрийн үйлчилгээ](#)
11-11 төв
1212.MN

Санал авч байна 2025-02-12

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2026 оны үйл ажиллагааны гэгдэлбэр"-ийн 2.1.3 бэлд "Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн бичлэг бүрдүүлж, иргэддэд ахиад нэвтрүүлэх олон эх үүсвэрийг тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ" гэж заасан. Дээрх зорилтын хэрэгжлэлийг хангах ажлын хүрээнд тус нэм Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулав.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар Монгол Улсад тэтгэврийн олон дараахан тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулах олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тэрийн бүс өмчид бүртгүүлсэн сайн дурын хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоох, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, анналт тавихтай холбоотой хариуцаж зохицуулах юм.

Та бүхэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд саналаа тус яамны төхивд mtbber.gov.mn цахим хаягаар оруулна уу.

Хавсралт хэсгээс хуулийн төслийг бүрэн эхээр нь уншиж авна уу.

Хавсралт файл

№	Гарчиг	Татах
1	хуулийн төслийн танилцуулга	Татах
2	Хуулийн төсөл	Татах

400 1008 Хуваалцах: [f](#) [t](#)

Хувийн нэмэлт тэтгэврийн эрх зүйн орчинг бүрдүүлснээр ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, төлсөн шимтгэлтэй уялдсан тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгох шударга аргачлалыг нэвтрүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах зэрэг ажил олгогч, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн олон харилцааг зохицуулахаар тусгаад байна.



Хэвлэл мэдээллийн байгууллагаар хуулийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал

2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Тэнгэр” телевизээр “Нийгмийн даатгалын шинэчлэл” сэдвийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал болон хувийн даатгалын компанийн төлөөлөл, судлаачдын хамт хэлэлцүүлэгт оролцож Нийгмийн даатгалын шинэчлэл, хувийн нэмэлт тэтгэврийн тухай тухай хуулийн төслийн талаар мэдээлэл хүргэсэн.



© 2025 Тенгэр Рэнж - Нийгмийн Даатгалын Шинэчлэл



© 2025 Тенгэр Рэнж - Нийгмийн Даатгалын Шинэчлэл

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Хөрөнгө оруулагч үндэстэн чуулган” болж, энэ чуулганд “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг явагдаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал оролцож, хуулийн төслийн ач холбогдлын талаар чуулганд оролцож байгаа иргэдэд мэдээлэл хүргэлээ.



---oOo---

Олон нийтээс санал авах зорилгоор тус яамны цахим хуудсанд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 2025 оны 02 дугаар сарын 12-ы өдөр байршуулсан.

Нүүр Яамны тухай ▾ Бодлого, чиглэл ▾ Мэдээ, мэдээлэл ▾



ГЭР БҮГД ХӨДӨЛМӨГ,
НИЙГЭМИЙН ХАМГААЛСЫН ЯАМ

Төрийн үйлчилгээ ▾ 11-11 төв 1212.MN



Санал авч байна 2025-02-12

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.5-д "Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ" гэж заасан. Дээрх зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус яам Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах юм.

Та бүхэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд саналаа тус яамны feedback@mtsp.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт хэсгээс хуулийн төслийг бүрэн эхээр нь татаж авна уу.

Хавсралт файл

№	Гарчиг	Тагах
1	хуулийн төслийн танилцуулга	Татах
2	Хуулийн төсөл	Татах

1005

Хуваалцах: [f](#) [t](#)

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн тайлан

2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Дэлхийн улс орон бүрийн өмнө сүүлийн жилүүдэд тулгараад байгаа нэг сорилт бол өндөр настай иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх тухай асуудал юм.

Иймд даатгуулагчдад олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бий болгох, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/48 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталж, ажлын хэсэг нийт 7 удаа уулзалт, олон нийтээр 1 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэг бүрчлэн хэлэлцэж, хуулийн төсөлд тусгасан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн ээлжит уулзалт, хэлэлцүүлэг 2026 оны 3 дугаар сарын 10-ны өдөр болж, хуулийн төслийг Ажлын хэсгийн хүрээнд хэлэлцлээ. Уулзалт, хэлэлцүүлэгт Ажлын хэсгийн ахлагч Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул “Дэлхийн улс орнуудын тэтгэврийн тогтолцоо”, тус яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналын талаар”, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин “Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулах боломжууд” сэдвээр мэдээлэл өгсөн.

Олон нийтийн хэлэлцүүлэгт Улсын Их хурлын даргын хувийн хэвшил, мөнгөний бодлого хариуцсан зөвлөх Б.Дөлгөөн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Б.Солонгоо, тус яамны төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, нийгмийн даатгал, хуримтлалын сагийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбат, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Жахан Шамсиев, “Өлзий энд ко ҮЦК”-ний захирал Б.Өлзийбаяр, “Нэйшнл лайф” даатгалын компанийн захирал Г.Монголхүү нар панелистаар, сэтгүүлч Ч.Гэрэлчулуун, Б.Ариунцэцэг нар модератороор, 100 гаруй хүн олон талын төлөөллөөс оролцож хэлэлцүүлэгийг амжилттай зохион байгуулсан.



Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төслийг холбогдох талуудын оролцоог ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулснаар, хууль эрх зүйн орчны гадна байгаа хувийн нэмэлт тэтгэвэрт даатгуулсан 135.6 мянган иргэн ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломж баталгаажих юм.

Мөн хууль батлагдсанаар ажил олгогчид хүний нөөцийн шинэ бодлого хэрэгжүүлж, ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх, бүтээмжээ нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн даатгал, тэтгэврийн сангуудын хөрөнгийн хэмжээ өсөж, урт хугацааны дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдсэнээр санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

**Хэвлэл мэдээллийн байгууллагаар хуулийн төслийн талаарх
мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал**

2026 оны 03 дугаар сарын 11-ны өдөр “Тэнгэр” телевизийн теле хэлэлцүүлэгт Сангийн дэд сайд Б.Хулан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, “Ардын тэтгэврийн данс” ХХК-ны гүйцэтгэх захирал Ц.Тайшир нар оролцож, “Хувийн тэтгэврийн даатгалын сангийн ирээдүй” сэдвийн хүрээнд ярилцав.



---oOo---



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025. 06. 06 № А-1/460
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх
тухай

Танаас 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1446 дугаар албан бичгээр ирүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төсөлтэй танилцан, дараах саналыг өгч байна.

Хөрөнгийн зах зээл өндөр түвшинд хөгжсөн АНУ, Япон, БНСУ зэрэг улсад мэргэжлийн буюу институционал хөрөнгө оруулагч болох хувийн тэтгэврийн сан хөрөнгө оруулагчдад санхүүгийн зөвлөгөө өгөх, тэдгээрийн нэрийн өмнөөс хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө, санхүүг нь удирдах зэргээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг бөгөөд үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалын зарчмыг мөрдөж, холбогдох техникийн болон дэд бүтцийн шаардлага хангасан байдаг.

Харин үнэт цаасны зах зээл нь хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулагчдын найдвартай байдлыг хангах хууль, эрх зүйн орчин сул, санхүүгийн эрсдэл өндөр байдаг тул хувийн тэтгэврийн сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд болох хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигддаг шалгуурыг тодорхой, өндрөөр хуулийн төсөлд тусгах нь хувийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн хөрөнгө оруулагч сонгодог утгаараа хөгжин төлөвших, нэмэлт тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгоход эерэг нөлөө үзүүлнэ. Иймд тус хуулийн төслийн 32 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах санхүүгийн чадамж, мэргэжлийн ур чадвар, хяналтын тогтолцоо, технологийн дэд бүтэц, хараат бус байдал зэрэг тодорхой, хэмжигдэхүйц шалгуурыг тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих зохицуулалтыг тодорхой заах нь чухал гэж үзэж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гаргадаг богино хугацаатай үнэт цаасны хүү буюу бодлогын хүүг урт хугацаатай хөрөнгө оруулалтын хэрэгслийн өгөөжийг тогтооход хэрэглэх нь зохисгүй тул хуулийн төслийн 9.4 дэх хэсэгт зах зээл дэх ижил төрлийн урт хугацаатай санхүүгийн хэрэгслийн хүүг харгалзах байдлаар өөрчлөх нь зүйтэй юм.

Хавсралтаар хуулийн төсөлтэй холбоотой бусад саналыг хүргүүлээ.
Хавсралт 2. хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525021721

Монголбанкны 2025 оны 6-р сарын 22-ны
өдрийн А.1/468 тоот албан бичгийн Хавсралт

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Д/д	Хуулийн төслийн зохицуулалт	Санал	Саналын үндэслэл
1	5.1.20	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд тусгагдсан 4.1.30 дахь заалтыг илүү нарийн тодорхойлох	Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан “холбогдох этгээд” болон Компанийн тухай хуулийн 99.1-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдээс ялгагдах үндэслэлийг тодорхой гаргах
2	7.3	Гэрээг хугацаагүй байгуулахаар заасан байгааг дахин хянах.	Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гэрээг хугацаагүй байгуулахаар тусгаснаар ажилтан тухайн ажил олгогч ААН-д хөдөлмөр эрхлэхгүй болсон тохиолдолд нэмэлт тэтгэврийн шимтгэл төлөлт доголдох, гэрээний нөхцөлийг хангахгүй байх нөхцөл үүсч болзошгүй байна.
3	8.1	“бэлнээр төлөх” гэж нэмэх	Бэлэн бусаар төлөх боломжгүй санхүүгийн хэрэглэгчдийг үйлчилгээнд хамрагдах боломжоор ханган, хууль иргэн бүрд тэгш, хүртээмжтэй үйлчлэх зарчмыг хангах
4	8.4	“50-аас доошгүй” гэснийг “70-аас доошгүй” гэж өөрчлөх	Босгыг өндөр тогтоовол ажилтны зүгээс хувийн даатгалд хамрагдах идэвх, санаачилга нэмэгдэх сэдэл болно.
5	9.4	Баталгаат өгөөжийн доод хэмжээг зах зээлийн зарчимд суурилсан, үр ашигтай байхаар тогтоохоор өөрчлөх	Баталгаат өгөөжийн доод хэмжээг хүү, эсхүл инфляциас багагүй байна, хэтрэхгүй байна, эсхүл тэнцүү байна гэж заагаагүй тул даатгагч

Д/д	Хуулийн төслийн зохицуулалт	Санал	Саналын үндэслэл
			аль нэг хувилбарыг сонгосон тохиолдолд даатгуулагч, даатгагчийн хооронд тодорхой бус байдал үүсгэх эрсдэлтэй. Төв банкны “бодлогын хүү” гэж хууль тогтоомжид тодорхойлоогүй. Төв банкны богино хугацаатай (7 хоног) үнэт цаасны хүү бөгөөд эрсдэл, зориулалтын хувьд маш ялгаатай хэрэгсэл учир тохиромжгүй.
6	12 дугаар зүйл	Тусгай зориулалтын компани (ТЗК) хэлбэртэйгээр хуулийн үзэл баримтлалыг өөрчлөн, ТЗК нь Хөрөнгө оруулалтын сангийн шинжийг агуулж байгаа оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан тул даатгуулагчийн сангийн хөрөнгөөр ХТС хамтын, нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн шинжтэй байх боломжийг судлах	Хувийн тэтгэврийн сан (ХТС) нь хөрөнгө оруулалтын сангийн шинжийг агуулж байгаа тул даатгуулагчийн сангийн хөрөнгөөр ХТС гэдэг компанийг тэтгэврийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх нь ХТС-ийн хөрөнгийн өгөөжийг багасгах нөлөөтэй.
7	12.1	ХТС-г хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) үүсгэн байгуулж болох, ХТС нь ТЗК-ийн хэлбэртэй хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулах агуулгаар өөрчлөх боломжийг судлах	Компанийн тухай хуулийн 9.1-д зааснаар ХТС-ийн бүх хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд энэхүү хуульд тэтгэврийн сангийн хөрөнгийг тусад нь бүртгэснээр санхүүгийн хариуцлагаас сангийн хөрөнгө хамгаалагдах үндэслэл болохгүй.
8	12.2	Хасах	Нэг хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласнаар эрсдэлээс сэргийлэх, Компанийн тухай хуулийн 31.3-д заасан дахин хөрөнгөжүүлэх үүрэгжүүлсэн зохицуулалт хэрэгжүүлэх боломжгүй болох нөхцөл үүснэ.
9	12.3.3	“хууль ёсны орлого”-ыг “хууль ёсны хөрөнгө” гэж өөрчлөх	Хууль ёсны орлого гэдэг борлуулалтын орлого юм уу?, татварын дараахь орлого юм уу? Үйл ажиллагааны орлого юм уу? Хөрөнгийн орлого

Д/д	Хуулийн төслийн зохицуулалт	Санал	Саналын үндэслэл
			юм уу? гэсэн ойлгомжгүй байдлаас шалтгаалан тусгай зөвшөөрөл олгогдохгүй байх шалтаг болдог. Хууль ёсны хөрөнгө компани, хувь хүний санхүүгийн тайлангаар, банкн дахь хадгаламж, эзэмшиж буй түргэн борлогдох актив буюу ЗГ-ын үнэт цаас, ХК-ийн хувьцаа, бонд, эзэмшиж буй санхүүгийн үүсмэл хэрэгсэл зэрэг хэлбэртэй байж болно.
10	12.3.4	Хасах	Аливаа бизнес бусдын хөрөнгийг гэрээний үндсэн дээр эзэл авч өргөждөг бол банк, санхүүгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүнийг хориглож байгаа боловч хяналт тавих боломжгүй, нугалаа гаргах үндэслэл болдог. Мөн зээлийн хөрөнгө гэдэгт компанийн пассивт туссан эх үүсвэрийг хамруулах эсэх тодорхойгүй. Тухайлбал, хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалт буюу компанийн хувьцааг эзэмших үндсэн үйл ажиллагаа явуулахаар бусдын хөрөнгийг эзэлж авах зөвшөөрлийг СЗХ-ноос хуулийн дагуу авсан боловч ХТС-ийн хувьцаа эзэмшигч болохыг хориглох боломжгүй.
11	12.3.5	Хасах	Тусгай зөвшөөрөл авсан банкуудыг ялгаварлах нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг боогдуулах эрсдэлтэй. Нөгөөтэйгүүр, системд нөлөө бүхий банк төлбөрийн чадваргүй болох эрсдэл нэгэн адил байдаг.
12	12.4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх	Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, ирээдүйд нэмэлт тэтгэврийн санд гишүүнээр

Д/д	Хуулийн төслийн зохицуулалт	Санал	Саналын үндэслэл
			орох иргэдийн хөрөнгийн найдвартай байдлыг хангахад 6 тэрбум төгрөг нь хангалттай эсхийг нарийвчлан судлах нь зүйтэй. Жишээлбэл, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 10 тэрбум төгрөгөөр тогтоож, 2028 оны 4 дүгээр сараас мөрдөхөөр шийдвэрлэсэн.
13	12.5	Хасах	ХТС нь ХОМК, кастодиан, нягтлан бодох бүртгэл, хөндлөнгийн аудит зэргээр ХТС-ийн хөрөнгийн бүртгэл, менежмент, хөрөнгө оруулалт, хяналт, хууль зүйн зөвлөгөө авах төлбөртэй гэрээгээр гүйцэтгүүлж байгаа нөхцөлд тусдаа ХТС гэгч яг ямар зорилготой байх нь ойлгомжгүй байна.
14	13 дугаар зүйл	ТУЗ нь Компанийн тухай хуулийн 84-д заасан шалгуурыг хангасан байхаар өөрчлөн найруулах	Үндсэн хуулиар олгосон өмчтэй байх, өмчөө захиран зарцуулах, хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх хүний эрхийн зөрчлийн асуудал бөгөөд сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах нь зохисгүй.
15	13.8	Хасах	Компанийн тухай хуулиар ТУЗ-д олгогдсон бүрэн эрхийн асуудлыг дахин “гадна” гэж байгаад тодотгох нь хуулийн кодификаци, Хууль тогтоомжийн тухай хуультай зөрчилдөж байна.
16	20.7	Таган буугдах үйл ажиллагааг хуульчлах	Таган буугдах үйл ажиллагааг журмаар зохицуулах нь эрсдэлтэй.

Д/д	Хуулийн төслийн зохицуулалт	Санал	Саналын үндэслэл
17	21.6.5	Дарааллын хамгийн эхэнд (21.6.1) оруулах	Зардал хяналт, нээлттэй байдал, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой.
18	30.4	Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банканд төлбөрийн чадварын эрсдэл нь ойлгомжгүй.	Монголбанк банкны ямар доголдлыг мэдэгдэх
19	32 дугаар зүйл	Хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах санхүүгийн чадамж, мэргэжлийн ур чадвар, хөрөнгө оруулагчдын найдвартай байдлыг хяналтын тогтолцоо, технологийн дэд бүтэц, хараат бусхангах хууль, эрх зүйн орчин сул, санхүүгийн байдал зэрэг тодорхой, хэмжигдэхүйц шалгуурыг эрсдэл өндөр тул хувийн тэтгэврийн сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн тусгах: • Санхүүгийн зохицуулах хорооноос авсан удирдлагыг хэрэгжүүлж байгаа үнэт цаасны зах тусгай зөвшөөрөлтэй байх; • Мэргэжлийн удирдлагын баг, олон жилийн хөрөнгө оруулалтын туршлагатай байх; • Компанийн засаглалын олон улсын зарчмыг мөрдөх (ТУЗ-ийн хараат бус гишүүн, хяналтын тогтолцоо); • Хөрөнгө оруулагчид зориулсан мэдээллийн илтгэл, шуурхай системтэй байх; • Иргэдийн эрх ашгийг хамгаалах хариуцлагын даатгал, санхүүгийн баталгааг хангаж байх зэрэг шаардлагыг нарийн тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих зохицуулалтыг хуульд тодорхой тусгах.	Үнэт цаасны зах зээл хөгжиж буй орны хувьд хөрөнгө оруулагчдын найдвартай байдлыг хэрэгжүүлж байгаа үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд болох хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигддаг шалгуурыг тодорхой, өндрөөр хуульд тусгаснаар хувийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн хөрөнгө оруулагч сонгодог утгаараа хөгжин төлөвших, нэмэлт тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгоход зөргөөр нөлөөлнө.

_____ оОо



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2024.11.19 № 1/3823

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1211 тоот албан бичгээр тус Хороонд ирүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Хуулийн төсөлд тухайн тэтгэврийн сан болон урт хугацааны даатгагч нь тэдгээрийн толгой, охин, хараат, зэргэлдээ компани, мөн үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн холбогдох этгээдийн дангаар, эсхүл хамтдаа эзэмших хувьцааны хяналтын багц эзэмшдэг компани, хөрөнгө оруулалтын сан болон бусад хуулийн этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг шууд хориглосон байна.

Тэтгэврийн сан болон урт хугацааны даатгагч нь хуульд заасан баталгаат өгөөжийг олгох, хөрөнгийн удирдлагыг зохистой түвшинд удирдахад хөрөнгө оруулалт хийх боломж бололцоо нь илүү уян хатан байх нь зүйтэй тул тодорхой хязгаарын хүрээнд хөрөнгө оруулалт хийх боломжтой байхаар хуулийн төсөлд тусгуулах саналтай байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хороо нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр, түүнийг зохицуулах, хяналт тавихтай холбогдох нарийвчилсан харилцааг зохицуулсан 10 гаруй дүрэм, журмыг батлахаар хуулийн төсөлд тусгасан байна.

Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас нийтээр дагаж мөрдөж буй хэм хэмжээний акт, дүрэм, журмын тоог цөөлөх бодлогыг барьж буй бөгөөд үүнтэй холбогдуулан дээрх хуулийн төслөөр тус Хорооноос батлахаар заасан дүрэм, журмуудыг нягталж, зарим зохицуулах харилцааг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн эдгээр дүрэм, журмыг боловсруулах чиглэлээр хуулийн төслийн ажлын хэсэгт ажилласан Азийн хөгжлийн банкны зөвлөх болон бусад холбогдох зөвлөхүүдийн хуулийн төслийг боловсруулах явцад хийсэн санал, зөвлөмж, судалгаа, тайлан, цаашид журмын суурь судалгаа хийхэд шаардагдах статистик мэдээ, мэдээлэл зэрэг холбогдох баримт бичгүүдийг ирүүлэх болон бусад чиглэлээр тус Хороотой хамтран ажиллахыг хүсье.

Хуулийн төсөлтэй холбогдох бусад саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА




Д.БАЯРСАЙХАН

1518003711

1518003711

Санхүүгийн зохицуулах хорооны
2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн
1/3823... тоот албан бичгийн хавсралт



ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛУУД

1. Төсөлд тусгагдсанаар тэтгэврийн сан нь 20 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, ажилтнуудтай компани байх бөгөөд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг өөрөө удирдах чадамжтай хүний нөөцийг бүрдүүлээд ажиллах боломжтой байх тул тухайн тэтгэврийн сан нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг бие даан удирдах зохицуулалтыг тусгах, үүнтэй ижил урт хугацааны даатгагч нь мөн тэтгэврийн хөрөнгийг өөрөө удирдах боломжтой байхаар тусгах нь зүйтэй. Харин энэ тохиолдолд тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь тэтгэврийн хөрөнгийг зүй зохистой удирдах мэргэжлийн буюу хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн багтай байх шалгуурыг тусгах шаардлагатай;
2. Төслийн 10.2-т “Хороо энэ хуулийн 10.1-д заасан зардлын дээд хувь хэмжээг тогтоож болно.” гэж заасан ба хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь үйл ажиллагааны орлого, зардлаа өөрөө удирдах бөгөөд Хороо тогтоох нь бизнесийн үйл ажиллагаанд хэт оролцсон зохицуулалт байх тул хасах;
3. Төслийн 12.3.2-т заасан “төрийн эрх бүхий байгууллагын санхүүгийн хяналт шалгалтад хамрагддаг байх” гэдэгт бүхий л аж ахуйн нэгжүүд орох боломжтой мэт ойлгогдож байх тул тодорхой болгон тусгах;
4. Төслийн 12.3.2, 12.9.8, 15.1.1, 15.1.5, 30.1, 44.4, 44.5, 49.1 дэх хэсэгт “эрх бүхий байгууллага” гэсэн нь ямар байгууллагыг хэлж байгаа нь ойлгомжгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн тодруулах нь зүйтэй;
5. Төслийн 12.3.3-т “олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллага” гэдгийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байгааг анхаарах;
6. Төслийн 12.8.1, 12.9.8 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах;
“12.8.1.хувийн тэтгэврийн санг хугацаагүй үүсгэн байгуулсан тухай компанийн шийдвэр;
12.9.8.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрх бүхий байгууллага болон гишүүдэд ил тод тайлагнах;”
7. Төслийн 13.6.4-т заасан “өмнө удирдаж байсан хуулийн этгээд” гэснийг нарийвчилж зохицуулах;
Тухайлбал: “Санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийг удирдаж байсан бөгөөд өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн хуулийн этгээдийг татан буулгаагүй байх,” гэж нарийвчлан зохицуулах;
8. Төслийн 13.6.5-д “энэ хуулийн 13.4-т зааснаас бусад Удирдах зөвлөлийн гишүүн нь санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх” гэж заасныг хэрхэн тодорхойлох, тухайн чиглэлээр сургалтад суусан нь тооцогдоод явах боломжтой байхаар ойлгогдож байгаа тул холбогдох чиглэлээр дээд боловсролтой байх, мөн санхүүгийн салбарт тодорхой хугацаанд ажилласан туршлагатай байх шалгуурыг тавих нь зүйтэй;

9. Төслийн 13.7-д удирдах зөвлөл нь ээлжит бус хурлыг Компанийн тухай хуульд заасны дагуу хуралдуулна гэж заасан боловч тус хуульд төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлын талаарх зохицуулалт байхгүй тул өөрчлөн найруулах;
10. Төслийн 13.8.1, 13.8.3-д заасан банканд данс нээх, бусад этгээдтэй гэрээ байгуулах зөвшөөрлийг хэнд олгохыг тодорхой заах;
11. Төслийн 14.2-т заасан “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж өөрчлөх;
12. Төслийн 14.6-д “Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Хороо хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно” гэж заасан нь тухайн хувийн тэтгэврийн санд энгийн зөвшөөрөл олгохоор байна. Уг тэтгэврийн сангийн үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөлд хамаарч байгааг анхаарах;
13. Төсөлд урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл нь түдгэлзсэн эсхүл хүчингүй болох нөхцөлд урт хугацааны даатгагч дээрх тэтгэврийн хөтөлбөрийг хэрхэх талаар зохицуулалтыг тусгах шаардлагатай;
14. Төслийн 15.1 дэх заалтыг дараах агуулгаар өөрчлөн найруулах;
“15.1.Хороо дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:
15.1.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг, даалгаврыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;”
15. Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг орхигдуулсан байх тул Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дараах агуулгаар Төслийн 15.2, 15.3, 15.4 дэх хэсгийг өөрчлөн найруулах:

“15.2.Хороо энэ хуулийн 15.1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.

15.3.Энэ хуулийн 15.2 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш тусгай зөвшөөрөл эзэмшигч ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

15.4.Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд ажлын хоёр өдрийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.”

/Эдгээр 3 заалтыг өөрчилсөнтэй холбогдуулан төслийн 15.5 дахь хэсгийг хасах, мөн төслийн 15.6 дахь хэсгийн дугаарлалт болон тухайн хэсэг доторх хуулийн иш татсан хэсгийн дугаарлалтыг өөрчлөх/

16. Зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл буюу төслийн 16.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий заалтыг нэмэх;

“16.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

16.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч дампуурсан, эсхүл татан буугдсан;”

17. Төслийн 18.1 дэх хэсгийн “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж өөрчлөх;

18. Төслийн 18.2 дахь хэсгийн “шалган шийдвэрлэж” гэснийг “хянан шийдвэрлэж” гэж өөрчлөх;
19. Төслийн 19 дүгээр зүйлд заасан “..хөтөлбөрийг түдгэлзүүлэх” гэснийг “..хөтөлбөрийг түр зогсоох” гэж өөрчлөн найруулах;
Учир нь түдгэлзүүлэх харилцаа нь ихэвчлэн тусгай болон энгийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх харилцаанд хэрэглэгддэг бөгөөд аливаа бүртгэл, эрхийн хувьд түүнийг түр зогсоох, хасах гэх мэт нэр томъёог хэрэглэвэл зохистой байна. Иймд төслийн 19 дүгээр зүйлд заасан хөтөлбөрийг түдгэлзүүлэх харилцааг “хөтөлбөрийг түр зогсоох” гэж өөрчлөн найруулж хуулийн төсөлд хэрэглэж оруулах нь зүйтэй байна;
20. Төслөөс бүтцээс харахад хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсны дараа нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, хасах харилцааг зохицуулж бичсэн байна. Бүтэц талаасаа дарааллын хувьд төөрөгдөл үүсэхээр бичигдсэн байх тул эхлээд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх харилцааг бичээд дараа нь тухайн харилцааг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг дарааллуулж бичих нь хууль тогтоомжийн хэрэглээний хувьд зохистой байна;
21. Төслийн 17.5-д “Энэ хуулийн 17.4-т заасан хөрөнгийг урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас бусад байдлаар болон хөтөлбөрт холбогдохгүй өр төлбөрийг барагдуулахад зарцуулах, батлан даалт гаргах, барьцаалахыг хориглоно.” гэж заасны нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа орж байгаа эсэх, тодорхойгүй байгаа тул ойлгомжтой болгох;
22. Төслийн 23.5-д “... Хорооноос баталсан шаардлагыг хангасан...” гэж заасныг тодорхой болгох эсхүл хасах;
23. Төслийн 26.1.4-т “хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх” нь 26.1.3-т заасан хөрөнгө оруулалтад хамаарах тул энэ заалтаас хасах;
24. Төслийн 27.1 дэх хэсэгт заасан хориглосон хөрөнгө оруулалтаар тухайн тэтгэврийн сан болон урт хугацааны даатгагчийн хөрөнгө оруулалтыг хэт хязгаарласан байх тул эдгээр төрлийн хөрөнгө оруулалтыг тодорхой хязгаарын хүрээнд хийх боломжтой байхаар хуульд заах нь зүйтэй;
25. Төслийн 27.3-т “ашиг сонирхлын зөрчил бүхий” гэдэг нь ямар хэлцлийг ойлгох нь тодорхойгүй байна. Харин Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлж байгаа тохиолдолд тухайн хуулиараа зохицуулагдах харилцаа байгааг анхаарах;
26. Төслийн 30.3-т “Хороо кастодианы бүтэц болон санхүүжилтийн доголдол үүссэн талаар хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, Төв банк (Монголбанк)-анд ажлын нэг өдрийн дотор мэдэгдэнэ. Төв банк (Монголбанк) кастодианы доголдол үүссэн талаар Хороо, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид мэдэгдэнэ.” гэж заасан бөгөөд Хороо мэдэгдэх, нөгөө талаас Монголбанк мэдэгдэх гэсэн тусдаа 2 зохицуулалтыг тусгасан байгааг салгаж оруулах;
27. Төслийн 34.2 дахь хэсэгт зааснаар Хороо хөрөнгийн үнэлгээ хийхээр зохицуулсан байх бөгөөд түүнийг хэрхэн, яаж хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтыг төсөлд тусгаагүй байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна;
28. Төслийн 42.1 болон 42.2 дахь хэсгүүд нь хоорондоо давхацсан байх тул хасах;
29. Төслийн 44.3-т “70 дээш жил” гэснийг “70-аас дээш жил” гэж өөрчлөх;

30. Төслийн 47.4-т “Шаардлагатай тохиолдолд Хороо энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээ авна” гэж заасан нь хэт ерөнхий, тодорхойгүй байх тул хасах эсхүл нарийвчлан заах.

--oOo--



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17011

Утас: 7727 7070, Факс: (976-11) 32 46 20,

Цахим шуудан: chamber@mongolchamber.mn

2024.11.18 № 02/1003

танай 2024.11.12-ны № 01/1211 -т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Таны энэ өдрийн амрыг эрье. Хувийн нэмэлт
тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй танилцлаа.
МҮХАҮТ-ын зүгээс хуулийн төсөлд тусгах саналаа
үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ДҮҮРЭН



0001851

**ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

№	Төслийн холбогдох зүйл, хэсэг, заалт	Санал, тайлбар
1.	7.4 Нэмэлт тэтгэврийн гэрээнд нэмэлт тэтгэврийн журмыг хавсаргана.	Гэрээнд журам хавсаргахын хууль зүйн үр дагавар нь тодорхойгүй байна. Хавсаргаснаар түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох уу? Эсхүл зөвхөн тухайн үеийн нөхцөлийг танилцуулах зорилготой юу? Журмыг сан батлах учраас дангаар өөрчлөлт оруулах эрхтэй гэж ойлгож байна. Журмыг өөрчлөх замаар гэрээний нөхцлийг өөрчлөх боломжгүй байх талаар тодорхой зааж өгөх.
2.	8.4 Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх нийт шимтгэлийн 50-аас доошгүй хувийг ажил олгогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө. Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны төлөх шимтгэлийн дээд хэмжээ нь сарын нийт шимтгэлийн хэмжээний тавин хувиас, шимтгэлийн сарын нийт дүн нь тухайн ажилтны сарын үндсэн цалингийн хорин хувиас тус тус хэтрэхгүй байна.	Энэ хэсэгт ажилтны төлөх шимтгэлийн хэмжээг тодорхойлоогүй боловч ажил олгогчийн төлөх шимтгэл хамгийн багадаа 50-аас доошгүй байхаар заасан нь ажилтан, ажил олгогч нар харилцан тохиролцож тогтоох боломжийг хязгаарласан тус хуулийн 4.1.1-д заасан сайн дурын байх зарчимд нийцэхгүй байна. Энэ нь ажил олгогчийн зүгээс уг хөтөлбөрийг санаачлах сэдлийг бууруулах эрсдэлтэй.
3.	31.5 Гишүүн нэмэлт тэтгэврийн хөрөнгөө өөр хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлэхэд татвар ногдуулахгүй.	Хуулийн заалт хоорондоо зөрчилдвөл илүү нарийвчилсан хуулийн заалтыг баримталдаг тул энэ заалтыг татварын хууль тогтоомжид зайлшгүй тусгах шаардлагатай.
4.	40.4. 38.4 Эрх залгамжлагч, өвлөгч гишүүний амь насыг хохироосон нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол тухайн эрх залгамжлагч, өвлөгчид нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэхгүй.	Хэрэв нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлсний дараа гишүүний амь насыг хохироосон нь шүүхээр тогтоогдсон бол буцаан шаардах эрх хэнд үүсэх талаар тусгах шаардлагатай.
5.	14.7 Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо батална.	Санал: Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах гол нөхцөл, шаардлагыг энэхүү хуульд тусгах нь зүйтэй.
6.	25.2 Хорооноос тогтоосон журмын дагуу хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хөрөнгө оруулалтын бодлого болон эрсдэлийн удирдлагын бодлогыг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж байгаа гишүүнд тухай бүр мэдэгдэнэ.	Санал: 25.2-т заасан журам нь ямар журам гэдэг нь тодорхойгүй байна. Энэхүү хуулийн төсөлд тусгасан журам, одоо хүчин төгөлдөр байгаа журам уу? гэдгийг тодруулах шаардлагатай.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, <http://www.ndaatgal.mn>

2024.11.25 № 01/2438
танай 2024.11.12 -ны № 01/1211 -т

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМАНД**

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-тэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Хуулийн төслийн 4.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан иргэн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авч болно” гэснийг “Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан даатгуулагч (иргэн) сайн дурын үндсэн дээр хамрагдана.” гэж өөрчлөх саналтай байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ГАНЦЭЦЭГ



1524983314



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2024.12.26 № А-1/969
танай _____-ны № _____-т

Г Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай Г

Танай 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ирүүлсэн 01/1211 дугаартай албан бичгээр Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ” гэж заасан зорилтын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд санал авахаар ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох нь дотоодын санхүүгийн зах зээлийн хөгжлийн нэг дэвшил тул түүний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор боловсруулан ирүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна.

Хувийн тэтгэврийн сан болон урт хугацааны даатгагч заавал давхар даатгалд хамрагдах зохицуулалтыг тусгаж олон улсын давхар даатгал компаниудад даатгагддаг сайн туршлагыг хэрэгжүүлэх нь цаашид Хувийн тэтгэврийн сан болон урт хугацааны даатгагч тогтвортой үйл ажиллагаагаа эрхлэх таатай нөхцөл үүсэх юм.

Мөн Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан стандартын Зөвлөмж 10-т тэтгэвэр, хуримтлалын тэтгэврийн тогтолцоо нь цалингаас суутгал хийх зарчмаар хэрэгждэг бол мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бага гэж үзсэн байдаг.

Харин “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төслийн 6.2-т нэмэлт тэтгэврийн хөтөлбөр нь хувь хүний болон ажил олгогчийн гэсэн хоёр төрөлтэй байхаар тусгасан байх бөгөөд мөн төслийн 7, 8 дугаар зүйлд ажил олгогчийн хөтөлбөртэй холбоотой зохицуулалтыг тусгасан байх боловч, хувь хүний нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой зохицуулалтууд дутмаг байна.

Тухайлбал, хуулийн төслийн 8.2-т шимтгэлийг хувь хүн, ажилтан дангаараа төлөхөөр заасан байх боловч төлөх шимтгэлийн дээд хязгаар, давтамж болон хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдах боломжтой хувь хүнд тавигдах шаардлагыг тодорхой заагаагүй байна. Энэ нь хувь хүн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлогынхоо хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, хуулийн хариуцлагаас зайлсхийх, гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны мэт болгон цэвэршүүлэх зорилгоор хувийн нэмэлт тэтгэврийн санг урвуугаар

1524023474

ашиглах эрсдэл үүсгэж байх тул хувь хүний төлөх шимтгэлийн эх үүсвэрийг нотлохтой холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт “Баталгаат өгөөжийн жилийн доод хэмжээ нь Төв банк (Монголбанк)-ны бодлогын хүүгээс багагүй байна.” гэж заасан байх бөгөөд энэ нь Төв банкны бодлогын хүүтэй уялдуулах нь зохисгүй бөгөөд эдгээр нь цаг хугацааны хувьд зөрчилдөхөөс гадна, зорилго, чиглэлийн хувьд ялгаатай юм. Тэтгэврийн сан нь шимтгэл төлөгчдийн хувьд урт хугацааны, өгөөж өндөр хөрөнгө оруулалт байх нь чухал. Харин Төв банкны бодлогын хүү нь харьцангуй богино хугацаат мөнгөний захын хүүд нөлөөлөх замаар инфляц, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж өөрчлөгдөж байдаг хүү тул Төв банкны бодлогын хүү зах зээлийн урт хугацаат хүүгээс доогуур түвшинд байдаг. Баталгаат өгөөжийн хувь хэмжээг тогтоохдоо олон улсын туршлагыг судалж, санхүүгийн зах зээлийн зарчимд тулгуурлан илүү тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой жишиг хүү ашиглах нь зохимжтой бөгөөд бодлогын хүү нь тогтмол биш зах зээлээс хамаарч өөрчлөгдөх боломжтой ба Мөнгөний бодлогын хороо улирал бүр хуралдаж шийдвэрээ гаргаж, бууруулж эсхүл өгсөх боломжтой байдаг.

Иймд баталгаат өгөөжийн доод хэмжээг нарийвчлан тодорхой заах эсхүл хүүгийн түвшнийг хоёр тал харилцан тохиролцож гэрээнд тусгах зэрэг боломжтой бөгөөд “баталгаат өгөөжөөс давсан өгөөж” гэх ойлголтыг хэрхэн тооцож, тодорхойлох талаар зохицуулалтыг тусгах саналыг хүргүүлж байна.

Хуулийн төсөлд өгөх бусад саналыг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт /З/хуудастай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны
1-р дугаар сарын 2-ны өдрийн 11-18/24
12-р дугаар сарын 2-ны өдрийн дугаар
албан бичгийн хавсралт

МОНГОЛБАНКНААС “ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-Д ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

№	Төслийн зүйл, заалт	Санал	Тайлбар
1.	5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 5.1.18.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэг цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан хуулийн этгээдийг;	Өөрчлөн найруулах.	Үнэг цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33 дахь заалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна.
2.	7.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажилтан, хувь хүнтэй нэмэлт тэтгэврийн гэрээг бичгээр, хугацаагүй байгуулах бөгөөд талуудын	Хуулийн төслийн 7.3-т Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажилтан, хувь хүнтэй нэмэлт тэтгэврийн гэрээг цаасаар болон цахимаар байгуулах гэж нэмэх.	Иргэний хуульд цахим гэрээ хийх зохицуулалтыг тусгасан байдаг.

	зөвшөөрөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.		
3.	8.4.Ажил оллогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх нийт шимтгэлийн 50-аас доошгүй хувийг ажил оллогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө.	Ажил оллогч нийт шимтгэлийн 50-аас доошгүй хувийг олоно гэснийг ажил оллогч нэмэлт тэтгэврээс төлдөггүй байхаар зохицуулах эсхүл доод хэмжээг тогтоож ажил оллогчийн хувийг бууруулах. Ажилтан хүсвэл өөрөө төлөөд явдаг байх нь ААН-үүдийн өсөлтөд тустай болно.	Ажил оллогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд "... нийт шимтгэлийн 50-аас доошгүй хувийг ажил оллогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө" гэж заасан нь ажил оллогч нарийн хувьд хэт өндөр босго болж байна. Ийнхүү ажил оллогчийн төлөх хувийг 50-с доошгүй гэж өндөр тогтоох тохиолдолд одоогийн сайн дураар нийгмийн даатгалаа өндрөөр төлөхөөс ялгаатай үр дүн гарахгүй болох эрсдэлтэй гэж харж байна. Энэ босгыг магадгүй 10-20% гэж доод хэмжээг тогтоовол том компаниуд магадгүй 50%-иар төлөөд жижиг компаниуд 10-20%-иар төлж болно. Хуулинд ийм өндөр босго оруулвал жижиг компаниуд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болохоор байна.
4.	11.6.Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөс гишүүний эрүүл мэндийн үйлчилгээний зардал, сургалтын төлбөр, орон сууц худалдан авах төлбөрт зарцуулах хүсэлт	Энэ үйл ажиллагаа нийгмийн шинжтэй харилцааг зохицуулахаар байх тул тус журмыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам багтах нь зүйтэй гэж үзэж байна.	

	хүлээн авах, шийдвэрлэх, шилжүүлэх, бүртгэх, тайлагнах журмыг Хороо батална.		
5.	12.3.6.хувь нийлүүлсэн хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд байршуулсан байх; 26.1.Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр дараах хөрөнгө оруулгад хөрөнгө оруулна: 26.1.1.Төв банк (Монголбанк)-наас тавьсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан банкны системд нөлөө бүхий банкны мөнгөн хадгаламж, хадгаламжийн сертификат	Хасах эсхүл өөрчлөн найруулах.	Зөвхөн банкны системд нөлөө бүхий банк гэх нь шударга өрсөлдөөний зарчмыг алдагдуулах эрсдэлтэй байна.
6.	12.4.Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болох 20 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэх.	Даатгуулагчид учирч болзошгүй эрсдлийг бууруулах, хувийн даатгалын байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх

	хөрөнгийн доод хэмжээ нь 20 тэрбум төгрөг байна. Энэхүү хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, хувийн тэтгэврийн санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг харгалзан Хороо тухай бүрд нэмэгдүүлэн тогтооно.		шаардлагагай тул хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болох 20 тэрбумыг нэмэгдүүлж тогтоох.
7.	12.8.Хувийн тэтгэврийн сангийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараах зүйлийг тусгана: 12.8.3. хөрөнгө оруулалтын өгөөж баталгаат өгөөжөөс бага бол үүсгэн байгуулагч өөрийн хөрөнгөөс нөхөж олгохтой холбогдсон зохицуулалт.	Хуулийн төслийн 9.4 дэх хэсэгт өгсөн саналтай уялдуулан хасах.	9.4-г Баталгаат өгөөжийн жилийн доод хэмжээ нь Төв банкны бодлогын хүүгээс багагүй байна гэж заасан байна. Энэ нь урт хугацааны хөрөнгө оруулалт хийх талаар ярьж байгаа бөгөөд урт хугацаанд бодлогын хүү болон зах зээлийн хүү өсөх, буурах чиглэлд хөдөлнө. Хүүгийн түвшин буурах тохиолдолд Хөрөнгө оруулалтын менежментийн компанид алдагдал үүснэ, харин өссөн тохиолдолд шимтгэл төлөгчийн хувьд алдагдал үүснэ. Учир нь алдагдсан боломжийн зардал нь нэмэгдэнэ. Ер нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ зах зээлийн зарчмаар тогтох ёстой бөгөөд ийнхүү хүүгийн түвшнийг хуулиар

			тогтоох нь буруу гэж үзэж байна. Иймд хүүгийн түвшнийг хоёр тал харилцан тохиролцож гэрээнд тусгах нь зохистой гэж үзэж байна.
8.	13 дугаар зүйл.Хувийн тэтгэврийн сангийн удирдлага, зохион байгуулалт	13.9 “Хувийн тэтгэврийн сан нь дотоод аудитын хороотой байх бөгөөд уг хорооны дарга нь удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.” гэж нэмэх.	Засаглалын хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу сан өөрөө өөрийгөө хянах тогтолцоог зайлшгүй тусгах шаардлагатай.
9.	13.4.Энэ хуулийн заасан гишүүний төлөөлөл удирдах зөвлөлийн гуравны нэгээс доошгүй хувь байх бөгөөд олонхын саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгоно.	Гишүүдийн төлөөллийг хэрхэн сонгох талаар тодорхой болгох.	Гишүүдийн төлөөллийг хэрхэн сонгох нь тодорхойгүй байна. Бүх гишүүдийн хурлаас өөрсдийн эрх ашгийг төлөөлөх хүнийг сонгоно гэж ойлговол энэ заалт зүйтэй. Түүнээс биш гишүүдээс 3 нь удирдлагад орно гэвэл засаглалын хувьд ийм байж болохгүй.
10.	13.4.Энэ хуулийн заасан гишүүний төлөөлөл удирдах зөвлөлийн гуравны нэгээс доошгүй хувь байх бөгөөд олонхын саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгоно.	Олонхын санал гэдгийг тодорхойлох.	ТУЗ-ийн гишүүдийн олонх эсэх эсхүл 5.1.7-д заасан гишүүний олонх эсэх Хэрэв 5.1.7-д заасан гишүүдийн олонх бол санал хураах харилцааг тодорхойлох.

	14.4.Хороо нь энэ хуулийн 14.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг ирүүлэхийг шаардах, тодруулга, тайлбар авах эрхтэй. 14.5.Хороо зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 45 өдрийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.	Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх.	Хуулийн төслийн 14.4 болон 14.5 дахь хэсэгт заасан хугацааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаатай нийцүүлэх.
11.	16.1.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:	16.1.5 “Компанийн тухай хуулийн 31.3-д заасан нөхцөл байдал тогтоогдсоноос хойш 90 (тодорхой хугацааг тогтоох) хоногийн дотор дахин хөрөнгөжүүлээгүй,” гэж нэмэх.	Өөрийн хөрөнгийн үзүүлэлт буурснаас шалтгаалж тусгай зөвшөөрөл түдгэлзэх болон хүчингүй болох нөхцөл байдлыг зохицуулсан зохицуулалт тусгагдаагүй байна.
12.	23 дугаар зүйл. Хөрөнгө оруулалт хийх	Хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа манай улсад жигдрээгүй байгаа нь сангийн хөрөнгийг эрсдэлд оруулж болзошгүй байна;	

13.	26.1.Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр дараах хөрөнгө оруултад хөрөнгө оруулна: 26.1.2.Засгийн газрын үнэт цаас, аймаг, нийслэлийн үнэт цаас, Засгийн газрын өрийн баталгаа бүхий үнэт цаас, Төв банк (Монголбанк)-ны үнэт цаас;	“Төв банк (Монголбанк)-ны үнэт цаас” гэдгийг хасах.	Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх гол санхүүгийн хэрэгсэл бол Төв банк (Монголбанк)-ны үнэт цаас бөгөөд тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын хэрэгсэл байх нь зохимжгүй юм. Ирээдүйд мөнгөний бодлогын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлийн бий болгох эрсдэлтэй гэж үзэж байна. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нээлттэй зах зээлийн үндсэн хэрэгсэл бөгөөд Монголбанк нь хуулиар олгогдсон эрх үүргийн дагуу банк хоорондын зах (БХЗ)-ын богино хугацаат хүү болон нөөц (liquidity)-ийн хэлбэлзлийг удирдах зорилгоор хугацаа (maturity), хүү, арилжаалагдах хэлбэрээр ялгаатай ТБҮЦ-ыг банкуудад арилжаалдаг буюу Мөнгөний нийлүүлэлтийг хянах мөнгөний бодлогын арга хэрэгсэл юм.
14.	26.1.Нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр дараах хөрөнгө оруултад хөрөнгө оруулна:	26.1.5 дахь заалтад “гадаад улсын банкны мөнгөн хадгаламж, сертификат, үнэт цаас” гэснийг “гадны зэрэглэл тогтоогч байгууллагуудаас тогтоосон А+ дээш зээлжих зэрэглэлийн үнэлгээтэй гадаад улсын банкны мөнгөн	Тус хуулийн 26.1.5-д заасан хөрөнгө оруулалтын ангилалд тусгасан гадаад үнэт цааснуудын төрлийг хориглох хэрэгтэй. Олон улсын санхүүгийн байгууллагууд санхүүгийн салбар бага хөгжсөн, хөгжиж буй орнуудын тэтгэврийн санд гадаад хөрөнгө оруулалтыг хязгаарлахыг

	26.1.5.Гадаад улсын банкны мөнгөн хадгаламж, хадгаламжийн сертификатыг үнэт цаас.	хадгаламж, хадгаламжийн сертификат” гэж өөрчлөх.	зөвлөдөг. Гадаад хөрөнгө оруулалт нь валютын ханшийн хэлбэлзэл, дэлхийн зах зээлийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалан эрсдэл үүсгэдэг. Тиймээс эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан эрсдэлийг бууруулах үүднээс хөрөнгө оруулалтыг дотоодын зах зээлээр хязгаарлах, үүнд олон улсын туршлагыг судлан тусгах. Түүнчлэн хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулж байгаа нь институционал хөрөнгө оруулагчийг бий болгож байгаа бөгөөд дотоодын хөрөнгийн захыг гүнзгийрүүлэх зорилготой юм. Энэхүү зорилгыг биелүүлэх хувийн тэтгэврийн тогтолцооны хөгжилд оруулах хувь нэмрийг бий болгохын тулд гадаадад хөрөнгө оруулалтыг хориглох нь зүйтэй.
15.	31.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгач нь урт хугацааны даатгач нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар итгэмжлэн удирдуулж болно.” гэж өөрчлөн найруулах эсхүл хасах.		Сан заавал хөрөнгө итгэмжлэн удирдуулах албагүй. Уг сан нь өөрөө хөрөнгө оруулалтаар мэргэшсэн компани байх ёстой. Эрсдэлээ тараан байршуулах зорилгоор хөрөнгийн тодорхой хэсгийг өөр компаниар итгэмжлүүлэн удирдуулж болно. Түүнээс биш заавал ХОМК хөрөнгийг удирдах албагүй. Эхнээсээ сан өөрөө ХОМК шиг ажиллах ёстой. Хөрөнгө оруулалтын менежментийн чадвартай Хувийн тэтгэврийн сан болон

			урт хугацааны даатгагчид хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох нь зохимжтой бөгөөд хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг нөлөөтэй гэж үзэж байна.
16.	32 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур	Хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур хангалтгүй байна. Хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавигдах шалгуур, хөрөнгийг удирдах менежер тавигдах шалгуурыг маш нарийн чанга, тодорхой болгож хуульд суулгаж өгөх шаардлагатай. Учир нь хөрөнгийн удирдлагын компани нь бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж, цааш гадаад, дотоод зах зээл дээр байршуулан ашиг олох үйл ажиллагаа явуулах этгээд юм. Хөрөнгийг ийнхүү удирдах явцад зээлийн эрсдэл, ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл гэх зэрэг санхүүгийн эрсдэлүүд үүсэх бөгөөд үүнийг удирдах чадвар бүхий хүний нөөц, програм хангамж, зохистой засаглалын тогтолцоотой байх шаардлагатай. Мөн хяналтын тогтолцоо нь зохистой байх шаардлагатай. Эдгээр зарчмын асуудлууд хуульд суусан байх шаардлагатай гэж үзэж байна.	
	35.2.Нэмэлт тэтгэврийн гэрээ,	Тус хуулийн төслийн 35.2-т заасан нэмэлт тэтгэврийн гэрээ, журамд нэмэлт тэтгэврийн	

	журамд нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх нөхцөл, шаардлагыг тусгана.	хөрөнгийг шилжүүлэх нөхцөл, шаардлагыг тусгахад дараах зүйлийг анхаарах шаардлагагай. Тэтгэврийн сан нь хувь хүний урт хугацааны хөрөнгө оруулалт учраас хугацааны явцад санг удирдаж байгаа хуулийн этгээд, түүний бизнес загвар, хөрөнгө оруулалтын хэв шинж өөрчлөгдөж болно. Хувь хүн өөрийн тэтгэврийн сангийн эдгээр өөрчлөлттэй санал нийлэхгүй, эрсдэлтэй гэж тооцсон тохиолдолд өөр санд шилжүүлэх, эсвэл анхлан тохирсон нөхцөлийн дагуу хөрөнгөө эргүүлэн татан эрхтэй байх шаардлагагай.	
17.	37 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн эрх үүсэх, төрөл, олгох нөхцөл	Хуулийн төслийн 6 дугаар бүлэг 37 дугаар зүйлд ажил олгогч болон тэтгэвэр тогтоолгох нас хүрээгүй ажилтан хоорондын хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох тохиолдолд ажилтны төлсөн шимтгэлийг буцаан олгох эсхүл шилжүүлж болох талаар зохицуулалтыг тусгах.	
18.	37.5.Насан туршийн тэтгэвэрт хамрагдахад шаардагдах этгэврийн нэрийн дансны хадгалагдсан эрхийн доод хязгаарыг тэтгэврийн журам, гэрээгээр тогтооно.	Насан туршийн тэтгэвэр авах хугацааны илэрхийллийг хэрхэн, яаж тооцохыг тодорхой тусган оруулах.	

	Тайлбар: “насан туршийн тэтгэвэр” гэж гишүүний тэтгэврийн наснаас хойш нэмэлт тэтгэвэр авах хугацааны илэрхийлэлд үндэслэн тооцож, нас барах хүртэл хугацаанд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.			
19.	38 дугаар зүйл.Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх	Хуулийн төслийн 38 дугаар зүйлд "Эрх залгамжлагч, өвлөгчид хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх" тухай зохицуулалтын 38.1, 38.2-д "... нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ." гэж зохицуулсан байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйл "Хуулийн нэр томъёоны тодорхойлолт"-ын 5.1.4-д "нэмэлт тэтгэврийн нэрийн данс" гэж хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас гишүүний нэр дээр бүртгэсэн нийт шимтгэл, баталгаат өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөж, зарлагыг тусгасан мөнгөн хуримтлалын бүртгэлийг" гэж зааснаар нэрийн данстай байхын тулд хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хамрагдсанаар нэмэлт тэтгэврийн нэрийн дансны бүртгэлтэй болохоор ойлгогдож байгаа юм. Энэ нь хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан "сайн дурын байх" гэсэн үйл ажиллагааны зарчимтайгаа		

		уялдахгүй, мөн төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.2-д заасан нэмэлт тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн нэг болох "тэтгэвэр хүлээн авах банкны нэр, дансны дугаар" гэсэн заалттай нийцэхгүй байна.	
20.	42.1.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.	Хасах.	Нэг ижил хоёр заалт байна. Хуулийн төслийн 42.1-д “Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.”
Нэмэлт санал			
21.		Хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг СЗХ өгөх, эргээд тэдгээрт хяналт тавих тохиолдолд энэ үйл ажиллагаанд төрийн оролцоо ямар байхыг хуульд тодорхой тусгах.	
22.		Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос үүдэн ажилтан, хувь хүний төлсөн шимтгэлийн тодорхой хэсгийг даатгалын компаниар төлүүлэх зохицуулалт оруулах.	
23.		Даатгуулагч Улсын тэтгэврийн тогтолцоо болон Хувийн тэтгэврийн тогтолцооноос аль нэгийг сонгон даатгуулах сонголттой байх зохицуулалтыг тусгах.	Даатгуулагч улсын тэтгэврийн тогтолцоо болон хувийн тэтгэврийн тогтолцооноос өгөөж, өөрийн ирээдүйн санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан аль нэгийг сонгох шаардлагатай. Ингэснээр үр ашиг муутай улсын тэтгэврийн тогтолцоог

		халах, шинэчлэлийг байдал үүсэх юм.	эхлүүлэх нөхцөл
24.		Дэлхийн зарим орнуудад Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгө удирдлагыг хийхдээ үндэсний томоохон ордууд, баялгийн сан зэрэгт хөрөнгө оруулж, түүнээсээ өгөөж авах байдлаар үр өгөөж өндөртэй, урт хугацааны хөрөнгө оруулалтуудыг хийдэг байна. Энэ талаар судалж, хуульд тусгах боломжтой эсэх талаар судлах.	
25.		Хуулийн төслийн үг, найруулгын алдааг дахин хянах шаардлагатай байна.	



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО

MONGOLIAN ASSOCIATION OF
SECURITIES DEALERS

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө
Express tower 11-01

Утас: 976-70123339
E-mail: info@masd.mn
Web site: www.masd.mn

2024.11.15 № 663

Танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн 2024.11.04-ны өдрийн 04/1095 тоот албан бичигтэй танилцан “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл”-д Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлж байна.

Дээрх зохицуулалт нь ажил олгогч, ажилтан, бизнесийн орчин, хөрөнгийн зах зээл, даатгалын салбарт ач холбогдол бүхий шинэ зохицуулалт болно. Хуулийн төсөл боловсруулах явцад даатгалын салбараас гадна хөрөнгийн зах зээлийн тогтолцоо, тэр дундаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нийцүүлэх шаардлага үүсдэг.

Хавсралтад дурдсан саналуудаас гадна нэмэлт санал гарах нөхцөл байдал үүсэж болзошгүйг харгалзан үзэж мөн хуулийн төслийг амжилттай батлуулахад шаардлагатай хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг цаг хугацаанд баригдахгүй олон талыг хамруулж ажиллахыг хүсье.

Хавсралт... хуудастай.

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.БУЯНХИШИГ

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛАХ САНАЛ

№	Хуулийн төслийн заалт	Санал	Тайлбар
1.	7.1.3 дахь заалт	Нэмэх	"7.1.3. эрх залгамжлагчийн тухай" гэснийг "эрх залгамжлагч, өвлөгчийн тухай" гэж нэмэх саналтай.
2.	7.1.4 дахь заалт	Өөрчлөн найруулах	"7.1.4. баталгаат өгөөж" гэснийг "баталгаат өгөөжтэй эсэх тухай" гэж өөрчлөн найруулах. "7.1.5. гишүүнд баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг олгох нөхцөл" гэснийг "хэрэв баталгаат өгөөжтэй бол гишүүнд баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг олгох нөхцөл" гэж өөрчлөн найруулах.
3.	7.1.5 дахь заалт	Өөрчлөн найруулах	Хувийн тэтгэврийн сан нь хөрөнгийн өгөөжийг өндөр байлгах дээр анхаарч ажиллах ч баталгаат өгөөж амлах нь хадгаламж, өрийн бичигээс бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах боломжийг хязгаарлаж байна. Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалт нь урт хугацааных байх ба богино хугацааны өгөөжийн хэлбэлзэл хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байхыг хуульчилж зохицуулах байгууллага (СЗХ) хэлбэлзэх түвшинг журамлах нь зохимжтой.
4.	7.5 дахь заалт	Нэмэх	"7.5. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн нэмэлт тэтгэврийн гэрээгээр хүлээсэн үүрэг нь гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нэмэлт тэтгэвэр авч дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна" гэж заасанд гишүүн нь нэг эсхүл хэд хэдэн эрх залгамжлагчийг (ижил эсхүл ялгаатай хувь хэмжээгээр нэмэлт тэтгэвэр авах эрхтэй байхаар) гэж нэрлэн зааж эрх зүйн боломжийг хуульд нэмэлтээр оруулах.
5.	5.1.9 дэх заалт	Өөрчлөн найруулах	Дээрх тохиолдолд "5.1.9. "эрх залгамжлагч" гэж нас барсан гишүүний хадгалагдсан эрх, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх авах гишүүний нэрлэсэн хүнийг" гэснийг "эрх залгамжлагч" гэж нас барсан гишүүний хадгалагдсан эрх, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг шилжүүлэх авах гишүүний нэрлэсэн нэг эсхүл хэд хэдэн хүнийг гэж өөрчлөн найруулах.
6.	8.2 дахь заалт	Өөрчлөн найруулах	"8.2. ... гишүүний төлөх шимтгэлийг хувь хүн, ажилтан дангаар, ..." гэснийг "... гишүүний төлөх шимтгэлийг хувь хүн дангаар, ..." гэж өөрчлөн найруулах. ХТС болон ажил олгогч нарын хооронд нэг гэрээ, ажил олгогч болон ажилтан нарын хооронд нэг гэрээ байгуулагддаг.
7.	8.3 дахь заалт	Өөрчлөн найруулах	"8.3. ... хувь хэмжээ, шимтгэл төлөх хугацааг заасан байна" гэснийг "... гишүүний төлөх шимтгэлийн дүн, хувь хэмжээ, шимтгэл төлөх хугацаа болон шимтгэл төлөлтийн тайланг хүргүүлэх тухай заасан байна" гэж өөрчлөн найруулах.
8.	8.4 дэх заалт	Өөрчлөн найруулах	"8.4. ... 50-аас доошгүй хувийг ажил олгогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө" гэснийг 50%-иас доошгүй гэж хатуу тогтоож өгөлгүй энэ хувийг ажил олгогч өөрөө тогтоох эрхийг өгөх. Саналын үндэслэл нь ажил олгогч ажилтнаа удаан хугацаанд тогтоон барих зорилгоор ажилд орсон үеэс нь шатлан өсгөх замаар нэмэлт тэтгэврийн гэрээндээ тусгаж өгөх нь зүйтэй учир өөрчлөн найруулах.

9.	8.6 дахь заалт	Нэгтгэж оруулах	8.6. Ажил олгогч нь шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, ажилтанд цахим хэлбэрээр хүргүүлнэ гэснийг 8.3 дахь заалттай нэгтгэх саналтай. Ажил олгогч нь тухайн бүтээгдэхүүний хэрэглэгч, тухайн хөтөлбөрт хамрагдах эсэх нь сонголтоор байх тул ийнхүү үүрэг хариуцлагыг нь хуульчилж өгөх нь зохимжгүй. Тус тайланг аль байгууллага хариуцан гаргах, ямар хугацаанд гаргах тухай гэрээгээр зохицуулж болно.
10.	8.8 дахь заалт	Өөрчлөн найруулах	“8.8. Гишүүн, ажил олгогчийн төлөх шимтгэлд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй” гэснийг “Гишүүн, ажил олгогчийн төлөх шимтгэлд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй ба гишүүний төлсөн шимтгэлийн дүнг татвар ноогдох орлогоос хасч тооцно” гэж өөрчлөн найруулах. Ажил олгогчийн санхүү байдал, НББ талаас хэрхэн бүртгэх, татвар, санхүүгийн үзүүлэлтүүдэд дарамт үзүүлэхгүй байхаар тусгах.
11.	9.1 дэх заалт	Өөрчлөн найруулах	“9.1. ... гишүүн бүрд ажлын гурван өдөрт багтаан нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээж, дансны мэдээллийг цахим хэлбэрээр хянах боломжтой нэвтрэх эрх олгоно” гэснийг заасныг “... гишүүн бүрд хөтөлбөрт хамрагдах гэрээ хүчин төгөлдөр болсноос ажлын гурван өдөрт багтаан нэмэлт тэтгэврийн нэрийн данс нээж, дансны мэдээллийг цахим хэлбэрээр хянах боломжтой нэвтрэх эрх олгоно” гэж өөрчлөн найруулах.
12.	9.2 дахь заалт	Өөрчлөн найруулах	“9.2. ... тэтгэврийн нэрийн дансанд өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг сар бүр, энэ хуулийн 11.4 дэх хэсэг, 39.2 дахь хэсэгт заасан зарлагыг тухай бүр бүртгэнэ” гэснийг “...тэтгэврийн нэрийн дансанд өгөөж, баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг сар бүр, энэ хуулийн 11.4 дэх хэсэг, 39.2 дахь хэсэгт заасан зарлагыг тухай бүр, бүртгэнэ” гэж өөрчлөн найруулах. Урт хугацааны хөрөнгө оруулалт байх тул богино хугацааны хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл зэргийг тооцож өгөөж бодох нь тохиромжгүй. ХТС-ийн гүйцэтгэл буюу NAV өөрчлөлтийг сар бүр бүртгэх, баталгаат өгөөж болон давсан өгөөжийг жил тутам бүртгэх нь зүйтэй.
13.	9.4 дэх заалт	Хасах	9.3. Баталгаат өгөөжийн жилийн доод хэмжээ нь Төв банк (Монголбанк)-ны бодлогын хүүгээс багагүй байна – ХАСАХ.
14.	12.2 дахь заалт	Өөрчлөн найруулах	“12.2. Хувийн тэтгэврийн санг хэд хэдэн этгээд хувь нийлүүлэн үүсгэн байгуулах бөгөөд нэг үүсгэн байгуулагчийн эзэмших хувь 20 хувиас ихгүй байна.” гэж заасан нь ХОМК өөрийн эрхийн хүрээнд хувийн ХОС, Хамтын ХОС үүсгэн байгуулахтай адил Хувийн тэтгэврийн сан үүсгэх нөхцөлд заавал 5-аас доошгүй (20%) хувь нийлүүлэгч этгээд байлгах нь сан үүсгэх шалгуур хэт өндөр болсноор Хувийн тэтгэврийн санг үүсгэх хөрөнгө оруулагч бүрдэхгүй нөхцөл үүсэх тул өөрчлөн найруулах.
15.	12.3.3 дахь заалт	Өөрчлөн найруулах	“12.2.3. ... олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулдаг байх” гэж заагдсанд СЗХ-с ХТС-н

			аудит хийхийг магадлан итгэмжилсэн аудитын байгууллагаар, сүүлийн нэг жилийн тайланг баталгаажуулсан байх зэрэг илүү тодорхой болгох агуулгыг тусгах. Мөн олон улсад нэр хүнд бүхий гэдгийг, жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулдаг байх гэдгийг тус тус тодруулах.
16.	12.4 дэх заалт	Өөрчлөн найруулах	"12.4. Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 20 тэрбум төгрөг байна. Энэхүү хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, хувийн тэтгэврийн санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдлийг харгалзан Хороо тухай бүрд нэмэгдүүлэн тогтооно" гэснийг "Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 6 тэрбум төгрөг байна. Энэхүү хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, хувийн тэтгэврийн санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг харгалзан Хороо тухай бүрд нэмэгдүүлэн тогтооно" гэж өөрчлөн найруулах. Тус хуулийн төсөлд хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хэмжээ нь 20 тэрбум төгрөг байхаар заасан байхад, СЗХ-ны 2019/12/4 өдрийн 354 дугаар тогтоол "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай"-д урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 6 тэрбум төгрөг гэж заасан байгаа нь урт хугацааны даатгагчид давуу тал олгосон, хэт нэг талыг баримталсан байна. Мөн Сан үүсгэн байгуулах дүрмийн сангийн дүн хэт өндөр бас нэг үүсгэн байгуулагч байж болохгүй гэснийг хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг багаар тогтоох, эс бөгөөс 20 тэрбумаар зөвхөн тоотой хэдхэн нэгдмэл хэлбэрийн хувийн тэтгэврийн сан үүсэж цаашид хөрөнгийн зах зээлд өрсөлдөх, олон төрлийн төрөлжсөн сангууд байх боломж, бололцоог хязгаарлаж байгаа хэрэг юм.
17.	15.1 дэх заалт	Өөрчлөн найруулах	"15.1.2. баталгаат өгөөж, эсхүл гэрээгээр тохирсон баталгаат өгөөжөөс давсан дүнг төлөөгүй" гэснийг "15.1.2. баталгаат өгөөжийг үргэлжилсэн 9 сарын хугацаанд олгоогүй, эсхүл гэрээгээр тохирсон баталгаат өгөөжөөс давсан дүнг төлөөгүй" өөрчлөн найруулах.
18.	21.8 дахь заалт	Өөрчлөн найруулах	"21.8. ... нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эсрэг нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй" гэснийг "21.8. Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч нь татан буулгах комисс, хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, тэдгээрийн холбогдох этгээд, буруутай үйл ажиллагаа явуулсан гэж үзсэн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эсрэг нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй" гэж Компанийн тухай хуулийн хувьцаа эзэмшигчийн эрх зүйн байдалтай нийцэж байгааг тодотгож өөрчлөн найруулах.
19.	27.1 дэх заалт	Өөрчлөн найруулах	"27.1. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь дараах этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хориглоно" гэснийг бүрэн хориглолгүй тодорхой тоон хязгаарлалт /банк болон

			бусад санхүүгийн байгууллагатай адилаар/ тавих саналтай байна. Саналын үндэслэл нь хувийн тэтгэврийн санг томоохон ААН, компаниуд үүсгэн байгуулсан тохиолдолд манай хөрөнгийн зах зээл дээр эдгээр компаниудын санхүүгийн хэрэгсэл харьцангуй эрсдэл багатай байхад тэтгэврийн сангийн багц бүрдүүлэлт, баталгаат өгөөжид сөргөөр нөлөөлж болзошгүй тул өөрчлөн найруулах.
20.	36.1. нэмэлт тэтгэврийн хөтөлбөр дараах тохиолдолд дуусгавар болно: [...] 36.1.3. гишүүн, эрх алгамжлагч, өвлөгч нас барсан.” гэдгийг тайлбар ирүүлж өгнө үү.		



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р
хороо, Сөүлийн гудамж, Твин тауэр-1, 1504 тоот

+976 7766-1112

2025.02.03 ААМ-25/06

Санал хүргүүлэх тухай

Хувийн Нэмэлт Тэтгэврийн Тухай хуулийн төслийн ажлын хэсгийн оролцогч байгууллагуудын саналтай танилцан, энэхүү албан бичгээр хариу хүргүүлж байна.

1. Хувийн нэмэлт тэтгэвэр, хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог хөгжүүлэхэд хөрөнгө оруулалтын менежментын компанийн (ХОМК) чадавхи тэдгээрийн оролцоо нэн чухал үүрэгтэй ба хуулийн төслийн 31.1 дэх зүйлд ХОМК-ийн үүргийн талаар тодорхой заасан байна. Энэхүү заалт нь тус хөрөнгийн удирдлагыг мэргэшсэн байгууллагаар итгэмжлэн удирдуулах шаардлагыг тусгасан бөгөөд зохицуулах байгууллагын хяналтын бүтцийг мөн тодорхой оруулж зохицуулсан байна.

Харин ажлын хэсгийн зарим гишүүн байгууллагуудаас ирсэн саналд ХОМК-ийн оролцоог урт хугацааны даатгагч болон хувийн тэтгэврийн сангийн сонголт байхаар тусгасан байгаад хуулийн төслийн 31.1 дэх “Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментын компаниар итгэмжлэн удирдуулна” заалтыг хэвээр үлдээхийг дараах үндэслэлээр санал болгож байна.

- 1.1. Урт хугацааны тогтвортой өсөлт – Нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийг мэргэжлийн байгууллагаар удирдуулах нь хөрөнгийн өгөөжийг урт хугацаанд тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн олон улсын жишгээс харахад хувийн тэтгэврийн санг ХОМК-иудаар удирдуулсанаар тэдгээрийн оролцоо болон чадавх мөн бэхжиж, хөрөнгө оруулалтын стратеги сайжирдаг байна.
- 1.2. Хараат бус, мэргэжлийн удирдлагын тогтолцоо – ХОМК нь байгууллага болон хувь хүний хөрөнгийг санхүүгийн зах зээлийн нарийн шинжилгээнд тулгуурлан удирдаж, хөрөнгө оруулалтын багцыг оновчтой хуваарилж, сангийн зорилгын дагуу мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн зах зээлийн чухал оролцогч тал юм. **Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо анх удаа бий болж буй тул хараат бус, мэргэжлийн удирдлагын тогтолцоог эхнээс нь зөв зохион байгуулах шаардлагатай.** Үүний тулд мэргэжлийн байгууллагуудын оролцоог бүрэн хангаж, тэдний үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нарийвчлан тусгахын зэрэгцээ зохицуулалтын болон хяналтын механизмыг тодорхой тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.
- 1.3. Ил тод байдал, хяналт - ХОМК-ууд нь зохицуулах байгууллагын хатуу хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг тул нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийн удирдлагыг ил тод, найдвартай байлгах боломжийг бүрдүүлнэ. Тухайлбал, Европын Холбооны улсуудын хувийн тэтгэврийн тогтолцоо нь Европын Санхүүгийн Зах Зээлийн Зохицуулах Газар (ESMA)-ын хатуу журам, ил тод байдлын стандартыг мөрдөж, хөрөнгө оруулалтын аюулгүй байдлыг хангадаг. Хувийн Тэтгэврийн Сангаас гадна Хөрөнгийн Менежментийг

хэрэгжүүлж буй компани нь зохицуулах байгууллагын хяналттай байх нь эрсдэлийг бууруулж, олон нийтийн хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

1.4. Олон улсын жишиг – Монгол Улсын хувьд олон улсын сайн туршлага дээр үндэслэн хувийн тэтгэврийн тогтолцоог хөгжүүлэх нь нэн чухал бөгөөд энэ хүрээнд хөрөнгө оруулалтын менежментийн компаниудыг заавал оролцуулж, тусгайлсан зохицуулалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

2. Монгол улсын өнөөгийн хөрөнгийн зах зээлийн багтаамжийг харгалзан үзэж нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулж болох хөрөнгийн ангилалыг гадаадын хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг үнэт цаас, гадаад улсын засгийн газраас гаргасан үнэт цаасд хөрөнгө оруулж болохоор хуулийн төслийн 26 дугаар зүйлд “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 24.1-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулна” гэж өөрчлөн найруулах саналтай байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ЗОЛЖАРГАЛ



**МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБОО**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Бага тойруу /15160/,
Сүхбаатрын талбай-9,
Утас: 70112128, Факс: (976) 70112128
E-mail: cmtu@mongol.net

**ГЭР БҮЛ ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА**

2024.12.14 № 03/484
танай 2024.11.12 -ны № 01/1211 -Т

Санал хүргүүлэх тухай

Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрт тусгагдсан олон давхаргат тэтгэврийн тогтолцоо, хуримтлалын тогтолцоог бий болгох зохицуулалтын хүрээнд “Хувийн нэмэлт тэтгэвэр”-ийн хуулийн төсөлд боловсруулсан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.Тэтгэврийн сангуудыг чадавхжуулах, түүний хөрөнгийн ашиглалт, менежментэд тавих хяналт, ил тод байдал зэргийг тодорхой зохицуулах.

2.Тэтгэврийн сангийн хөрөнгийг урт хугацаанд өсгөх найдвартай хөрөнгө оруулалтын стратегийг зөв тодорхойлох.

3.Сан, хөрөнгө оруулалтад оролцогч талуудын санхүүгийн чадавхийг үнэлэх, үнэлгээг тогтоох, үнэлгээний хязгаарыг тогтоох, үнэлгээний хязгаараас доошилсон тохиолдолд эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг тусгах.

4.Сангийн үйл ажиллагаа, ашиглалтын талаарх мэдээлэл ил тод, нээлттэй байх, хяналт тавих механизмыг олон улсын стандарт, туршлагад нийцүүлэх.

5.Урт хугацааны хуримтлал үүсгэх механизмыг боловсронгуй болгох.

6.Ирээдүйд эрсдэл үүсэхээс хамгаалах зохицуулалтыг тодорхой тусгах.

7.Хуулийн төслийн 42,1; 42,2 давхардлыг арилгах.

8.Тус хуулийн 5.1.18-ыг 2024 оны 05 дугаар сарын 16-ний өөрчлөлтөөр хүчингүй болж хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт орсноор найруулах.

9.Ажил олгогчийн нэмэгдэл тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтан нас барсан тохиолдолд өвлөгч, эрх хадгалагч байхгүй тохиолдолд мөнгөн хуримтлалын 80-аас доошгүй хувийг ажил олгогчид өвлүүлэх, үлдсэн хувийг төрд үлдээх.

10.Байгалийн гамшиг давагдашгүй хүчин зүйл, кибер халдлага дайны нөлөөллөөс үүссэн хувь гишүүн, ажил олгогчийн хохирлыг барагдуулах талаар тус хуульд тусгах.

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Х.БУЯНЖАРГАЛ



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБОО

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам -62,
Юнион Бюлдинг "В" корпус 1505-1506 тоот
Утас: 325635, 326513, 314579, 326445, 318896
Факс: (976-11) 325635

И-мэйл: monef@monef.mn, <http://www.monef.mn>

2024.11.19 № 02/204
танай 2024.11.12 -ны № 01/1211 -т

Санал хүргүүлэх тухай

“Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль”-аар ажил олгогчийн хувийн нэмэлт тэтгэвэрт төлсөн хураамж, шимтгэлийн хэмжээнд татварын хөнгөлөлт, хойшлуулалт үзүүлдэг болсноор ажиллагчдынхаа нийгмийн баталгааг хангах зорилгоор хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх боломж бүрдэж байгаа нь сайшаалтай боловч тус Холбооны гишүүн компаниудаас ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудас

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч. НАНЖИДСАМБУУ

МАОЭНХолбооны 2024 оны 11-р сарын 19
-ны өдрийн 02 тоот албан бичгийн хавсралт



НЭГ. ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ХУУЛИЙН ТӨСӨЛД:

- Энэ хуулийн төсөл нь хувь хүний болон ажил олгогчийн нэмэлт тэтгэвэртэй холбогдсон харилцааг аль алиныг нь хамарсан байна. Хоорондоо ялгаатай 2 томоохон харилцааг нэг хуулиар зохицуулах нь зарчмын хувьд учир дутагдалтай гэж үзэж байна. Иймд зөвхөн хувь хүний нэмэлт тэтгэвэртэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль гаргах санал оруулж байна. Энэ нь "Хувийн нэмэлт тэтгэврийн тухай" гэх хуулийн нэртэй тохирч байгаа санал юм. "Хувийн" гэдэг нь "Хувь хүн" (Individual or Personal) гэсэн ойлголттой холбоотой байдаг.
- Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт байгаа "Хувийн тэтгэврийн сан" гэгдэх шинэ сан байгуулах нь эрт бөгөөд эрсдэлтэй байна. Иймд зохих туршлага хуримтлуулсан урт хугацааны даатгагч буюу даатгалын компаниудад нэмэлт хөтөлбөрүүдийг хариуцуулах саналтай байна.
- Монгол Улсын Их Хурлаар батлагдсан 2023 оны 1-р сарын 1-ээс мөрдөгдөж буй Зөвшөөрлийн тухай хуулийн **8.1 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалтын** 2-т Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр ... үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд хэнд олгох талаар тодорхой дурдсан. Гэтэл хуулийн төсөлд Зөвшөөрлийн хуулийн талаар тусгаагүй бөгөөд зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн талаар заажээ.
- Төсөлд тусгагдсан "Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр" гэсэн ойлголт нь дан ажил олгогчийнх биш, харин ажил олгогч, ажилтан хамтран бий болгодог нэмэлт тэтгэврийн тухай буюу аж ахуйн нэгжийн тэтгэврийн тогтолцоог хамрахаар байна. Англи хэл дээр "Corporate pension schemes or plans" гэдэг. Энэ тогтолцоо нь тухайн компанийн бүх ажилтныг хамардаг давуу талтай. Энэхүү нэмэлт тэтгэврийн тогтолцоо нь хамтын гэрээний дагуу болон компанийн сайн засаглалын хөтөлбөрийн хүрээнд бий болж хөгжиж байгаа тогтолцоо тул хуулиар зохицуулах шаардлагагүй юм.
- Төслийн дөрөвдүгээр бүлэгт байгаа "Хөрөнгө оруулалт" хийхтэй холбогдсон харилцааг "Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах" харилцаа байдлаар өргөн хүрээнд авч үзэж, олон төрлийн аргыг тусгах. Хөрөнгө оруулалт хийх нь гол аргуудын нэг л юм.
- Төслийн аравдугаар бүлэгт дурдсан төрийн байгууллагууд, ялангуяа, Санхүүгийн зохицуулах хороо, татварын болон нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг хянаж үзэх, түүнчлэн аливаа эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх гэх мэт шинэ чиг үүрэг нэмэх. Дангаар ноёрхохоос сэргийлэх шаардлага гарвал төрийн холбогдох байгууллагыг ч нэмж

тусгах хэрэгтэй. Дагах хуулийн төсөлд ч холбогдох байгууллагын чиг үүргийг нэмэх.

- Энэхүү хуулийн төслийн дагуу Санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны Хувийн тэтгэврийн сан бий болно. Хуулийн төсөлд... хувь нийлүүлсэн хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд байршуулсан байх... гэж заажээ. Цаашид сангийн үйл ажиллагаа зөвхөн дотоодын санхүүгийн тогтолцоогоор хязгаарлагдах уу гэсэн асуудал гарч ирж байна. Иймд түүнийг эрсдэлээс хамгаалах асуудлыг тодорхой оруулж өгөх саналтай байна.
- Санг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулах шаардлагагүй бөгөөд тэтгэврийн сан, урт хугацааны даатгач нь өөрөө удирдах бүрэн боломжтой.

ХОЁР. ДАГАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД:

- Аж ахуйн нэгжийн тэтгэврийн тогтолцоо нь хамтын гэрээний дагуу болон компанийн сайн засаглалын хөтөлбөрийн хүрээнд бий болж хөгжиж байгаа тогтолцоо тул хуулиар зохицуулах шаардлагагүй. Иймд дагах хуулиудын төслүүд дотор байгаа Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хасах.
- "ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ" хуулийн төсөлд: Нийгмийн даатгалын болон хувийн нэмэлт тэтгэврийн шимтгэл төлсөн хүмүүсийн хооронд ялгаварлал үүсгэж байгаа тул дараах хэсгийг хасах:
 - "14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн дагуу төлсөн шимтгэлийг албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцох дүн ажилтны албан татвар ногдуулах үеийн үндсэн цалингийн 20 хувиас хэтрэхгүй байна."
- Хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан журмууд нь харилцан уялдаатай, салаа утгагүй байх хэрэгтэйг тэмдэглэхийг хүсэж, зарим журмуудыг хуульд оруулж өгөх саналтай байна. Тухайлбал: **Хуулийн төслийн 3.5-д** Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдох татварын харилцааг татварын хууль тогтоомжоор зохицуулна гэж заажээ. Гэтэл манай холбогдох байгууллагууд нийгмийн даатгалыг татварын нэг хэлбэр гэж ойлгож байгаа учраас түүнийг хуулийн төсөлд тодорхой заах саналтай байна. Үүнээс гадна хувийн тэтгэврийн сангийн хэмжээ нь 20 тэрбум төгрөгөөс доошгүй гэж заасан нь өрсөлдөөнийг хязгаарлаж, зөвхөн томоохон компаниудад шинэ зах зээл нээж өгч байгаа мэт ойлголтыг төрүүлж байна.



ТЭТГЭВРИЙН УУГАН САН

Чингэлтэй дүүрэг 1-р хороо,
Сүхбаатарын талбай-5, Голомт банкны төв байр
Утас: +(976)-70111646-/1679, 1728/

Э-шуудан: info@tus.mn Веб хуудас: <http://www.tus.mn>

2024.11.14 № 24/048
танай 2024.11.12 -ны № 01/1211

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ-д

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд санал хүргүүлэх нь

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тэтгэврийн Ууган Сан ТББ-аас “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль”-ийн төсөл болон дагалдах хуулиудад өгөх саналаа хавсралтаар хүргүүлж байна. Уг саналтай холбоотой дэлгэрэнгүй тодруулах зүйл гарвал бидэнтэй холбогдож лавлана уу.

Уг хуулийн төсөлд иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ өөрийн хөрөнгөөр болон шийдвэр, үйл ажиллагаандаа бүрэн хариуцлага хүлээж байгаа тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тогтвортой ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, мөн салбарын үйл ажиллагаанд оролцогчдын эрх ашгийг тодорхой хэмжээнд хангах замаар салбарын тогтвортой байдлыг хангах нь чухал байгааг онцлон дурдъя.

Хавсралт 2 хуудас.

Хамтын ажиллагаанд талархсан,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.МӨНХЖАРГАЛ



ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ-ААС ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Хуулийн төсөлд Тэтгэврийн Ууган Сан ТББ-аас өгөх ерөнхий зарчмын санал байхгүй боловч логик болон тавигдах шаардлагын хувьд дараах гол хэдэн саналтай байна.

1. **Мэдээллийн нэгдсэн сан:** Гишүүний хувийн тэтгэврийн сан болон урт хугацаат даатгагчийн хооронд шилжих хөдөлгөөнийг бүртгэх, тэдгээрт үүссэн нэрийн данснуудын хуримтлал, өгөөжийн мэдээлэл зэрэг нэгдсэн мэдээллийн систем бий болгох /зээлийн мэдээллийн сантай ижил/ үйл ажиллагааг хуульд шууд заах. Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч бүр тусдаа мэдээллийн сантай байх нь илэрхий бөгөөд эдгээр дээрх мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн нэгдсэн сан байх нь зайлшгүй шаардлагатай байна.
2. **Тэгш байдлыг хангах:** Урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх бол хувийн нэмэлт тэтгэврийн сантай ижил дүрмийн сан болон бусад шаардлагыг хангасан байх;
3. **Дүрмийн сан:** 12.4. –д 20 тэрбум гэснийг 10 тэрбум болгох.
4. **Хувийн тэтгэврийн сан, урт хугацаат даатгагч:** Өөрийн хөрөнгөөр хариуцлагаа хүлээж байгаа учраас ямар эх үүсвэрээс ашиг, орлого олох, ямар сонирхлоор тэтгэврийн санг байгуулах нь харагдахгүй байгаа тул тодорхой болгох.
5. **Эрсдэлийн сан:** Эрсдэлийг удирдах, эрсдэлийн сан бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай тул хуулинд тодорхой оруулах
6. **Баталгаат өгөөж:** 9.2 заалтыг дараах байдлаар өөрчлөх *“Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн, ажил олгогчийн төлсөн шимтгэлийг гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд баталгаат өгөөж болон түүнээс давсан өгөөжийг жил бүр, энэ хуулийн 11.4 дэх хэсэг, 37.2 дахь хэсэгт заасан зарлагыг тухай бүр бүртгэнэ. 9.4-р заалтыг Төв банкны бодлогын хүүний тухайн жилийн дундажаас багагүй байна гэж тодорхой болгох. 9.5-р заалтыг хасах саналтай.*
7. **ХОМК:** Хуулийн төслийн 31.1-д сангийн хөрөнгийг заавал ХОМК-оор удирдуулахыг заасныг ХОМК-иар удирдуулж **болно** гэж уян хатан болгох. Учир нь хувийн тэтгэврийн сан нь өөрийн хөрөнгөөр аливаа учирч болох эрсдэл, үүрэг, хариуцлагыг бүрэн дааж байгаа тул өөрсдийн сонголтоор удирдуулах эрхийг нь олгох саналтай байна.
8. **Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх:** Хуулийн төслийн 27-29-р зүйлд тусгагдсан хөрөнгө оруулалтын хориглох заалтуудыг уян хатан болгож зохистой харьцааг холбогдох журмаар зохицуулах саналтай байна. 1) Өнөөдрийн байдлаар Монголд 3 банк кастодиан үйлчилгээтэй. Иймд энэ 3 банктай холбоо бүхий хуулийн этгээдүүд ажил олгогчийн хөтөлбөрт хамрагдах боломж хязгаарлагдмал болж байна. 2) Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажил олгогчийн гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулахыг шууд хориглох нь Монгол шиг жижиг орны хувьд гайгүй хэдэн байгууллагууд хувийн тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах боломжийг хязгаарлана.
9. **Ажил олгогч:** Энэхүү хууль хэрэгжсэнээр ажил олгогч ажилтныхаа ирээдүйд санаа тавих нийгмийн хариуцлагын үүргээ биелүүлж нэмэлт зардал гаргаж байгаа боловч үнэт цаасаа тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид санал болгох эрхээрээ хязгаарлуулж байна. Ажил олгогчид өгөх давуу тал байхгүй харин ч сул тал болох гээд байгаа тул ажил олгогчийн гаргасан үнэт цаасад хөрөнгө оруулахыг хориглож болохгүй юм.
10. **Өвлөгч:** Нас барагчийн өв хөрөнгө, хөрөнгийн эрхийн тухай асуудлыг Иргэний хуулиар зохицуулдаг. Энэ хуулийн төсөлд тусгагдсан эрх залгамжлагч нь Иргэний хуулийн гэрээслэлээр өвлөх асуудалтай агуулгын хувьд ижил байна. Тиймээс



гэрээслэлтэй зэрэгцэн давхар өвийн асуудлыг эрх залгамжлал буюу хэлцлийн үндсэн дээр зохицуулах нь хожим давхцал үүсэх, маргаан, үл ойлголцол бий болох эрсдэлтэй байна. Иргэний хууль дахь гэрээслэлийн ойлголт нь тогтсон, илүү нарийн зохицуулалттай, баталгаагаар хангагдсан болно. Тиймээс энэ хуулийн төсөл дэх “эрх залгамжлал”-ын ойлголтыг хасах,

Дээрх ерөнхий саналууд дээр нэмээд дараах заалтуудыг хүснэгтэд тусгалаа.

№	Өөрчлөх заалт, санал
1	9.2.-д “сар бүр” гэснийг “жил тутамд” болгох, 43.1.1-д нэмэлт тэтгэврийн хөрөнгийн бүх гүйлгээ, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолж, тэтгэврийн нэрийн дансанд жил бүр оруулан бүртгэж, тэтгэврийн нэрийн дансны нийт үлдэгдлийг илтгэсэн тайлан; Тайлбар: Энэ хэсгийг амьдралд хэрэгжих боломжтой эсэхийг сайн нягтлаж үзнэ үү. Сар болгон тийм бүртгэл хийх нь утгагүй юм. Жилд нэг юм уу, хагас жилд нэг гэх байдлаар зохицуулах. Энэ заалтыг 43.1.1 заалттай нийцүүлэх
2	“11.4. Энэ хуулийн 11.3-т заасан эрх үүсэхээс өмнө гишүүн эрүүл мэндийн үйлчилгээний зардал, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн сургалтын төлбөр, өөрийн нэр дээр орон сууц худалдан авах нөхцөлөөр нэмэлт тэтгэврийн хөрөнгийн 30 хүртэл хувийг зарцуулах хүсэлтийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид нэг удаа гаргаж болно.” байгааг дараах байдлаар өөрчлөх “11.4. Энэ хуулийн 11.3-т заасан эрх үүсэхээс өмнө гишүүн хувийн тэтгэврийн санд 10 жилээс дээш хугацаагаар хуримтлуулсан бол нэмэлт тэтгэврийн хөрөнгийн 30 хүртэл хувийг зарцуулах хүсэлтийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид 10 жил тутамд 1 удаа гаргаж болно. 11.3-т заасан эрх үүсэхээс өмнө авсан тохиолдолд хойшлуулсан татварыг төлнө.” Тайлбар: - 10 жилээс бага хугацаанд хувийн тэтгэврийн хуримтлалтай бол хуримтлал бага хэмжээтэй байна. Энэ тохиолдолд 30 хувь нь маш бага мөнгө болж таарна. - Мөн нэгэнт л 30 хувиа авах эрх олгож байгаа бол өвчтэй, байр авах гэж байгаа гэж иргэн хүний хувийн асуудалд хөтөлбөр хэрэгжүүлэгч оролцох нь утгагүй юм. Үүнээс болж хүмүүс хуурамч бичиг баримт бүрдүүлэх, ялгавартай байдал үүсэх асуудалтай юм. Тиймээс нөхцөл, шалтгаан заах шаардлагагүй байна. - Нэг удаа 30 хувийг авах биш 10 жил тутамд нэг удаа авах боломж өгөх нь хувийн тэтгэврийг дэмжих, гишүүн амьдралаа сайжруулах боломж олгоно.
6	- 38.5. Энэ хуулийн 38.4-т заасан тохиолдолд гишүүн эрх залгамжлагчийг нэрлээгүй, хууль ёсны өвлөгч байхгүй бол хувийн тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Тайлбар: - Энэ хууль ёсны өвлөгчийг байхгүй гэдгийг хэрхэн тогтоох вэ? Яагаад төрийн өмчид шилжүүлэх ёстой вэ? Төрийн өмчид шилжүүлэх бол ямар хугацааны дараа шилжүүлэхийг тодорхой заах.
7	6.6 заалтыг хасах саналтай, сайн дурын гэдэг зарчимтай зөрчилдөж байна.
8	11.3 заалт дахь “...өвлөгч энэ хуулийн 13.1-д заасан...” гэснийг “11.3-д” гэж засах
9	Шимтгэл төлөх: 8.4-р заалтыг найруулгыг сайжруулах
10	12.1-найруулгыг сайжруулах:
11	12.3.3 заалт дахь “...олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагаар ...” гэж заасныг “монгол улсын эрэмбээр эхний 10-т жагсдаг” гэх байдлаар өөрчлөх.



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж, Твин тауэр-1, 1504 тоот

+976 7766-1112

МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

2024/11/15 ААМ - 24/105
2024/11/12 01/1211

Хариу хүргүүлэх тухай

Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын 2024 оны 11-р сарын 12-ны өдрийн 01/1211 тоот албан бичигтэй холбогдуулан энэхүү албан тоотыг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүний хувьд бид та бүхний ирүүлсэн хуулийн төсөлтэй танилцаж холбогдох санал хүсэлтийг хүргүүлэхээр ажиллаж байна.

Энэхүү хуулийн төсөлд хөрөнгийн зах зээл, ялангуяа тус хуулийн төслийн гол оролцогч тал болох хөрөнгө оруулалтын менежментийн компанийн байр суурийг илүү тодорхой тусгах шаардлагатай гэж үзэж байна. Мөн бидний зүгээс Хувийн тэтгэврийн сантай холбоотой хийгдсэн судалгаа, тус чиглэлээр авч байсан зөвлөх үйлчилгээний дүгнэлт, зөвлөмжтэй танилцах хүсэлтэй байна. Манай байгууллага энэ чиглэлээр илүү нарийвчлан судалж, холбогдох саналыг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор та бүхэнд хүргүүлэхээр ажиллаж байна.

Иймд хуулийн төсөл, холбогдох судалгаа, шинжилгээний баримтуудтай бүрэн танилцаж, бидэнд саналыг боловсруулахад шаардлагатай хугацаагаар хангаж, хамтран ажиллахыг хүсье.



Г.ЗОЛЖАРГАЛ

Г.ЗОЛЖАРГАЛ

2024.11.20 № 24/03/728
танай 2024.11.12 -ны № 01/12.11 -т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1/ Урт хугацааны даатгалын компанийн хувьд хөрөнгө оруулах үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулахаар зохицуулсан хуулийн төслийн 33-36-р зүйлийн заалтуудыг дэмжихгүй байна.

Тодруулбал, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.19-д "Мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч" гэж мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаадаатгал, андеррайтер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэж үзсэн бусад этгээдийг" ойлгоно гэж заасны дагуу урт хугацааны даатгалын компанийг хөрөнгө оруулах үйл ажиллагааг бие даан явуулах боломжтой хуулийн этгээд гэж үздэг. Олон улсын туршлагыг судлахад 2003 онд гаргасан судалгаагаар Европын 7 улсын нийт тэтгэврийн сангийн хөрөнгийн 42.3 хувийг даатгалын компани удирдаж байсан, 2007 онд Израйлын урт хугацааны даатгалын компаниуд нийт хувийн тэтгэврийн сангийн 67 хувийг удирдаж байсан, 2010 онд АНУ-н урт хугацааны даатгалын компаниуд нийт 2.3 триллион долларын тэтгэврийн хөрөнгийг удирдаж байгаа нь нийт хувийн тэтгэврийн хөрөнгийн 45 хувийг эзэлж байсан байна.

Иймд хуулийн төслийн 33, 34, 35, 36-р зүйлийн холбогдох заалтуудаас “урт хугацааны даатгагч” гэснийг хасах саналтай байна.

2/ Даатгалын тухай хуулийн 6¹-р зүйлийн 6^{1.1}-д “Даатгагч нь энэ хуулийн 4.1.1-д зааснаас гадна холбогдох этгээдээс бусад этгээдэд даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно.”, мөн зүйлийн 2 дах хэсэгт “ баталгаа, батлан даалтын үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэж тус тус заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.3, 42.3.1 дэх заалтуудад Монгол Улсын даатгагч тендерийн баталгаа гаргаж болохоор заасан.

Иймд хуулийн төслийн 26.3 заалтад “зээл, барьцаа, батлан даалт гаргахыг хориглох”-оор заасан нь дээрх хуулийн заалтуудтай нийцэхгүй байгаа тул СЗХ-ноос тогтоосон журмуудтай уялдуулж өөрчлөх саналтай байна.

3. Даатгагч нь даатгалын хууль тогтоомжийн дагуу тогтоосон даатгалын хэлбэр бүрээр, тодруулбал тэтгэврийн хуримтлалын даатгал зах зээлд нийлүүлэхэд зөвшөөрөл авдаг тул хуулийн төслийн 17.1 заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай.

“17.1.Тэтгэврийн даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхэлнэ.”

4. Хуулийн төслийн 4.2 заалтын агуулга “нийгмийн даатгалын санд шимтгэл төлж, даатгуулсан иргэн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж болох”-оор заасан нь сайн дураар даатгуулах зарчимтай нийцэхгүй, зах зээлийн боломжийг хязгаарлахаар байгаа тул хасах саналтай байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.МОНГОЛХҮҮ

7376

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.12.24 № 01/10627

танай _____-ны № _____-т

Хариу өгөх тухай

Таны хамтран батлахаар ирүүлсэн “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал” нь Монгол Улсын Засгийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх зорилттой нийцэж байх тул зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн үзэл баримтлалын 1.2 дахь хэсэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр тооцох орлогын дээд хязгаараас давсан өндөр орлоготой даатгуулагчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 30.2 мянга байна. Мөн ажил олгогчоос шимтгэл төлөхөөр тооцох цалин хөлсний дээд хязгаар тогтоох талаар тусгажээ.

Ажил олгогчоос шимтгэл төлөхөөр тооцох цалин хөлсний дээд хязгаар тогтоосноор нийгмийн даатгалын сан тэр дундаа тэтгэврийн даатгалын сангийн орлого хэдий хэмжээгээр буурах, уг эх үүсвэрийг хэрхэн нөхөх талаар хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд боловсруулах хууль тогтоомжид тусгах талаар агуулга нэмэх;

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, үйл ажиллагааны онцлогтой холбогдсон бусад харилцааг тус тусын хуулиар зохицуулна.” гэж заасан.

Хуулийн төслийн үзэл баримтлалын хоёр дахь хэсэгт хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиантай холбоотой нийтлэг харилцааг хуулийн төсөлд тусгахаар заасан байгааг хасах; ✓

3. Хуулийн төслийн үзэл баримтлалын 1.2 дахь хэсэгт хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд санхүүгийн хөшүүрэг буюу татварын дэмжлэг, хөнгөлөлт чөлөөлөлт шаардлагатай талаар, дөрөв дэх хэсэгт Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын

9762004639

11A

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна гэж тус тус заасан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд татварын хууль тогтоомжуудад ямар өөрчлөлт оруулах, хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд ямар хэлбэрээр татварын дэмжлэг, хөнгөлөлт, чөлөөлөлт бий болгох талаар тодорхой тусгах зэрэг саналыг хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж, Твин тауэр-1, 1504 тоот

+976 7766-1112

МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

2024/11/25 ААМ-24/106

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын 2024 оны 11-р сарын 12-ны өдрийн 01/1211 тоот албан бичиг болон тус компанийн 2024 оны 11-р сарны 15-ны өдрийн ААМ-24/105 тоот албан бичигтэй холбогдуулан энэхүү албан тоотыг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүний хувьд та бүхний ирүүлсэн хуулийн төсөлтэй танилцаж холбогдох санал хүсэлтийг Хавсралт 1-р хүргүүлж байна.

Мөн Хувийн тэтгэврийн сан болон Урт хугацааны даатгагчийн хөрөнгийг Хөрөнгө оруулалтын менежментын компаниар удирдуулах үндэслэл болон ач холбогдлыг салбарын төлөөллийн хувиар Хавсралт 2-р хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 10 хуудас.



Г.ЗОЛЖАРГАЛ

Хавсралт 1.

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ БА САЙЖРУУЛАХ САНАЛ

1. ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САНД ТАВИГДАХ ШААРДЛАГА (12-Р ЗҮЙЛ)

Одоогийн хуулийн төсөл:

- Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 20 тэрбум төгрөгөөр тогтоосон (12.4).
- Санхүүгийн тайлан, аудитын шаардлага тусгасан боловч хөрөнгийн удирдлагын туршлага, хөрөнгийн хэмжээний үндэслэлийг нарийвчлаагүй.

Сайжруулах санал 1.1:

- Хувийн тэтгэврийн сангийн үүсгэн байгуулагчдын нэг нь заавал Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК) байх шаардлагыг хуулийн төсөлд тусгах.

Үндэслэл:

- ХОМК нь хөрөнгө удирдах мэргэжлийн туршлага, стратегийг баталгаажуулж, гишүүдийн хөрөнгийн эрсдэлийг бууруулна.
- ХОМК-ийг үүсгэн байгуулагчид оролцуулах нь сангийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах баталгааг хангана.

Сайжруулах санал 1.2:

- Хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 тэрбум төгрөгийн хөрөнгийн хэмжээг тогтоосон үндэслэлийг тодорхой болгох:
- Хөрөнгийн хэмжээг урт хугацааны даатгагчдын шаардлагатай дүйцүүлэх:

Үндэслэл:

- Сангийн болон урт хугацааны даатгалын бүтээгдэхүүнүүд нь ижил төстэй эрсдэлийн удирдлагын хүрээнд ажилладаг тул тэдгээрт ижил түвшний хөрөнгийн шаардлага тавих нь шударга өрсөлдөөнийг хангана.
- 6 тэрбум төгрөгийн суурь хөрөнгө нь жижиг, дунд байгууллагуудад зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах зарчимд үндэслэн тогтоох:
 - (1) Сангийн хөрөнгө удирдах өгөөжийг хангахын тулд суурь хөрөнгийн хэмжээ хангалттай бай.
 - (2) Монголын зах зээлийн хэмжээ, эрсдэлийг харгалзан дотоодын хөрөнгийн удирдлагад шаардлагатай санхүүгийн тогтвортой байдлыг хангах.
 - (3) Сангийн өгөөжийг баталгаажуулах суурь эх үүсвэрийг бүрдүүлэх.

Ач холбогдол:

- Мэргэжлийн түвшний хөрөнгө удирдлага: ХОМК-ийн оролцоо нь хөрөнгө оруулалтын чанарыг нэмэгдүүлнэ.
- Шударга өрсөлдөөн: Хөрөнгийн шаардлагыг урт хугацааны даатгагчдын хэмжээнд дүйцүүлэх нь зах зээлийн тэнцвэрийг хадгална.

- Итгэлцэл нэмэгдэнэ: Сангийн хөрөнгийн суурийг сайжруулж, иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ.

Санал болгож буй хувилбар:

12.4. Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулагчдын нэг нь заавал хөрөнгө оруулалтын менежментын компани байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 6 тэрбум төгрөгөөс багагүй байна.”

Жич: Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх журам батлах эрхийг хуулиар олгож болно.

2. АЖИЛ ОЛГОГЧ-АЖИЛТНЫ ХАМТАРСАН ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХУУЛЬД ТУСГАХ САНАЛ

Одоогийн зохицуулалт:

- Хуулийн төсөлд ажил олгогчийн хувьд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг сонгох эрхийг ерөнхий байдлаар тусгасан боловч ажил олгогч-ажилтны хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой зохицуулалт дутмаг байна (10-р зүйл).

Хязгаарлалт:

- Ажил олгогчийн эрх, үүргийн нарийвчлал дутмаг бөгөөд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд тодорхой удирдамж байхгүй.
- Уян хатан байдал хязгаарлагдмал буюу хөтөлбөрийн нөхцөл, шимтгэлийн харьцааг тохиролцох эрхийн талаар тодорхой заалт байхгүй.
- Хэрэгжүүлэх сонголт хязгаарлагдмал буюу ажил олгогч өөрт тохирсон төрлийн хөтөлбөр сонгох боломж хангалтгүй.

Сайжруулах санал 2.1: Ажил олгогч-ажилтны хамтарсан хөтөлбөрийг тусгай бүлэгт тусгах

- “Ажил олгогч-ажилтны хамтарсан хувийн тэтгэврийн хөтөлбөр” гэж ажил олгогч, ажилтан хоёрын харилцан тохиролцсон шимтгэлийн төлбөрөөр хэрэгжих, ирээдүйд ажилтанд тэтгэвэр хэлбэрээр буцаан олгогдох хөтөлбөрийг ойлгоно.”

Үндэслэл: Энэ нь ажил олгогчид сонголттой байх эрх олгохын зэрэгцээ ажилтны санхүүгийн баталгааг нэмэгдүүлнэ.

Сайжруулах санал 2.2: Ажил олгогчийн эрх, үүргийг уян хатан байдлаар зохицуулах

- “Ажил олгогч нь ажилтны хамт тохиролцон, хувийн тэтгэврийн хөтөлбөрт шимтгэлийн хувь хэмжээг тохируулах эрхтэй. Шимтгэлийн хувь хэмжээ хамгийн багадаа 1%, хамгийн ихдээ 10% байж болно.”

Үндэслэл: Уян хатан зохицуулалт нь ажил олгогчийн санхүүгийн чадварт нийцэхээс гадна ажилтны оролцоог нэмэгдүүлнэ.

Санал болгож буй хувилбар:

10-р зүйлд дараах нэмэлтийг оруулна:

- “Ажил олгогч-ажилтны хамтарсан тэтгэврийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сонголтыг ажил олгогчид олгоно. Хөтөлбөрийн шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хуульд заасан хэмжээнд багтаана.”
- “Ажил олгогч, ажилтны шимтгэлийн хувь хэмжээний харьцаа, урамшууллын механизмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмаар тодорхойлно.”

3. ӨГӨӨЖ БҮРТГЭХ ДАВТАМЖИЙН ТУХАЙ

Одоогийн зохицуулалт:

- Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь гишүүн, ажил олгогчийн төлсөн шимтгэлийг гишүүний нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд өгөөж болон баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг сар бүр бүртгэхийг шаардсан (9.2).
- Үүнтэй холбоотой заалтууд нь 11.4 болон 39.2-д тусгагдсан.

Хязгаарлалт:

- Сар бүр өгөөж тооцох нь тохиромжгүй: Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө нь урт хугацааны хөрөнгө оруулалт тул богино хугацааны ХЗЗ (Хөрөнгийн зах зээлийн) хэлбэлзэл өгөөжийг бодитой илэрхийлэхгүй.
- NAV (Net Asset Value)-ийн гүйцэтгэлийг бүртгэх шаардлага дутмаг: Гишүүдийн хөрөнгийн бодит өсөлт, сангийн гүйцэтгэлд суурилсан ил тод байдал дутмаг.

Сайжруулах санал 3.1: Сар бүр NAV-ийн гүйцэтгэлийг бүртгэх:

- Хуулийн 9.2-д дараах өөрчлөлтийг оруулах: “Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийн гүйцэтгэлийг сар бүрийн үндсэн дээр, NAV (цэвэр хөрөнгийн үнэ цэнэ)-ийн өөрчлөлтөд тулгуурлан бүртгэнэ.”

Үндэслэл: NAV-ийн бүртгэл нь хөрөнгө оруулалтын бодит үнэлгээ болон сангийн гүйцэтгэлийг ил тод харуулна

Сайжруулах санал 3.2: Баталгаат болон давсан өгөөжийг жил тутам бүртгэх

- Хуулийн 9.2-д дараах нэмэлт өөрчлөлт оруулах: “Баталгаат өгөөж болон баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг жил тутамд нэг удаа тооцож, нэрийн дансанд тусгайлан бүртгэнэ.”

Үндэслэл: Жил тутмын өгөөж тооцох нь урт хугацааны хөрөнгө оруулалтын онцлогт нийцэж, богино хугацааны хэлбэлзлийн нөлөөг багасгана.

Сайжруулах санал 3.3:

- Сангийн гүйцэтгэлийг жил бүр гишүүдэд тайлагнаж, NAV-ийн өөрчлөлт, баталгаат өгөөж, нэмэлт өгөөжийн талаар тодорхой мэдээлэл өгөх зохицуулалт тусгах.

Үндэслэл: Гишүүдийн хөрөнгө оруулалтын талаар илүү ойлголттой байх боломжийг хангана.

Санал болгож буй хувилбар:

9.2-д дараах нэмэлт өөрчлөлтийг тусгана:

- “Хувийн тэтгэврийн сангийн NAV-ийн өөрчлөлтийг сар бүрийн үндсэн дээр бүртгэж, баталгаат өгөөж болон баталгаат өгөөжөөс давсан өгөөжийг жил тутамд нэг удаа тооцож бүртгэнэ.”
- “Эдгээр өгөөжийг гишүүдэд тайлагнах журам болон бүртгэлийн нарийвчилсан дүрмийг Санхүүгийн зохицуулах хороо батална.”

4. БАТАЛГААТ ӨГӨӨЖИЙГ МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮГЭЭС ДООШГҮЙ БАЙНА ГЭЖ ЗААСНЫ ТОХИРОМЖТОЙ БАЙДАЛ БА САЙЖРУУЛАХ САНАЛ

Одоогийн зохицуулалт:

- Хуулийн төсөлд баталгаат өгөөжийг Монголбанкны бодлогын хүүгээс доошгүй байхаар заасан. Энэ нь сар бүр эсвэл жил бүрийн хүүгийн хэлбэлзэлтэй уялдах байдлаар өгөөж тооцох боломжийг бий болгодог.

Хязгаарлалт:

- Богино хугацааны хэлбэлзэл нөлөөлөх эрсдэлтэй: Монголбанкны бодлогын хүү нь ихэвчлэн богино хугацааны санхүүгийн бодлогод уялддаг бөгөөд энэ нь урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжгүй байж магадгүй.
- Урт хугацааны дундаж өгөөжийг харуулахгүй: Урт хугацааны хөрөнгө оруулалтад хүүгийн богино хугацааны хэлбэлзлийг ашиглах нь сангийн гүйцэтгэлийг бодитой үнэлэх боломжийг хязгаарлана.

Сайжруулах санал 4.1: 5 жилийн дундаж хүүг ашиглах

- Баталгаат өгөөжийг тооцохдоо Монголбанкны бодлогын хүүгийн 5 жилийн дундажийг ашиглах заалтыг тусгах.

Үндэслэл:

- Урт хугацааны хөрөнгө оруулалтад тогтвортой хүүгийн түвшин ашиглах нь хөрөнгө удирдлагад илүү тохиромжтой.
- 5 жилийн дундаж хүү нь богино хугацааны хэлбэлзлийн нөлөөг багасгаж, урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

Сайжруулах санал 4.2: Уян хатан байдлыг нэмэгдүүлэх

- Сангийн хөрөнгө оруулалтын бүтэц, хүлээгдэж буй өгөөжид суурилсан баталгаат өгөөжийг тооцох уян хатан зохицуулалтыг хуульд тусгах.

Үндэслэл: Хөрөнгийн ангилал, хөрөнгө оруулалтын төрөл, эрсдэлээс хамааруулан баталгаат өгөөжийг илүү бодитой тооцох боломжийг хангана.

Сайжруулах санал 4.3: Баталгаат өгөөжийн үнэлгээг жил тутам хийх

- Жил бүр баталгаат өгөөжийг хянан үнэлж, шаардлагатай бол Монголбанкны бодлогын хүүгийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх журам батлах.

Үндэслэл: Сангийн гүйцэтгэл болон зах зээлийн нөхцөлд уялдуулан өгөөжийн бодлого уян хатан байх боломжтой болно.

Санал болгож буй хувилбар:

Хуулийн 9.4-д дараах нэмэлт өөрчлөлт оруулна:

- “Баталгаат өгөөж нь Монголбанкны бодлогын хүүгийн 5 жилийн дундажаас багагүй байхаар тооцогдоно.”
- “Баталгаат өгөөжийн үнэлгээг жил бүрийн эцэст Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хянан шинэчилнэ.”

Хавсралт 2.

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН БОЛОН ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТЫН КОМПАНИ (ХОМК)-ААР УДИРДУУЛАХ ҮНДЭСЛЭЛҮҮД

1. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах

1.1. Системийн эрсдэлийг бууруулах

Урт хугацааны даатгагчийн болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг мэргэжлийн Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК)-аар удирдуулах нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах нэг гол арга зам юм. Даатгалын болон тэтгэврийн сангууд зах зээлд томоохон жинтэй хөрөнгө оруулагчид тул эдгээр сангийн буруу удирдлага нь нийт санхүүгийн системд хямрал үүсгэх эрсдэлийг дагуулдаг. Мэргэжлийн ХОМК-уудын оролцоотойгоор хөрөнгийг төрөлжүүлж, хөрөнгө оруулалтын шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргаж, зах зээлийн хэт савлагааг бууруулах боломжтой.

Олон улсын туршлага:

Европын Холбооны Солвенси II зохицуулалт нь даатгалын хөрөнгийг мэргэжлийн байгууллагуудаар удирдуулахыг шаарддаг. Энэ нь системийн эрсдэлийг багасгаж, хөрөнгө оруулалтын тогтвортой байдалд хүрэхэд онцгой үүрэгтэй. Жишээлбэл, Грек улсын өрийн хямралын үеэр даатгалын сангуудын мэргэжлийн удирдлагатай байдал нь зах зээлийн тогтвортой байдлыг тодорхой хэмжээнд хамгаалж чадсан.

Монгол Улсын хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын “Даатгалын тухай хууль”-ийн 35.2-д хөрөнгийн удирдлагад тавигдах шаардлагыг тодорхойлсон боловч мэргэжлийн ХОМК-уудын оролцоог хангах заалт дутмаг байна. Энэ заалтыг тодорхой болгох нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн чухал алхам юм.

Эдийн засгийн ач холбогдол:

Монгол Улсын даатгалын зах зээл харьцангуй жижиг боловч өргөжин тэлэхийн хэрээр хөрөнгө оруулалтын удирдлага нь системийн эрсдэлийг багасгаж, зах зээлийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах зайлшгүй хэрэгцээтэй болно. Даатгалын болон тэтгэврийн хөрөнгийг ХОМК-уудаар удирдуулах нь хөрөнгө оруулалтын төрөлжилтөд хувь нэмэр оруулж, зах зээлийн хэт төвлөрлийг багасгадаг.

1.2. Төвлөрсөн хяналтыг сайжруулах

ХОМК-ууд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа дотоод аудит болон хөндлөнгийн хяналтын механизмыг ашигладаг. Энэ нь хөрөнгийн удирдлагын ил тод байдлыг хангаж, зохицуулагч байгууллагуудад бодит цагийн мэдээлэл өгөх замаар эрсдэлийг удирдах боломжийг бүрдүүлнэ.

Олон улсын туршлага:

Их Британи, Хонконг зэрэг орнуудад ХОМК-уудын оролцоотой төвлөрсөн хяналтын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд хөрөнгийн удирдлагын ил тод байдлыг нэмэгдүүлж, хяналтын зардлыг бууруулсан. Их Британийн Санхүүгийн Зан Үйлийн Газар (FCA) болон Хонконгийн Үнэт цаас, фьючерсийн хяналтын газар (SFC) нь энэ жишгийг дэлхийн түвшний шилдэг туршлага гэж үздэг.

2. Засаглал, хариуцлага, зохицуулалтын нийцлийг хангах

2.1. Засаглал, үйл ажиллагааны бие даасан байдал

Урт хугацааны даатгагчийн болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгө оруулалтын удирдлагыг Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК)-аар гүйцэтгүүлэх нь хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаанаас тусгаарлах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Энэ нь хөрөнгө оруулалтын шийдвэрийг хараат бус, мэргэжлийн түвшинд гаргах боломжийг бүрдүүлнэ.

Олон улсын туршлага:

Австралийн тэтгэврийн тогтолцоонд хөрөнгийн удирдлагыг мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэснээр сангийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ил тод, үр ашигтай засаглалыг нэвтрүүлсэн. Энэ нь тэтгэврийн сангийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад томоохон түлхэц болсон.

2.2. Хараат бус хяналт, тайлагнал

ХОМК-уудын оролцоо нь хөрөнгийн удирдлагын ил тод байдлыг хангаж, ёс зүйтэй байдал, хариуцлагыг нэмэгдүүлнэ. Тэд зохицуулагч байгууллагуудын хяналтад байж, хөрөнгийн тайлан, багцын удирдлагын мэдээллийг тогтмол хүргэх үүрэг хүлээдэг. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулах чухал хэрэгсэл болдог.

Олон улсын туршлага:

Европын Холбооны “UCITS” болон “AIFMD” зохицуулалтууд нь хөрөнгийн удирдлагад хараат бус аудит, нарийн тайлагналын системийг нэвтрүүлсэн. Энэ нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, хөрөнгийн удирдлагын үйл явцыг ил тод болгодог.

Ач холбогдол:

- Засаглалын ил тод байдал, хараат бус байдлыг хангаж, сангуудын хөрөнгийг үр ашигтай удирдах нөхцөл бүрдэнэ.
- Зохицуулагч байгууллагууд хяналт тавих, хууль эрх зүйн нийцлийг баталгаажуулах, хөрөнгийн менежментийн эрсдэлийг бууруулах боломжтой болно.
- Ил тод байдал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулна.

3. Даатгуулагч болон тэтгэвэр авагчдын эрх ашгийг хамгаалах

3.1. Эрсдэл ба өгөөжийн оновчлол

Урт хугацааны даатгагчийн болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг мэргэжлийн Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК)-аар удирдуулах нь хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрсдэлийг бууруулахад онцгой ач холбогдолтой. Мэргэжлийн байгууллагууд хөрөнгийн багцыг төрөлжүүлэх, нарийн үнэлгээ хийх, стратегийг урт хугацаанд оновчтой хэрэгжүүлэхэд чиглэсэн арга зүйтэй тул хөрөнгө оруулалтын шийдвэр илүү үр дүнтэй байдаг.

Олон улсын туршлага:

АНУ-ын “ERISA Act” (Employee Retirement Income Security Act) хуульд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа тэтгэвэр авагчдын өгөөж, эрсдэлийг оновчтой удирдах үүрэг хүлээсэн байхыг шаарддаг. Энэ хуулийн хэрэгжилт нь тэтгэврийн сангуудын санхүүгийн тогтвортой байдлыг

хангах үндсэн суурь болж өгдөг. Австралийн тэтгэврийн тогтолцоонд ХОМК-ууд хөрөнгийн багцыг удирдаж, 10 гаруй жилийн хугацаанд хөрөнгө оруулалтын дундаж өгөөжийг 7-8%-д хүргэсэн нь тэтгэврийн сангийн өгөөжийг тогтвортой байлгасан жишээ юм.

Ач холбогдол:

- Эрсдэлийг бууруулж, өгөөжийг оновчтой удирдах нь даатгуулагч болон тэтгэвэр авагчдын санхүүгийн эрх ашгийг хамгаалах хамгийн чухал хүчин зүйл болно.
- Мэргэжлийн ХОМК-уудын оролцоо нь хөрөнгийн тогтвортой өгөөжийг хангаж, сангуудын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулна.

3.2. Итгэлцлийг нэмэгдүүлэх

Хөрөнгийн удирдлагыг мэргэжлийн ХОМК-аар удирдуулах нь ил тод байдал, найдвартай байдлыг хангаж, даатгуулагч болон тэтгэвэр авагчдын итгэлийг нэмэгдүүлнэ. ХОМК-ууд хөрөнгө оруулалтын тайлан, багцын удирдлагын талаарх мэдээллийг тогтмол ил тод байдлаар хүргэдэг тул хөрөнгө оруулагчид хөрөнгийн ашиглалт, үр дүнг ойлгож, хянах боломжтой.

Олон улсын туршлага:

Их Британид мэргэжлийн ХОМК-уудын үйл ажиллагааны тайланг даатгуулагчдад ил тод хүргэх шаардлагыг Financial Conduct Authority нь заавал мөрдүүлдэг. Энэ нь санхүүгийн зах зээлд иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.

Ач холбогдол:

- Итгэлцлийг нэмэгдүүлэх нь иргэдийн даатгал, тэтгэврийн системд оролцох сонирхлыг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд хувь нэмэр оруулна.
- Ил тод байдал, хариуцлагатай менежмент нь иргэдийн санхүүгийн аюулгүй байдлыг баталгаажуулж, ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.

4. Эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх

4.1. Эрсдэлийн мэргэшсэн үнэлгээ

Урт хугацааны даатгагчийн болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг мэргэжлийн Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК)-аар удирдуулах нь санхүүгийн эрсдэлийг нарийвчлан үнэлэх, удирдах үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой. ХОМК-ууд хөрөнгө оруулалтын эрсдэлийг төрөлжүүлж, тохирсон арга зүйгээр үнэлэх мэргэжлийн ур чадвартай байдаг.

Олон улсын туршлага:

Канад болон Швейцарьт хувийн тэтгэврийн сангууд хөрөнгийн багцын эрсдэлийг бууруулахын тулд мэргэжлийн хөрөнгийн менежментийн компаниудтай хамтран ажилладаг. Жишээлбэл, Канадын CPP Investment Board нь сангийн эрсдэлийг оновчтой удирдаж, дунд болон урт хугацааны тогтвортой өгөөжийг баталгаажуулдаг.

Ач холбогдол:

- Эрсдэл бууруулах мэргэжлийн үнэлгээ нь хөрөнгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангана.
- Даатгуулагч болон тэтгэвэр авагчдын хөрөнгийг хэт савлагаанаас хамгаалж, ирээдүйн өгөөжийг тогтвортой байлгах боломж бүрдэнэ.

4.2. Урт хугацааны тогтвортой байдал

ХОМК-ууд урт хугацааны хөрөнгө оруулалтын стратеги боловсруулж, хэрэгжүүлэх туршлагатай тул даатгалын болон тэтгэврийн сангуудын хөрөнгийн тогтвортой байдалд шууд нөлөө үзүүлнэ. Тэд эрсдэлийг оновчтой удирдаж, өгөөжийг нэмэгдүүлэх урт хугацааны шийдлүүдийг санал болгодог.

Олон улсын туршлага:

Австралийн Superannuation тэтгэврийн тогтолцоонд хөрөнгийг мэргэжлийн ХОМК-ууд удирдаж, 10 гаруй жилийн хугацаанд дундаж өгөөжийг 7-8%-д хүргэсэн нь урт хугацааны тогтвортой байдлыг хангах чухал жишээ юм.

Ач холбогдол:

- Урт хугацааны стратегийн хэрэгжилт нь даатгалын болон тэтгэврийн сангуудын санхүүгийн эрүүл байдлыг хадгална.
- Сангуудын хөрөнгө оруулалтаас гарах өгөөжийг тогтвортой байлгаж, даатгуулагчдын итгэлийг нэмэгдүүлнэ.

5. Санхүүгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах

5.1. Хөрөнгийн менежментийн салбарын хөгжил

Урт хугацааны даатгагчийн болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг мэргэжлийн Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК)-аар удирдуулах нь Монгол Улсын хөрөнгийн менежментийн салбарыг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, олон улсын хөрөнгө оруулалтыг татах гол хүчин зүйл болно. Мэргэжлийн ХОМК-ууд зах зээлд шинэ бүтээгдэхүүн, инноваци нэвтрүүлснээр санхүүгийн салбарын өргөжилтөд хувь нэмэр оруулна.

Олон улсын туршлага:

Сингапурын хөрөнгийн менежментийн салбар нь хувийн тэтгэврийн сан болон даатгалын хөрөнгийг мэргэжлийн ХОМК-уудаар удирдуулж, олон улсын хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх тогтолцоог бий болгосон. Энэ жишээ нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах бодит туршлага болж чадна.

Ач холбогдол:

- Хөрөнгийн менежментийн салбарын хөгжил нь зах зээлийн өргөжилт, санхүүгийн олон бүтээгдэхүүн бий болгох үндэс болно.
- Мэргэжлийн байгууллагуудын оролцоо нь хөрөнгийн удирдлагад итгэх итгэлийг нэмэгдүүлж, олон улсын хөрөнгө оруулагчдыг татах боломжийг нээж өгнө.

5.2. Шинэ бүтээгдэхүүн, инноваци

ХОМК-уудын хөрөнгийн удирдлагын туршлага нь санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, инноваци нэвтрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна. Жишээлбэл, олон улсын түвшинд хөрөнгө оруулалтын төрөлжилтийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй санхүүжилт (ESG) зэрэг шинэ чиг хандлагыг зах зээлд нэвтрүүлдэг.

Олон улсын туршлага:

Европын орнууд ХОМК-уудын тусламжтайгаар “Ногоон санхүүжилт”-ийн бүтээгдэхүүн хөгжүүлж, эдгээр нь хөрөнгө оруулалтын шинэ чиг хандлагыг тогтоож байна. Сингапурын хөрөнгийн менежментийн салбар байгальд ээлтэй санхүүжилтээр зах зээлээ амжилттай өргөжүүлж чадсан.

Ач холбогдол:

- Шинэ бүтээгдэхүүн, инноваци нь хөрөнгийн зах зээлд шинэ боломжуудыг бий болгож, хөрөнгө оруулагчдад төрөлжсөн сонголт санал болгоно.
- Хөрөнгийн удирдлагын үйлчилгээний өрсөлдөөнийг нэмэгдүүлж, зах зээлийн үр ашгийг сайжруулна.

6. Зах зээлийн эрүүл өрсөлдөөнийг дэмжих**6.1. Шударга өрсөлдөөн**

Урт хугацааны даатгагчийн болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг мэргэжлийн Хөрөнгө оруулалтын менежментын компани (ХОМК)-аар удирдуулах нь хөрөнгийн удирдлагын чанартай, үр ашигтай үйлчилгээг хөгжүүлж, зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгоно. ХОМК-уудын оролцоо нь хөрөнгө удирдлагын үйл явцад мэргэжлийн түвшний стандартыг нэвтрүүлж, үйлчилгээний чанарыг тогтвортой байлгахад чиглэнэ.

Олон улсын туршлага:

Их Британи болон АНУ-ын хөрөнгийн зах зээлд ХОМК-уудын оролцоотойгоор хөрөнгийн удирдлагын салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдад чанартай, төрөлжсөн сонголт санал болгох боломжийг бүрдүүлсэн. Энэ жишиг нь даатгалын болон тэтгэврийн сангуудын хөрөнгийг үр ашигтай удирдахад хувь нэмэр оруулдаг.

Ач холбогдол:

- Шударга өрсөлдөөн нь хөрөнгийн удирдлагын үйлчилгээний чанарыг сайжруулж, сангийн өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн түвшинд өрсөлдөөнтэй үйлчилгээ үзүүлэх нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, зах зээлийн тогтвортой байдлыг хангана.

6.2. Нээлттэй зах зээл

ХОМК-уудын үйл ажиллагаа нь зах зээлийг илүү нээлттэй, хүртээмжтэй болгоход чиглэгддэг. Даатгалын болон хувийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг мэргэжлийн байгууллагуудаар удирдуулах нь зах зээлд ил тод байдал, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоог нэмэгдүүлнэ.

Олон улсын туршлага:

Сингапур болон Хонконг зэрэг орнууд мэргэжлийн хөрөнгийн удирдлагаар дамжуулан нээлттэй, хүртээмжтэй зах зээл бүрдүүлж, дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчдыг идэвхтэй оролцоход уриалсан. Энэ нь хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийн үр ашгийг сайжруулдаг.

Ач холбогдол:

- Нээлттэй зах зээл нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Ил тод байдал, хүртээмжтэй байдал нь зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, сангийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

2024 он 11 сар 19 өдөр

Дугаар 2024/6293

Улаанбаатар хот

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА**

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.ТАЙШИР

АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС ХХК-ИАС ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Манай Ардын Тэтгэврийн Данс ХХК нь 2007 онд үүсгэн байгуулагдсан ба хувийн тэтгэврийн хуримтлалын үйлчилгээг 17 жилийн турш иргэд, байгууллагын ажиллагсдад үзүүлсэн туршлагатай компани юм. Өдгөө бид 140 мянга гаруй иргэд, харилцагчдын хувийн тэтгэврийн хуримтлалын дансыг удирдан ажиллаж байгаа ба Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь манай компанийн эрх зүйн байдал, үйл ажиллагаа, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн талаар зохицуулсан нэн чухал ач холбогдол бүхий хуулийн төсөл юм.

Иймд тус хуулиар зохицуулах үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлж буй компанийн хувьд хуулийн төсөлд дараах саналуудыг хүргүүлж буйг хүлээн авна уу.

I. ТУЗ-ийн гишүүнтэй холбоотой:

Санал №1: Хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-дэх заалтыг “Энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүний төлөөлөл удирдах зөвлөлийн гуравны нэгээс доошгүй хувь байх бөгөөд олонхын саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгоно” гэсэн хэсгийг хасах.

Үндэслэл: Удирдах зөвлөлд гишүүдийн төлөөллийг сонгон оруулах нь зөв ч олонхын саналаар сонгохдоо аль гишүүдийн олонхын саналыг үндэслэн, ямар процессоор сонгох нь тодорхойгүй байна. Тухайлбал, манай компанийн хувьд 140,000 гаруй харилцагчтай тул санал хураалт явуулж сонгох нь хүндрэлтэй юм.

Санал №2: Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан “сар бүр тооцож” гэсэн хэсгийг хасах.

Үндэслэл: Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгалын компани нь хөрөнгө оруулалтын өгөөжийг сар бүр буюу богино хугацаанд гаргах боломжгүй, хөрөнгө оруулалтын өгөөж нь урт хугацаанд буюу дор хаяж нэг жилийн хугацаанд бодогдож, зөрүүг олгож байх нь зөв гэж үзэж байна.

II. Тусгай зөвшөөрөл авах, нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүртгүүлэхтэй холбоотой:

Санал №1: Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэгч ХТС-ийн тоо хэмжээнд хязгаарлалт тавих

Үндэслэл: Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хувийн нэмэлт



тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлснээр иргэд, байгууллагаас урт хугацаанд мөнгө татан төвлөрүүлж байгаа учраас хэт олон хувийн нэмэлт тэтгэвэр хөтөлбөр хэрэгжүүлэгч гарч ирснээс үүсэх аливаа эрсдэлээс сэргийлж /жишээ нь 2008 оны эдийн засгийн их хямралын үеэр олон тооны ХТС-д дампуурсан статистик байдаг/ ХТС-ийн тоо хэмжээг хөдөлмөрийн насны хүн амын тоонд үндэслэн, тодорхой хүн амд 1 ХТС ногдож байхаар зохицуулалт хийх, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэгчийн тоон хязгаарыг СЗХ-оос гаргаж байх зохицуулалт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Санал №2: Хуулийн 14.5 дахь хэсэгт заасан 45 хоногийг 30 хоног болгох

Үндэслэл: ХТС-ийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 45 хоногийн дотор нэмэлт баримт бичиг шаардаж, ажлын 60 хоногт шийдвэрлэхээр заасан ба нийт ажлын 105 хоног буюу ойролцоогоор 5 сарын хугацаанд тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэж болохоор байна. Шилжилтийн үеийн зохицуулалтад энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээд 1 жилийн дотор хуульд нийцүүлэн үйл ажиллагаагаа өөрчлөхөөр заасан ба тус хугацааг харгалзан, нэмэлт материал шаардах хугацааг ажлын 30 хоног болгох боломжтой байна.

Санал №3: Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүртгүүлэх хүсэлтээ тусгай зөвшөөрлийн өргөдөлтэй хамт гаргаж болох заалт нэмэх.

Үндэслэл: Тусгай зөвшөөрөл хүсэгч нь тусгай зөвшөөрлийн хүсэлтдээ хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлогыг хавсаргах, 18.1.1 дэх заалтаас харахад тусгай зөвшөөрлөө авсны дараа нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүртгүүлэх хүсэлтийг гаргах ойлголт үүсгэж байгааг ойлгомжтой болгох шаардлагатай байна.

Санал №4: Хуулийн 18.1.3-д заасан “эрх залгамжлагч, өвлөгчтэй байгуулах нэмэлт тэтгэврийн гэрээний загвар, бусад баримт бичгийн загвар” гэсэн хэсгийг хасах

Үндэслэл: Иргэний хуулийн дагуу хууль ёсны өвлөгчид нь өвлөгдөнө. Эрх залгамжлагч, өвлөгч нэмэлт тэтгэврийн хөрөнгийг өвлөхдөө нэг удаагийн эсхүл өөрийн нэмэлт тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлж авах боломжтой ба тус харилцааг хүсэлтийн дагуу шийдвэрлэх боломжтой. ХТС, урт хугацааны даатгагч нь эрх залгамжлагч, өвлөгчтэй гэрээ байгуулах шаардлага үүсэхгүй.

3.1. Урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэврийн хөтөлбөр эрхлэхтэй холбоотой:

Санал: Хуулийн 17.1 дэх заалтыг “Урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхэлж болно. Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр эрхлэх урт хугацааны даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 12 дугаар зүйлийн 12.4-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шаардлагыг хангасан байна” гэж өөрчлөх.

Үндэслэл: ХТС нь зөвхөн хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр санал болгох үйл

ажиллагаа эрхлэх ба үүнтэй адил үйл ажиллагаа эрхлэх буюу хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр санал болгож байгаа урт хугацааны даатгалын компанид мөн адил хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг адил байлгах шаардлагатай.

III. Хөрөнгө оруулалттай холбоотой:

Санал №1: Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг энэ хуулийн 26.1.1, 26.1.2-т заасан хөрөнгийн ангилалд Хорооноос тогтоосон дээд хязгаарт багтаан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хөрөнгө оруулж итгэмжлэн удирдаж болно” гэсэн хэсгийг хасах.

Үндэслэл: ХТС, урт хугацааны даатгагч нь тусгай зөвшөөрөл авсны дараа кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээ байгуулахаар заасан ба гишүүдийн нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн тусгай зөвшөөрөлтэй компаниар удирдуулах нь зөв юм. Харин тус заалтаас ХТС, урт хугацааны даатгагч хөрөнгийг удирдаж болохоор харагдаж байгаа тул хасах саналтай байна.

Санал №2: Хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтад “кастодиан, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд тухайн ажил олгогчийн холбогдох этгээд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл холбогдох этгээд биш байх” гэсэн хэсгийг хасах

Үндэслэл: Компанийн хувьд хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодиантай гэрээ байгуулна. Харин ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан этгээдийн хөрөнгийг тэдгээрийн холбогдох этгээд биш байгууллагаар удирдуулахын тулд өөр хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээ байгуулж удирдуулах нь Монгол Улсын нөхцөл байдалд хэтэрхий хязгаарлагдмал юм.

IV. Мэдээллийн сантай холбоотой заалт:

Санал: Хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэгт “Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн мэдээллийн сангийн нууцлалыг хадгалах ба зөвхөн эрх бүхий байгууллага, гишүүн, хадгалагдсан эрх үүссэн эрх залгамжлагч, өвлөгч нэвтрэх эрхтэй байна гэсэн заалтаас “эрх бүхий байгууллага, эрх залгамжлагч, өвлөгч” гэсэн хэсгийг хасаж, 44.5 дахь заалтыг “Эрх бүхий байгууллага нь зөвхөн хяналт тавих, шалгалт хийх, гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн гомдлыг барагдуулах зорилгоор мэдээллийн сангаас баримт гаргуулан авах эрхтэй” болгох.

Үндэслэл: Эрх бүхий байгууллага нь хяналт шалгалтын хүрээнд мэдээллийн сангаас мэдээлэл гаргуулах, баримт шаардах эрхийг олгох нь үндэслэлтэй. Харин тухайн мэдээллийн санд нэвтрэх, ашиглах эрхийг эрх бүхий байгууллагад олгосон байгаа нь Хүний хувийн мэдээллийн тухай хуулийг зөрчихөөр байна.

Мөн мэдээллийн санд гишүүн л нэвтрэх боломжтой байх нь зөв ба эрх залгамжлагч, өвлөгч нэвтэрч, тэтгэврийн дансны үлдэгдлийг харах боломжтой байх нь хуулийн 38.4-д заасан гишүүний амь насыг хохироосон, аливаа санхүүгийн залилах үйлдэл гарах нөхцөлийг бий болгохоор байна.

V. Ажил олгогчийн төлөөгүй нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн шимтгэлийг төлүүлэхтэй холбоотой заалт:

Санал: Хуулийн 45 дугаар зүйлийн 45.11-т “Ажил олгогч төлөөгүй шимтгэлийг төлсөн буюу ХТС-д шилжүүлсэн өдрөөс хойш аливаа өгөөж бодогдоно” гэж нэмэх.

Үндэслэл: Хуульд ажил олгогч шимтгэлийг төлөөгүй бол ажил олгогчийн эсрэг шимтгэлийг Төв банкны бодлогын хүүгээр нэмэгдүүлэн шаардах эрхийг хуульчилсан ба ажил олгогч хугацаандаа шимтгэлийг шилжүүлээгүй бол шилжүүлснээс хойш өгөөж тооцох зохицуулалт ороогүй байгаа тул нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

VI. Шилжилтийн үеийн зохицуулалт:

Санал №1: Шилжилтийн үеийн зохицуулалтад “хууль батлагдахаас өмнө энэ төрлийн үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдтэй хугацаатай гэрээ байгуулсан харилцагчийн гэрээний үйлчлэл нь тус гэрээний хугацаа дуустал хүчин төгөлдөр үргэлжлэх” заалт нэмэх.

Үндэслэл: Хууль батлагдахаас өмнө гэрээ байгуулж, хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдсан харилцагч нь харилцан тохиролцож, Иргэний хуулийн дагуу тодорхой хугацаатай гэрээ байгуулсан тул энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч нь тус гишүүдийн гэрээг шууд хугацаагүй болгох, эсхүл энэ хуульд нийцүүлэн гэрээг өөрчлөх шаардлага тавих боломжгүй тул өмнө гэрээ байгуулсан байсан харилцагчдын хувьд тус гэрээний хугацаа нь дуустал шинэ хуулийн дагуу гэрээг шинэчлэхгүй үргэлжлүүлэх саналтай байна.

Санал №2: Хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтын ард “Хороо нь тус хугацаанд шаардагдах дүрэм, журмыг батлаагүй тохиолдолд 50.2-т заасан хугацаа нь Хороо дүрэм, журмыг батлах хугацаанаас хэтрүүлсэн хугацаагаар хойшилно.” гэж нэмэх

Үндэслэл: ХТС нь үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэхийн тулд Хорооноос дүрэм журам нь бүрэн гарсан байх шаардлагатай ба Хорооны дүрэм, журам хугацаандаа батлагдаагүй бол 1 жилийн дотор хуульд үйл ажиллагаа нийцүүлэх нь хүндрэлтэй юм.

Санал №3: 2023 оны 7 сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болно.” гэж заасан ба манай компанийн хувьд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч биш иргэд хувийн тэтгэврийн данс нээлгэн, хамрагдсан

байдаг. Иймд тус зөрүүтэй асуудлыг шилжилтийн үеийн зохицуулалтад оруулан, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль батлагдахаас өмнө хамрагдсан иргэдэд төрийн нийгмийн даатгалд даатгуулсан байх шаардлага тавихгүй байхаар зохицуулалт оруулах байдлаар шийдвэрлэж өгнө үү.

VII. Дагасан хуулиудтай холбоотой санал:

Зөрчлийн тухай хуулийн 11.36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн танилцуулгад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа өөрчлөлт оруулсан, эсхүл хуулийг зөрчиж эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй танилцуулгыг нийтэд танилцуулсан бол зөрчилд тооцохоор заасан ба “танилцуулгыг бүртгүүлэх” шаардлага хуулиар тавигдаагүй тул тус хэсгийн найруулгыг засварлах.

Мөн зөрчлийн тухай хуулийн тус зүйлийн 4 дэх хэсэгт “Хуульд заасан мэдээлэл, мэдэгдлийг зохих журмын дагуу холбогдох этгээдэд гаргаж өгөөгүй бол” зөрчилд тооцохоор заасан ба ямар этгээдээс шаардсан, ямар төрлийн мэдээлэл, мэдэгдэл болохыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна.

---oOo---



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИ

Д.Сүхбаатарын талбай 3, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 31 05 01, 31 37 47, Факс: (976-11) 32 51 70,
Цахим шуудан: info@mse.mn, Цахим хуудас: www.mse.mn

2024.12.12 № 01/929
танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМАНД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн зүгээс “Хувийн
нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл”-д тусгах
саналаа хавсралтаар хүргүүлж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОГТБАЯР

1501660602

05/01/2025



ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛАХ САНАЛ

№	Хуулийн төслийн заалт	Санал		Үндэслэл, тайлбар
1.	8.4 дэх заалт	Өөрчлөн найруулах	“8.4 Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх нийт шимтгэлийн 50-иас доошгүй хувийг ажил олгогч, үлдэх хэсгийг ажилтан төлнө” гэсний 50-иас доошгүй хувийг гэснийг ажил олгогч ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоох эрхийг нь өгөх	Хувийн тэтгэврийн сан нь сайн дурын үндсэн дээр нэмэлт даатгал учир ажил олгогч ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах хөшүүрэг хөтөлбөр болгон шимтгэлийн хувь хэмжээг ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоох
2.	9.4 дэх заалт	Хасах	“9.4 Баталгаат өгөөжийн жилийн доод хэмжээ нь Төв банк /Монголбанк/-ны бодлогын хүүгээс багагүй байна”	Баталгаат өгөөжийн жилийн доод хэмжээг тогтоохдоо Төв банк /Монголбанк/-ны бодлогын хүүгээс хөрөнгө оруулалтын зардлыг хассан хувь хэмжээгээр эсвэл Засгийн газрын урт хугацаат бондын өгөөжийн хувь хэмжээгээр (зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан жил тутам тохируулдаг байх) тогтоох. Олон улсын жишигт баталгаат өгөөжийн хэмжээг төв банкны бодлогын хүү, Засгийн газрын урт хугацаат бондын өгөөж, зах зээлийн индексүүдийн жигнэсэн дундаж хувь хэмжээ эсвэл зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн дундаж өгөөжийн хувь хэмжээтэй уялдуулан тогтоож байна.
3.	Нэмэлтээр		Баталгаат өгөөжийн гүйцэтгэлийг хангах үүднээс заавал байлгах нөөц сан эсвэл даатгалын	Зах зээлийн уналтын үед алдагдал хүлээх эрсдэлтэй тул нэмэлт тэтгэврийн сангийн тогтвортой үйл ажиллагааг

			зохицуулалтыг нэмж тусгах	хангах үүднээс заавал байлгах нөөцийг тогтоох нь зүйтэй. Тухайлбал, ХБНГУ-д заавал байлгах нөөцийн зохицуулалттай байдаг бөгөөд үүний зарим хэсгийг улсын төсөвийн татаасаар бүрдүүлдэг байна. Чили улсад сангийн алдагдлыг нөөц сан эсвэл даатгалын механизмаар нөхөх зохицуулалттай байдаг.
4.	27.1 дэх заалт	Өөрчлөн найруулах	“27.1 Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь дараах этгээдийн гаргасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хориглоно” гэснийг “Хязгаарлана” гэж өөрчилж, Хорооны журмаар хязгаарлалтын хэмжээг нарийвчлан тогтоох	Хувийн тэтгэврийн санг томоохон ААН-үүдтэй холбоотой этгээд үүсгэн байгуулж, хувь нийлүүлсэн тохиолдолд эдгээр томоохон ААН-үүдийн гаргаж буй, харьцангуй эрсдэл багатай санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах боломжгүй болсноор сангийн багц бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.